ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2015 ОНЫ АРАВДУГААР САР

Лиахона

Онцлох өгүүлэл: Төлөвлөгөөг мэдэх нь ямар их итгэл найдвар өгдөг билээ! х. 32

Үзмэрч чулуунууд, Иосеф Смит, Мормоны Ном, х. 10

100 жилийн ойн мэнд хүргэе: Гэр бүлийн үдэш дэлхий даяар, х. 26

Порнографын асуудлыг дахин авч үзэх нь, х. 50

"Өөр сургаалт зүйрлэлээр -Тэнгэрийн хаанчлал бол гурван хэмжүүр гурилыг бүхэлд нь исгэхээр нэгэн эмэгтэйн хийсэн хөрөнгөтэй төстэй гэж Есүс хэлэв."

Матай 13:33

Лиахона, 2015 оны аравдугаар сар



4

ЗАХИАСУУД

4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Бамбараа асаалттай чигээр нь барианд ор
Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф

7 Айлчлагч багшийн захиас бичиг: Есүс Христийн тэнгэрлэг зан чанарууд: Энэрэл, хайраар дүүрэн

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

10 Үзмэрч Иосеф
Бага Ричард И.Төрли,
Робин С.Жэнсэн,
Марк Ашурст Макгий
Иосеф Смит үзмэрчийн хувьд үүргээ хэрхэн биелүүлж, Мормоны Номыг орчуулах боломжтой байсан бэ?

18 Бидний амьдралыг өөрчлөх үгс
Норман К.Хилл
Гана дахь нэгэн дүүргийн зөвлөлийн бичиг үсэг заах хөтөлбөр зарим гэгээнтний хувьд хэмжээлшгүй их адислал авчрав.

22 Өсвөр үеийнхэнд Аврагчийн арга барилаар хэрхэн удирдахыг заах нь
Кэрол Ф.Макконки
Өсвөр үеийнхэн Сүмийн ирээдүйн удирдагчид боловч өнөөдрөөс эхлэн удирдах туршлагатай болж болно.

26 Гэр бүлийн үдшийг тэмдэглэж байна
Гэр бүлийг хүчирхэгжүүлдэг энэ үйл ажиллагаанд дэлхий даяарх Сүмийн гишүүд хэрхэн оролцдогийг үзнэ үү.

32 Авралын төлөвлөгөө: Бидний зүг чигийг заагч ариун бөгөөд эрхэм нандин мэдлэг
Робэрт Д.Хэйлс
Мөнх бус байдлын өмнөх амьдрал дахь бидний амжилтын түлхүүр нь Эцэгийн төлөвлөгөөг дэмжих явдал байсан. Энэ нь мөнх бус амьдралд ч бидний амжилтын түлхүүр болдог.

АЛБАД

8 Сүмд үйлчлэх нь: Би хангалттай сайн хийж байгаа болов уу?
Брүк Бартон

9 Эргэцүүлэл: Хулуу юу, тарвас уу?
Рачел Кокс

40 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой

80 Биднийг дахин уулзтал: Аюулгүй газарт хүрэх зам
Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг

ХАВТСАН ДЭЭР
Хавтасны нүүрэн талын гэрэл зураг чимэглэлийг Коди Бэлл. Нүүрний дотор талын гэрэл зургийг: © StockFood/Talbott, Барбара. Арын хавтасны дотор талын гэрэл зургийг Тиффани Майлөн Тонг.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

44 Үнэн хүсэлтэй амьдрах нь
Рандалл Л.Ридд
Гаргаж буй шийдвэрийнхээ учир шалтгааныг эргэцүүлж нягтлах нь илүү зорилго чиглэлтэй амьдрахад тань туслах болно.

48 Итгэл ба үйлчлэл, мөн ганц талх
Ниссанка (Ниш) Муту Мудалигэ
Би номлогчидтой хамт явж заахыг хүсэж байсан ч тэдэн рүү яаж явж очихоо мэдэхгүй байлаа.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

50 Порнографын урхинаас мултрах нь
Ахлагч Даллин Х.Өүкс
Та нарыг сексийн утга агуулгатай хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зөв хандлагаар хандаж сурахад туслах таван зарчим

56 Зөв газар зөв цагтаа
Заримдаа та нар Их Эзэн өөрсдийг нь, эсвэл өөр хүмүүсийг ямар нэг шалтгаанаар илгээдэг гэдгийг мэддэг.

58 Зурагт хуудас: Таны амьдралын ном

59 Шат шатаар: Эхлэл 1:26–27

60 Үнэний эрэлд
Пен Хуа
Би бага байхаасаа Бурхан байдаггүй гэж заалгасаар ирсэн боловч үүнийг өөрөө олж мэдэхээр шийдсэн юм.

62 Судрууд дахь гайхамшигтай залуу эрэгтэй, эмэгтэйчүүд
Жизела Гутиер

64 Асуулт, хариултууд
Ээжийгээ өвчтэй байхад бид мацаг барьж, залбирсан ч ээж минь нас барсан юм. Бид үүнтэй хэрхэн эвлэрэх вэ?

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

66 Хожил авчирсан шийдвэр
Марисса Виддисон
Миранда хожиж буй багт тоглох боломжтой болов. Гэвч тэр ням гарагт тоглож болох уу?

68 Асуултын булан
Чи Сүмийн гишүүн байхын чухам юунд нь хамгийн их дуртай вэ?

69 Бидний хуудас

70 Судрын цаг: Петр, Корнел, тэнгэр элч
Эрин Сандэрсон

72 Тусламж авсан нь
Кимберли Рейд
Тэйт үзэх ёсгүй зүйлийг үзсэн ч эцэг, эхдээ хэлэхээс айж байв.

74 Үгүй байлгүй дээ! Одоо яах вэ?
Та муу гэж мэддэг зүйлээ харсан үедээ яах ёстой вэ?

75 Полын хулуу
Пол хэзээ нэгэн өдөр ахтайгаа адил номлолд явж чадна гэж бодож байсангүй.

79 Дуу хөгжим: Саяд нэг
Жан Пинбөрөү, Майкл Ф.Мүди

Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Зөвлөмж: Чи юу хийхээ мэдэхгүй үедээ хаанаас тусламж авч болох вэ?



2015 ОНЫ АРАВДУГААР САРЫН ДУГААР, 16, №5
ЛИАХОНА 12570 363
Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хэнри Б.Айринг, Дийтр Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн чуулга: Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс, М.Рассэлл Баллард, Ричард Г.Скотт, Робэрт Д.Хэйлс, Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күк, Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн

Эрхлэгч: Иосеф В.Ситати
Зөвлөхүүд: Рандалл К.Бэннэтт, Крэйг А.Кардон Кристоффэл Гоулдэн, Ларри Р.Лоурэнс, Жэймс Б.Мартино

Удирдах захирал: Дэвид Т.Варнэр
Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал: Винсэнт А.Ваун
Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг
Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон
Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр
Хэвлэлийн туслах: Мэган Вэрхөф
Редакцийн баг: Бриттани Бийти, Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фүллэр, Гаррэт Х.Гарфф, ЛаРин Портэр Гаунт, Жилл Хакин, Чарлотт Ларкэбэл, Минди Аннэ Лийвитт, Майкл Р.Моррис, Салли Жонсон Одэкөрк, Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороү, Ричард М.Ромни, Пол Вандэнбэрг, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер: Ж.Скотт Кнудсэн
Зураглал чимэглэлийн удирдагч: Тадд Р.Петрсон
Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрьюс, Фэй П.Андрус, Мэндэл М.Бэнтли, С.Кимбалл Ботт, Том Чайлд, Нэйт Гайнс, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан Лофгрэн, Скотт М.Моой, Марк В.Робисон, Брад Тиэри, П.Никол Вокэнорст
Оюуны өмчийн зохицуулагч: Коллэт Нэбэкэр Аун
Хэвлэлийн захирал: Жэйн Анн Пэтэрс
Хэвлэх баг: Конни Вауторп Бриж, Жюли Бардэтт, Кэти Данкан, Брайн В.Гайги, Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон, Гэйл Тэйт Раффэрти
Хэвлэлийн захирал: Крэйг К.Сэдвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсэн, Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт liahona.lds.org руу; шуудангаар *Liahona*, Rm. 2420, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин" буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын, свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити, тонга, украйн, унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2015 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувилан олшруулж болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн: cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada: October 2015 Vol. 16 No. 5. LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year (January, April, June, July, October, and December) by The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is $5.00 per year; Canada, $6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change of address. Include address label from a recent issue; old and new address *must* be included. Send USA and Canadian subscriptions to Salt Lake Distribution Center at address below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard, American Express) may be taken by phone. (Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 707.4.12.5). NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368, Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдшийн санаа

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглаж болох өгүүлэл, үйл ажиллагаануудыг оруулсан. Доор хоёр жишээ өгөгдсөн болно.



"Гэр бүлийн үдшийг тэмдэглэх нь" 26-р хуудас: Та долоо хоног алгасалгүй хийдэг, эсвэл анх удаа хийх гэж байгаа ч гэсэн гэр бүлийн үдшийн *ойд* зориулан онцгой гэр бүлийн үдэш хийх талаар бодож үзээрэй. Та уг өгүүллийг уншаад, дэлхий даяарх гэр бүлүүд хэрхэн сайн мэдээнээс суралцангаа цагийг хамтдаа зугаатай өнгөрөөдгийг харж болно. Гэр бүлийн үдэш хийх зорилгодоо хэрхэн хүрэх тухай ярилцах талаар бодож үзээрэй. Та гэр бүлийнхээ хэрэгцээ шаардлагад нийцүүлэхийн тулд үүнийг хэрхэн өөрчилж болох вэ? Та нөхцөл байдлаасаа үл хамааран, 100 жилийн түүхтэй энэ уламжлалыг гэр бүлийнхээ тэргүүн зорилго болгох амлалтыг дахин өгч болно.

"Тусламж авсан нь," 72-р хуудас: Уг өгүүллийг гэр бүлээрээ уншаад, дараах асуултын дагуу ярилцах талаар бодож үзээрэй: (1) Хүүхдүүд ямархуу төрлийн зураг юм уу үзвэр үйлчилгээг үзэж болзошгүй вэ? (2) Тэдгээрийг үзэж, анхаарлаа хандуулахад чухам аль нь бидэнд сайн биш нөлөө үзүүлэх вэ? (3) Хүн бүр үзэх, сонсох ёсгүй зүйлийг үзэж, сонсож болох нөхцөл байдалд орвол юу хийх вэ? Хэрэв танд (тухайн нөхцөл байдлаасаа салж холдох, эцэг эхтэйгээ ярилцах, үйлчлэл хийх гэх мэт) санаанууд хэрэгтэй бол 74-р хуудас дээрх "Үгүй байлгүй дээ! Одоо яах вэ?" өгүүлэл дээрх арга замуудын талаар ярилц.

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиахона болон Сүмийн бусад материалыг олон хэлээр languages.lds.org хаягаар орж үзэж болно. Гэр бүлийн үдшийн санаа, ням гаргийн хичээлийн тусламж, найзуудтайгаа болон гэр бүлтэйгээ хуваалцаж болох зүйлүүд зэргийг олж мэдэхийг хүсвэл **Facebook.com/liahona.magazine** хуудас руу орно уу (англи, португаль, испани хэл дээр үзэх боломжтой).

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

Авралын төлөвлөгөө, *32*
Ариун сүм, *55*
Бичиг үсгийн боловсрол, *18*
Бошиглогчид, *10, 80*
Гэр бүлийн үдэш, *26*
Гэрлэлт, *32*
Есүс Христ, *7*
Залбирал, *43, 64, 72*
Зөвлөлүүд, *18*
Илчлэлт, *80*
Иосеф Смит, *10*
Мормоны Ном, *10, 44*
Номлогчийн ажил, *44, 48, 60, 70*
Өрөвч сэтгэл, *50*
Өсвөр үеийнхэн, *22, 62*
Порнограф, *50, 72*
Сонгох эрх, *32*
Судрууд, *18, 59, 62*
Сүмийн гишүүнчлэл, *68*
Сүмийн дуудлагууд, *8*
Сүмийн түүх, *10*
Сүнслэг нөлөө, *40, 41, 42, 56*
Удирдлага, *22*
Үйлчлэл, *8, 56*
Үхэл, *64*
Хичээнгүй байдал, *4*
Хуучин Гэрээ, *59*
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, *50, 72, 74*
Хүндэтгэлийн өдөр, *66*
Хөрвөлт, *60*
Шийдвэрүүд, *9, 44, 58, 66*
Шинэ Гэрээ, *70*
Эн тэргүүнд тавих зүйлс, *9*
Энэрэл, *7*

Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф
Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх

БАМБАРАА АСААЛТТАЙ ЧИГЭЭР НЬ бариaнд ор

Эртний Грекийн гүйлтийн тамирчид *лампадэдромиа* хэмээх буухиа уралдаанд уралддаг байжээ.[1] Уралдааны үеэр гүйгчид гартаа бамбар барьж гүйгээд, дараагийн хүндээ дамжуулдаг байсан ба багийн сүүлийн гишүүн барианд ордог байв.

Уралдааны шагналыг хамгийн хурдан гүйсэн багт биш, харин бамбараа асаалттай чигээр барьж, барианд орсон эхний багт өгдөг байсан байна.

Энд ихээхэн сургамжтай зүйл байдаг бөгөөд үүнийг эрт эдүгээгийн бошиглогчид заасаар иржээ. Уралдааныг эхлүүлэх нь чухал ч, бамбараа асаалттай чигээр уралдааныг дуусгах нь илүү чухал юм.

Соломон эрч хүчтэй эхлүүлсэн

Агуу Соломон хаан уралдааныг эрч хүчтэй эхлүүлсэн хүний жишээ юм. Тэрээр залуу байхдаа "эцэг Давидынхаа тогтоолуудаар алхаж ЭЗЭНд хайртай байсан" (Хаадын дээд 3:3). Тэрээр Бурханы таалалд нийцсэн бөгөөд түүнд "Чи надаас юу авахыг хүсэж байгаагаа надаас гуйгтун" хэмээн хэлсэн байдаг (Хаадын дээд 3:5).

Соломон эд баялагтай болохыг, эсвэл урт удаан наслахыг гуйхын оронд "Таны ард түмнийг шүүн, сайн мууг ухааран ялгах чадварыг" гуйжээ (Хаадын дээд 3:9).

Их Эзэн үүнд нь баярлаж, Соломоныг мэргэн ухаанаар төдийгүй хэмжээлшгүй их эд баялгаар адисалж, урт нас хайрлажээ.

Соломон маш ухаантай, тун олон агуу зүйлийг хийсэн боловч тэр уралдааныг эрч хүчтэй дуусгаж чадаагүй юм. Харамсалтай нь, амьдралынхаа төгсгөл хэсэгт "Соломон ЭЗЭНий мэлмийн өмнө бузар муу зүйл үйлдэн, . . . ЭЗЭНийг гүйцэд дагасангүй" (Хаадын дээд 11:6).

Өөрсдийнхөө уралдааныг дуусгах нь

Эхлүүлсэн зүйлээ дуусгаагүй тохиолдол бидэнд хэр олон байдаг вэ? Хоолны дэглэм? Дасгал хөдөлгөөн? Судраас өдөр бүр унших амлалт? Есүс Христийн илүү сайн шавь байх шийдвэр?

Бид нэгдүгээр сард шинэ оны зорилго тавьсны дараа зорилгоо хэдэн өдөр, хэдэн долоо хоног, хэдэн сар урам зоригтой биелүүлж байснаа, аравдугаар сар гэхэд энэ урам зориг маань замхран алга болсон тохиолдол хэр олон байдаг вэ?

Нэгэн өдөр би урагдаж салбарсан цаасны дэргэд хэвтэж байгаа нохойны хөгжилтэй зургийг харсан юм. Тэр нь "Сургуультай нохойны гэрчилгээ" гэсэн бичигтэй цаас байв.

Бид заримдаа үүнтэй адилхан байдаг.

Бид сайн зорилго тавьж, эрч хүчтэй эхлэн, хамгийн сайнаараа байхыг хүсдэг. Гэтэл эцэстээ бид зорилгуудаа умартан, хөсөр хаядаг.

Амьдралд бүдэрч, бүтэлгүйтэн, заримдаа уралдааны замаас гарахыг хүсдэг нь хүний төрөлх чанар юм. Гэсэн хэдий ч, бид Есүс Христийн шавь нарын хувьд уралдааныг эхлүүлээд зогсохгүй, бамбараа асаалттай чигээр барианд орох амлалт өгсөн. Аврагч шавь нартаа "Харин эцсээ хүртэл тэвчсэн нь аврагдах болно" хэмээн амласан билээ (Матай 24:13).

ганц зам бол бууж өгөх явдал байдаг.

Бид унасан газраасаа босож, Аврагчийг чиглэн явж байгаа үедээ дүрэлзэн асаж буй бамбартайгаа уралдаанд түрүүлэх болно.

Бамбар нь биднийг болон бидний хийсэн зүйлийг дөвийлгөх зорилготой биш юм.

Энэ нь дэлхийн Аврагчийг алдаршуулдаг.

Энэ нь хэзээ ч үл бөхөлзөх Гэрэл юм. Энэ нь харанхуйг үлдэн хөөж, бидний шархыг эдгээн, хамгийн хэцүү уй гашуу тохиосон үед төдийгүй ёроолгүй харанхуйд ч дүрэлзэн асдаг Гэрэл билээ.

Энэ нь ухаан санаанд ч багтамгүй Гэрэл юм.

Бидний хүн нэг бүр эхлүүлсэн замаа дуусгах болтугай. Аврагч ба Гэтэлгэгч, Есүс Христийн тусламжтайгаар бид бамбараа асаалттай чигээр, баяр баясгалантай барианд орох болно. ■

Аврагчийн өнөө үед өгсөн амлалтыг: Хэрэв бид Түүний зарлигуудыг сахиж, бамбараа асаалттай чигээр барианд орвол Бурханы бүх бэлгээс хамгийн агуу нь болох мөнх амьдралтай болох болно хэмээн өөрийн үгээр илэрхийлэхийг минь зөвшөөрнө үү (С ба Г 14:7-г мөн 2 Нифай 31:20-ийг үзнэ үү).

Хэзээ ч бөхдөггүй гэрэл

Заримдаа бид бүдэрч, бүтэлгүйтэн, тэр ч байтугай бууж өгсний дараа сэтгэлээр унаж, гэрэл маань унтарсан мөн уралдаанд ялагдсан гэж боддог. Гэвч Христийн гэрэл бөхдөггүй гэдгийг би гэрчилж байна. Энэ нь түнэр харанхуйд ч гэрэлтдэг бөгөөд бид зүрх сэтгэлээ Түүн рүү эргүүлэх төдийд л зүрх сэтгэлийг маань дахин гэрэлтүүлж эхэлдэг юм (Хаадын дээд 8:58-ыг үзнэ үү).

Бидний хэдэн удаа эсвэл хэр хол унахаас үл хамааран Христийн гэрэл үргэлж хурц тод гэрэлтэж байдаг. Тэр байтугай хамгийн гүн харанхуйд ч бид Түүнийг чиглэн алхах юм бол Түүний гэрэл сүүдрийг хөөж, бидний бодгальд дахин асах болно.

Шавь байх энэхүү уралдаан ойрын зайн гүйлт бус, харин марафон гүйлт юм. Бидний хэр хурдан гүйж байгаа нь тийм ч чухал биш. Чухамдаа, уралдаанд ялагдах

ЭШЛЭЛ

1. *Harpers Dictionary of Classical Antiquities* (1898), "Lampadedromia," www.perseus.tufts.edu/hopper. Овог бүрээс нэг хүн оролцдог, гүйгч нь бамбараа дамжуулдаггүй өөр нэг гүйлтийн талаар Посаниас дурдсан байдаг. Гэсэн хэдий ч *лампадэдромиа* хэмээх уралдаанд бамбараа асаалттай чигээр барьж, барианд орсон эхний хүн ялагч болдог байжээ.

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Амьдрал хэмээх уралдааны чухам аль хэсэгт явж байгаагаа эргэцүүлэн бодоход заадаг хүмүүсээ урамшуулан дэмж. Тэдний бамбар дүрэлзэн асаж байна уу? Та Христийн гэрэл нь "харанхуйг арилган, бидний шархыг эдгээж, хамгийн хэцүү уй гашуу тохиосон үед төдийгүй, ёроолгүй харанхуйд ч дүрэлзэн асдаг Гэрэл билээ" гэсэн өгүүлбэрийг уншиж өгч болно. Христийн гэрэл амьдралд нь хэрхэн нөлөөлж байсан, одоо хэрхэн нөлөөлж байгааг заадаг хүмүүстэйгээ ярилцах талаар бодож үзээрэй.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ COMSTOCK/STOCKBYTE/THINKSTOCK

Бамбартаа тос нэм: 30 өдрийн аян

Сүмийн өсвөр үеийнхэн завгүй амьдралаасаа болоод сүнслэг зүйлүүдийн хувьд зогсонги хэв маягт орох нь амархан байдаг. Бид бараг л өдөр бүр нэгэн хэвийн байдлаар судраа уншиж, залбирч, шүтэн биширдэг бөгөөд яагаад сүнслэг хямралд орсноо гайхдаг.

Сүнслэг бамбараа илүү тод асаах хамгийн шилдэг аргуудын нэг нь ач холбогдол бүхий сүнслэг туршлагатай болох явдал юм. Гэхдээ энэ нь хэлэхэд амар ч хийхэд хэцүү. Тиймээс сүнслэг байдлаараа өсөхөд тань туслахын тулд энэхүү зөвлөгөөг өгч байна. Өмнө нь хэзээ ч хийж байгаагүй (эсвэл ховорхон хийдэг) сайн мэдээтэй холбоотой ямар нэг зүйлийн тухай бодоод, үүнийгээ нэг сарын турш хийхээр амла. Та нар жижиг зүйлээс эхлэж болно. Учир нь жижиг өөрчлөлтийг дадал хэвшил болгох нь илүү хялбар байдгийг та нар олж мэдэх болно. Сүнслэг байдлаараа өсөж, хөгжих зүйлийг хийж байх нь биднээс илүү их итгэл, хүчин чармайлт шаардаж магадгүй. Гэвч бид тэдгээрийг хийснээр Ариун Сүнсийг өөрсдөтэйгөө хамт байлгахаар урьж байдаг бөгөөд Тэнгэрлэг Эцэгт бүрэн итгэдгээ, мөн Түүнд илүү ойртох хүсэлтэй байгаагаа харуулдаг. Чамайг хийж эхлэхэд туслах хэдэн санааг харуулав:

- Өглөө, орой залбирах зорилго тавь. Чанга залбирахыг хичээгээрэй.
- 15 минутын өмнө босоод, сургуульд явахаасаа өмнө судраа унш.
- Өнгөрсөн Ерөнхий чуулгануудад дээр хэлсэн үгсийг унш.
- Мормоны Номон дээрээс нэг судар сонгоод, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хуваалц.
- Энгийн дуу хөгжмийн оронд дуулал юм уу Сүмийн дуу хөгжим сонс.

Бамбараа илүү хурц дүрэлзүүл

Олон жилийн тэртээ Грект нэгэн уралдаан болдог байсан ба гүйгчид нь асаалттай бамбар бариад гүйдэг байжээ. Уралдааны турш бамбараа асаалттай чигээр барьж гүйсэн хүн нь ялагч болдог байв. Амьдрал ийм уралдаантай адил гэж ерөнхийлөгч Угдорф хэлсэн. Бидний барьж явдаг бамбар бол Христийн гэрэл юм. Бид Есүс Христтэй адил байхыг хичээснээрээ өөрсдийнхөө бамбарыг илүү хурцаар дүрэлзэн асаадаг.

Энэ хөвгүүн Есүстэй адил болж, бамбараа илүү хурц дүрэлзүүлэхийн тулд хийж чадах зүйлсийг нь тойрог дотор өнгөөр ялган буд.

Энэ материалыг залбирч судлаад, хуваалцах зүйлээ олж мэдэхийг эрэлхийл. Аврагчийн тэнгэрлэг зан чанаруудыг ойлгох нь Түүнд итгэх итгэлийг тань хэрхэн нэмэгдүүлж, мөн айлчлагч багшийн хувьд харж ханддаг хүмүүсийн тань амьдралыг хэрхэн адисалж болох вэ? Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол reliefsociety.lds.org хаягаар орж үзнэ үү.

Есүс Христийн тэнгэрлэг зан чанарууд: Энэрэл, хайраар дүүрэн

Энэ бол Аврагчийн тэнгэрлэг зан чанаруудын талаарх Айлчлагч багшийн цуврал захиасуудын нэг хэсэг юм.

Судрын удирдамж дээр энэрлийг "хамгийн дээд, хамгийн эрхэм ариун, хамгийн хүчтэй хайр" хэмээн тодорхойлжээ ("Энэрэл"). Энэ бол Есүс Христийн цэвэр хайр. Бид Есүс Христийн талаар суралцаж, Түүнтэй адил болохыг хичээснээрээ өөрсдийнхөө амьдралд Түүний цэвэр хайрыг мэдэрч эхлэх бөгөөд Түүний адилаар бусдыг хайрлаж, үйлчлэхээр өдөөгдөх болно. Ерөнхийлөгч Томас С.Монсон "Энэрэл нь биднийг сэтгэлээр унагасан хүмүүст тэвчээртэй хандаж, амархан уурлаж, гомдох зүйлст биеэ барьдаг байхыг шаарддаг. Мөн сул дорой байдал, хүмүүний дутагдлыг ойлгож, хүмүүсийг байгаагаар нь хүлээн зөвшөөрөх явдал юм. Энэ нь хүмүүсийн гадаад төрхийг биш, харин цагийн уртад үл бүдгэрэх дотоод сэтгэлийг харж, бусдыг ялгаварлах сэтгэлийг эсэргүүцэхийг хэлдэг" хэмээн хэлжээ.[1]

ЗӨВ ШУДАРГА ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН НӨЛӨӨ, ЖЮЛИ РОЖЕРС

Бид Мормоны Номоос "та нар түүний Хүү, Есүс Христийн үнэн дагалдагчид бүгдийн дээр түүний цутгасан хайраар дүүргэгдэж болохын төлөө; [бид] Бурханы хөвгүүд [ба охид] болж болохын тулд; тэрбээр хүрч ирэхэд бид түүнтэй адил байх болно, учир нь бид түүнийг байгаагаар нь харах болно гэсний учир, бидэнд энэ найдвар байж болохын тулд, түүний цэврийн адил бид цэвэр болгогдож болохын тулд зүрхнийхээ бүхий л эрч хүчээр Эцэгт хандан залбирагтун" (Моронай 7:48) хэмээх агуу үнэнийг мэдэж авдаг.

Нэмэлт судрууд

Иохан 13:34–35; 1 Коринт 13:1–13; 1 Нифай 11:21–23; Ифер 12:33–34

ЭШЛЭЛҮҮД

1. Ерөнхийлөгч Томас С.Монсон, "Энэрэл хэзээ ч дуусдаггүй," *Лиахона,* 2010 оны 11-р сар, 124.
2. *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 119–120.
3. *Daughters in My Kingdom,* 87.

Үүнийг эргэцүүлэн бод

Христ бидэнд хайр, энэрлийн төгс жишээг хэрхэн үзүүлдэг вэ?

Итгэл, гэр бүл, халамж

Бидний түүхээс

"Саяхан бэлэвсэрсэн нэгэн эгч өөртэй нь хамт гашуудаж, өөрийг нь тайтгаруулсан айлчлагч багш нартаа талархаж явдаг. Тэр: 'Надад ярилцах хэн нэгэн хэрэгтэй байсан. Намайг сонсох хүн хэрэгтэй байсан. . . . Тэд намайг сонссон. Тэд намайг тайтгаруулсан. Тэд мөн надтай хамт уйлсан. Тэд намайг тэвэрч, . . . ганцаардлын эхний хэдэн сарын гүн уй гашуу, сэтгэл санааны зовлонг даван туулахад надад тусалсан юм' гэж бичжээ.

"Өөр нэг эмэгтэй айлчлагч багшаасаа жинхэнэ энэрэл хүлээн авсан мэдрэмжээ товчхон дүрслэхдээ: 'Би гишүүнчлэлийн жагсаалт дээрх тооноос илүү чухал учраас тэр над дээр айлчилж ирсэн гэдгийг би мэдсэн. Тэр надад санаа тавьж байгааг би мэдсэн.'"[2]

Эдгээр эгчтэй адил, дэлхий даяар амьдарч буй олон хожмын үеийн гэгээнтэн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч Боид К.Пакэрийн (1924–2015) хэлсэн дараах үгсийн үнэнийг баталж чадна: "[Аливаа гэр бүл] хаашаа ч явсан бай, Сүмийн өөр нэг гэр бүл тэднийг хүлээж байгаа гэдгийг мэдэх нь ямар их тайвшралыг өгдөг гээч. Тэд ирсэн өдрөөсөө л эрэгтэй нь санваарын чуулгад, эмэгтэй нь Халамжийн нийгэмлэгт харьяалагдах болно."[3]

БИ ХАНГАЛТТАЙ САЙН ХИЙЖ БАЙГАА БОЛОВ УУ?

Брүк Бартон

Алдагдсан хонины талаарх зүйрлэл дуудлагаа хэрхэн хамгийн сайнаараа биелүүлэхийг ойлгоход надад тусалсан.

Би 23-тай байхдаа, гэрлэсэн оюутны тойргийн Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчөөр дуудагдсан юм. Би өөрийгөө голж байснаа, бас чадах бүхнээ хийх хүсэлтэй байснаа санаж байна. Би үйлчлэхийг тэсэн ядан хүлээж, сэтгэл хөдөлж байсан ч өөрийнхөө сайн удирдагч байх чадвартай эсэхэд эргэлзэж байлаа.

Би Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчөөр хэдэн сар үйлчилснийхээ дараа хангалттай сайн үйлчлэхгүй байгаа мэт санагдаж байв. Би эгч нартай холбоотой байж, тэдний хувийн хэрэгцээг ойлгодог байхыг хүссэн боловч надад чадвар дутагдаж байлаа.

Би бишоптойгоо ярилцаж, санааг минь зовоож буй зүйлээ хэлэв. Би бүх эгчдээ хүрч үйлчилж чадахгүй байгаагаа хэлсэн юм. Би өөрийгөө тав хуваагаад, өөрийнхөө хүссэнээр ажлаа сайн хийхийг маш их хүсэж байгаагаа хэлж билээ. Би энэ бүхнийг хүндрүүлэлгүй, наргиан маягаар хэлэхийг хичээсэн боловч удалгүй нүдийг минь нулимс бүрхэв. Тэр инээмсэглээд, удирдагч байх талаар миний авч байсан хамгийн сайн зөвлөгөөнүүдийн нэгийг өгсөн юм.

Тэр "Сүргээсээ нэг хонь алдаад, ерэн есөн хонио орхиод алдагдсан нэгийг олохоор явдаг хоньчны түүхийг мэдэх үү?" гэж асуув (Лук 15:4–7-г үзнэ үү). Би толгой дохилоо.

"Энэ сургаалт зүйрлэлээс сурах зүйл маш их байдаг" гэж тэр хэлэв. "Хоньчин алдагдсан нэг хонио хайхаар явах хооронд ерэн ес нь аюулгүй байх болно гэдгийг мэдэж байсан."

Тэгээд бишоп маань дараах зөвлөгөөг өгсөн юм:

"Эзэн нь байхгүй хойгуур ерэн есөн хонь нэг нэгнээ харж хандаад байж чадна. Тэд нэг нэгнээ дэмжиж, хамтдаа сайн байх болно. Алдагдсан хүмүүстээ анхаарлаа төвлөрүүлэхийг би чамд зөвлөж байна. Үлдсэн хүмүүс ЗҮГЭЭР байх болно" гэлээ.

Түүний надад хэлсэн зүйл үнэн байсан бөгөөд бухэл сүрэгт санаа тавих хэрэггүй гэсэн мэдрэмж надад төрсөн юм. Миний зорилго бол алдагдсан хүмүүсийг олоод, хороонд буцааж урих явдал байлаа. Ингэснээр Тэнгэрлэг Эцэгийн зорилгууд хэрэгжиж, би Түүний мутар дахь зэмсэг болж чадна.

Би бишопынхоо зөвлөгөөг дагаснаар Их Эзэн намайг Өөрийн хаант улсад хэрхэн үйлчлээсэй гэж хүсдгийг илүү сайн ойлгох болсон юм. Түүнчлэн би Аврагчийн заавarласны дагуу үйлчилж байсан учраас намайг дуудлагад минь хүчирхэгжүүлсэн сүнслэг хүчийг хүлээн авсан билээ. Бишоп маань Ариун Сүнсний хүчээр надад ойлгох бэлэг өгсөн юм.

Биднийг залбирч, санваарын удирдагчдаасаа сүнслэг өдөөлт эрэлхийлэх үед тэд хэрхэн зөв шударга арга замуудаар удирдахыг бидэнд заах болно. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ MIKE BOYLAND/ISTOCK/THINKSTOCK AND OLEKSIY FEDOROV/HEMERA/THINKSTOCK

ХУЛУУ ЮУ, ТАРВАС УУ?

Рачел Кокс

Зарим үед буруу сонголт гэж байдаггүй. Зүгээр л сонголт байдаг.

Аав өнгөрсөн жилийн тарьсан хулууны үр нь энэ зун тарвас тарьсан газар соёолохыг хараад нэлээн гайхсан юм. Тарвас хажууг даган сайн ургаж байсан боловч хулуу ч бас ургаж байлаа. Тэгээд аав минь хулууны ургамлыг ургуулахаар шийдсэн юм. Гэсэн ч, энэ нь тарвас ургахад саад болохыг тэр мэдэж байв.

Тиймээс тэр сонголт хийх хэрэгтэй болов. Тэрээр хулуугаа сугалж аваад, тарвасаа ургуулах, эсвэл хулуугаа зөнгөөр нь ургуулаад, тарвасаа үхүүлэхийн алийг нь ч сонгож болох байв. Эдгээрийн аль нь ч үр дүн багатай байв. Хулуу юу, тарвас уу? Энэ нь хоёр сайн зүйлийн аль нэгийг сонгох тухай байлаа.

Хооронд нь харьцуулж байгаад аав минь хулууны ургамлыг сугалж авахаар шийдэв. Тэд оройтож соёолсон учраас хожуу ургасан хулуунаас *төлөвлөсөн* тарвасаа сонгосон нь дээр гэж үзсэн юм.

Энэ явдал нь намайг хийдэг сонголтуудынхаа талаар бодоход, ялангуяа бусадтай хэрхэн харилцах тухай бодоход хүргэсэн. Гэр бүл, найзууд эсвэл бидний болзож, гэрлэсэн хүмүүсийн аль нь ч бай, хоёр сайн зүйлээс сонголт хийж, зөв эсвэл хамгийн сайн зүйлийг сонгоход заримдаа хэцүү байдаг. Буруу сонголт хийчихвий гэсэн айдас нь заримдаа биднийг сонголт хийх чадваргүй болгодог бөгөөд энэ айдас нь итгэлтэйгээр урагшлахад саад болдог. Гэвч үнэн хэрэгтээ зарим үед *буруу* сонголт гэж байдаггүй. Зүгээр л сонголт байдаг. Аав минь өөрийнхөө хувьд *үнэ цэнэтэй* гэгдсэн зүйл дээрээ үндэслэн, шийдвэр гаргасан. Тэр хулуугаа үхүүлэхийг хүсээгүй ч тэдгээр нь тарвасанд хохирол учруулахыг хараад харамсах болно гэдгээ мэдэж байсан.

Амьдрал дээр зарим сонголт тийм ч чухал биш байдаг. Жишээлбэл: Би өглөө юу идэх вэ? Би өнөөдөр ямар өнгийн даашинз өмсөх вэ? гэх мэт. Бид хоёр сайн зүйлийн хооронд сонголт хийх хэрэгтэй болсон үедээ миний аав шиг "Надад аль нь илүү үнэ цэнэтэй вэ?" гэж өөрсдөөсөө асууж болох юм. Тэгээд шийдвэр гаргаад, итгэлтэйгээр урагшилж, хэрэв бид алдаа гаргасан бол Их Эзэн тусална гэдэгт итгэх хэрэгтэй.

Гэвч зарим сонголт *маш* чухал байдаг. Ерөнхийлөгч Томас С.Монсон нэгэн удаа: "Бидний өмнө сонголтууд үргэлж гарч ирсээр байдаг. Тэдгээрийг зөв хийхэд бидэнд зориг хэрэгтэй болдог. "Үгүй гэж, мөн "Тийм" гэж хэлэх зориг. Сонголтууд маань үнэхээр бидний хувь тавиланг *тодорхойлдог*" хэмээн хэлсэн ("Гурван сонголт," *2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 71). Ийм төрлийн сонголт хийх хэрэгтэй үед асууж болох илүү сайн асуулт бол "*Их Эзэн* алийг нь илүү үнэ цэнэтэйд тооцдог вэ?" гэсэн асуулт юм. Хэрэв бид энэ асуултын хариултыг мэдэж байвал өөрсдийн хүслийг Түүнийхтэй нийцүүлсний дараа уг сонголтоо хийх нь зүйтэй. Энэ нь үргэлж зөв сонголт байх болно. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЭРОЛИН ВИББЕРТ

Үзмэрч Иосеф

Иосеф Смит үзмэрчийн хувьд хэрхэн үүргээ биелүүлж, Мормоны Номыг орчуулсныг түүхэн бичээсүүд тодруулж өгдөг.

Бага Ричард Э.Төрли, Сүмийн туслах түүхч ба бүртгэгч,
Робин С.Жэнсэн ба Марк Ашурст Магий, Сүмийн түүхийн алба

1830 оны 4-р сарын 6-нд Иосеф Смит Христийн Сүмийг (хожим нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм болсон) зохион байгуулсан[1] бөгөөд цугласан хүмүүст хандаж илчлэлтээр ирсэн үгсийг тунхаглажээ. "Болгоогтун, та нарын дунд цэдэг хөтлөгдөх болно; мөн . . . үүнд чи [Иосеф Смит] үзмэрч . . . хэмээн дуудагдах болно" (С ба Г 21:1).

Шинээр зохион байгуулагдсан Сүмд Иосеф Смитийн үзмэрч байсны хамгийн илэрхий тэмдэг бол Мормоны Ном байсан бөгөөд энэ нь "Бурханы бэлэг ба хүчээр" орчуулагдсан гэж тэрээр олонтоо тайлбарладаг байжээ.[2] Иосефын ойр дотны хүмүүс Сүмийг зохион байгуулагдахаас нэг жилийн өмнө Мормоны Номын ирсэн үйл явцыг харж мөн *үзмэрч* гэдэг үгийн талаар зарим нэг ойлголттой болсон байв.

Үзмэрч гэдэг үгийн утга

Үзмэрч гэдэг нь залуу бошиглогч ба түүний үед амьдарч байсан хүмүүсийн хувьд ямар утгатай байсан бэ? Иосеф Библи уншдаг гэр бүлд өссөн бөгөөд үүнд үзмэрч гэдэг үг олон гардаг. Жишээ нь: 1 Самуел дээр "Урьд Израильд хэн нэгэн хүн Бурханы хүслийг асуухаар очихдоо "Үзмэрчид очъё" гэдэг байжээ. Одоогийн эш үзүүлэгчийг урьдын цагт үзмэрч гэдэг байв" гэж бичигдсэн байдаг (1 Самуел 9:9).

Хүмүүс саваа,[3] шургааг ороосон гуулин могой (анагаахын салбарын бэлгэ тэмдэг болсон),[4] ефод (энэ нь санваартны өмсгөлийн нэг хэсэг бөгөөд хоёр чулуутай байсан), [5] Урим ба Туммим[6] зэргийг ашиглан сүнслэг илэрхийллүүдийг хүлээн авдаг байсан тухай Библид дурдсан байдаг.

JOSEPH SMITH, ATTRIBUTED TO DAVID ROGERS, COURTESY OF COMMUNITY OF CHRIST LIBRARY-ARCHIVES, INDEPENDENCE, MISSOURI

СҮМИЙН ТҮҮХИЙН НОМЫН САНГИЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

Иосеф Смит, түүний эхнэр Эмма Хэйл Смит хоёр Мормоны Номын орчуулгын үеэр энэ байшингийн нэг давхарт амьдарч байжээ. Баруун гар талд харагдаж буй хоёр давхрын хэсгийг дараа нь нэмж барьжээ.

Иосеф Смит амьд ахуй цагтаа мянга мянган хүнд, нас барснаасаа хойш сая сая хүнд бошиглогч, үзмэрч, илчлэгч хэмээн нэрлэгдсээр ирсэн.

"Үзэгдэл үзэх" ба "үзмэрч" гэсэн ойлголтууд нь Америкийн болоод Иосеф Смитийн өссөн гэр бүлийн соёлын нэг хэсэг байжээ. Библид агуулагддаг ба европын дүрвэгсдээр дамжин хойд Америкт ирсэн соёлоос үүдэн 19-р зууны эхээр зарим хүн онцгой бэлэг бүхий хүмүүсийг "үзэгдэл үзэх" эсвэл сүнслэг үзэгдлүүдийг үзмэрч чулуу гэх мэт биет зүйлүүдээр дамжин хүлээн авах боломжтой гэдэгт итгэдэг байв.[7]

Залуу Иосеф Смит тухайн үеийн иймэрхүү итгэл үнэмшлийг хүлээн зөвшөөрч, үзмэрч нь алдагдсан эсвэл нуугдсан зүйлүүдийг чулуугаар дамжуулан харж болно гэдэгт итгэдэг байв. Бурхан хүмүүсийн итгэлийг нэг зүйлд төвлөрүүлэхийн тулд, эсвэл эрт үед сүнслэг зүйлүүдийг ойлгуулахын тулд биет зүйлс ашигладаг байсан тухай Библид дурдагдсан байдаг учраас Иосеф болон бусад хүн ийм зүйлд итгэж байв. Иосефын эцэг Ахмад Иосеф Смит, эх Люси Мак Смит хоёр тэдний гэр бүл энэ соёлыг хүлээн зөвшөөрч, биет зүйлсийг ашигладаг байсныг баталсан юм. Мөн Смитийн гэр бүл амьдарч байсан Нью Йоркийн Палмирагийн болон Манчестер тосгоны хүмүүс алдагдсан эд зүйлсийг олохын тулд Иосефыг 1827 оны сүүлээр Пеннсильвани руу нүүхээс нь өмнө эрж хайж байжээ.[8]

19-р зууны үед Иосефын нутагт амьдарч байсан хүмүүсийн шүтлэг бишрэлийн талаар ойлголтгүй хүмүүсийн хувьд үзмэрч чулуу нь танил бус бөгөөд эрдэмтэд түүний амьдралын энэ цаг үеийн талаар маргалдсаар ирсэн. Соён гэгээрүүлэгчдийн буюу оюун ухааны гэгдэх шинжлэх ухааны болон дэлхий дээрх нээлтүүдийг сүнслэг зүйлүүдээс илүүд үзэж байсан эрин үеийн нөлөөнөөс болж Иосефын үед амьдарч байсан олон хүн чулуу эсвэл саваа гэх мэт биет зүйлсийг мухар сүсэг эсвэл шашны зориулалтаар ашиглахад зохимжгүй хэмээн үзэх болсон байна.

Хожим нь Иосеф өөрийн гайхамшигт түүхийг ярихдаа үзэгдэл ба сүнслэг тохиолдлуудаа онцолсон юм.[9] Нөгөө талаас, хуучны танилууд нь үзмэрч чулуу ашигласных нь төлөө түүний нэр хүндийг унагаахыг оролдож байв. Иосеф ба эхэн үеийн гишүүд номлох ажлаа хийж байхдаа энэ уламжлалыг ашиглахад төдийлөн анхаарал хандуулаагүй юм. Учир нь оюун ухааны хөгжлийн үеийн хөрвөгч болох олон хүн Учир шалтгааны эрин үе дэх шашны талаар шинэ ойлголттой болж байв. Гэсэн хэдий ч, албан ёсны илчлэлтүүдэд Иосеф үзмэрч чулуу ба бусад хэрэгсэл, мөн эдгээрийг ашиглах чадвар нь чухал бөгөөд Бурханаас ирсэн ариун нандин, чухал бэлэг хэмээн заасаар байсан юм.[10]

Мормоны Номыг орчуулахад ашиглагдсан хэрэгслүүд

Иосеф Смит ба Мормоны Номын орчуулгыг дүрсэлсэн түүхэн бичээсүүдэд үзмэрч чулууны тухай гардаг. 1838 онд албан ёсоор эхэлсэн Иосефын түүхэнд Моронай хэмээх тэнгэр элчийн тухай гардаг бөгөөд тэрээр ойролцоох гүвээнд булаастай алтан ялтсуудын тухай хэлжээ. Иосефыг тэнгэр элчтэй ярилцаж байх зуур түүний оюунд "үзэгдэл нээгдэн," тэнд очихдоо уг газрыг танихуйц маш илэрхий бас тодорхойгоор харж чадсан гэж хэлсэн байдаг (Иосеф Смит—Түүх 1:42).

1838 оноос эхтэй Иосефын түүхэнд Моронай түүнд "надад сануулга болгон нэмж, (эцгийн минь гэр бүлийн ядуу тарчиг амьдралын үр дагавраас болж) ялтсуудыг баяжих зорилгын тулд эзэмшүүлэхээр Сатан намайг уруу татахыг хичээх болно гэдгийг хэлэв." Тэнгэр элч түүнд Бурханы хаант улсыг байгуулахаас "өөр ямар нэгэн шалтгаан" байвал "тэдгээрийг авч чадахгүй" гэж хэлсэн хэмээн Иосеф хэлжээ (Иосеф Смит—Түүх 1:46). Иосеф 1832 оны түүхэндээ тайлбарлахдаа "Би баяжих зорилгоор ялтсуудыг авахаар эрэлхийлж, Бурханы алдар суугийн төлөө бүхнээ зориулах ёстой гэсэн зарлигийг сахиагүй"[11] гэжээ. Үүний үр дүнд, тэрээр хүлээн авахад бэлэн болох хүртлээ дөрвөн жилийн турш жил бүр уг газарт ирэх ёстой болсон юм (Иосеф Смит—Түүх 1:53–54-ийг үзнэ үү).

JOSEPH SMITH, ATTRIBUTED TO DAVID ROGERS, COURTESY OF COMMUNITY OF CHRIST LIBRARY-ARCHIVES, INDEPENDENCE, MISSOURI

Иосеф 1827 онд Моронайгаас ялтсуудыг авахдаа тэдгээрийг орчуулахад ашиглах хоёр чулуу хүлээн авсан гэж хэлжээ. Иосеф болон түүний дотны хүмүүс эдгээр чулууг цагаан эсвэл тунгалаг харагддаг, орчин үеийн нүдний шилтэй адил хүрээнд суулгагдсан бөгөөд том чээжний хуягтай холбогдсон байсан гэж бичсэн байв.[12] Уг дүрслэлээс үзэхэд энэхүү үзмэрч хэрэгсэл нь нэлээд овортой байжээ. Иосеф чулуунуудыг ашиглахад илүү хялбар байлгахын тулд чээжний хуягаас нь салгасан гэж түүний ээж хэлж байжээ.[13]

Мормоны Номонд эдгээр чулууг “хөрвүүлэгч” гэж нэрлэдэг ба тэдгээр нь “эхлэлээс бэлтгэгдсэн ажээ, мөн хэлнүүдийг хөрвүүлэх зорилгын учир үеэс үед гардуулагдсан байв,” мөн “Их Эзэний мутраар хамгаалагдаж мөн хадгалагдан үлдсэн” (Мозая 28:14–15, 20) гэж тайлбарладаг.

Уг номонд Их Эзэн Жаредын ахад “хоёр чулуу” өгсөн тухай гардаг ба эдгээр нь түүний үгийг авчрахад ирээдүйн үеийнхэнд туслах болно гэдэг амлалтыг өгсөн байна. “Эдгээр зүйлийг бичигтүн мөн тэдгээрийг лацдагтун; мөн би тэдгээрийг өөрийн зохих цагт хүмүүний үрст үзүүлэх болно.” “Чиний бичих эдгээр зүйлүүдийг хүмүүсийн нүдэнд эдгээр чулуунууд тодруулахаар болгоно” (Ифер 3:24, 27) хэмээн Их Эзэн тайлбарласан.

1829 оны дундуур Иосеф Смит Мормоны Номын орчуулгыг бичээчид хэлж бичүүлж дуусгаад байх үед *үзмэрч* гэдэг үгийн утга илүү тодорхой болжээ. Мормоны Номонд Египетийн Иосефын үр удмын нэг нь буюу Иосеф Смит “сонгогдсон үзмэрч” байх бөгөөд бусад үр удмыг Бурханы эцэг өвгөдтэй нь хийсэн “гэрээнүүдийн мэдлэгт” авчрах болно гэсэн бошиглол байдаг (2 Нифай 3:6, 7).

Мормоны Номын өөр нэгэн хэсэгт залуу Алма хөрвүүлэгчдийг өөрийн хүү Хиламанд өгсөн. Алма мөнгөн нуман дахь хоёр чулууны талаар ярихдаа түүнд “эдгээр хөрвүүлэгчдийг хадгалан үлдээ” хэмээн зөвлөсөн байдаг. Гэвч Алма нэг чулууны талаар дурдсан бас нэгэн бошиглолыг “Мөн Их Эзэн хэлсэн нь: . . . би өөрийн зарц Газелемд, харанхуйг гэрлээр гийгүүлэх чулууг бэлтгэн өгөх болно” хэмээн эш татсан (Алма 37:21, 23).


Lehies dream of the [illegible]
[illegible] and i behold that the fruit thereof [illegible]
to exceed all the whiteness that i had ever seen and as
i partook of the fruit thereof it filled my soul with ex-
ceding great joy wherefore i began to be desirous that my [illegible]
should partake of it also for i knew that it was desirous
Above all other fruit and as i cast my eyes round [illegible]
[illegible] that perhaps i might discover my family also
and i beheld a river of water and it ran along and it [illegible]
[illegible] near the tree of which i was partaking the fruit and
looked to behold [illegible]

Лихайн гэр бүл Иерусалимаас гарсныг өгүүлсэн, эдүгээ 1 Нифай 2-р бүлэг болох Мормоны Номын анхны гар бичмэлийн хуудас. Иосеф Смит Оливер Каудери нарын хэд хэдэн бичээчид Мормоны Номыг хэлж бичүүлжээ.

СҮМИЙН ТҮҮХИЙН НОМЫН САНГИЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ; ИЛҮҮ ОЙЛГОМЖТОЙ БОЛГОХ ГЭРЭЛ ЗУРАГ

Хэдийгээр энэ бошиглол нь “хөрвүүлэгчдийн” (олон тоон дээр) тухай өгүүлж байгаа боловч “харанхуйг гэрлээр гийгүүлэх чулууг бэлтгэн өгөх болно” гэсэнчлэн ирээдүйн үйлчлэгчид өгөх нэгэн “чулууны” (ганц тоон дээр) тухай өгүүлдэг.[14] Эхэн үеийн гэгээнтнүүд бошиглогдсон энэ үйлчлэгч Иосеф Смит байсан гэдэгт итгэдэг.[15]

Чухамдаа, Иосеф Смит Мормоны Номыг орчуулахдаа “хөрвүүлэгчид” гэж нэрлэгдсэн хоёр үзмэрч чулуунаас гадна наад зах нь бас нэг өөр чулуу ашигласан бөгөөд гэрэл хаахын тулд ихэвчлэн малгайн дотор хийдэг байсан гэдгийг түүхэн баримтууд харуулдаг. Иосеф Смитийн үед амьдарч байсан хүмүүсийн хэлснээр, тэрээр чулуун дээрх үгийг илүү сайн харахад үүнийг ашиглажээ.[16]

1833 он гэхэд Иосеф Смит болон түүний нөхөд тэнгэрлэг илчлэлт хүлээн авахад ашиглагддаг нифайчуудын хөрвүүлэгчдийг болоод ганц ширхэг үзмэрч чулууг Библид гардгаар “Урим ба Туммим” гэж нэрлэж эхэлсэн ажээ.[17] Энэ тодорхой бус хэллэг нь Мормоны Номыг орчуулсан үнэн зөв арга барилыг дахин тодруулах

ТЭНГЭР ЭЛЧ МОРОНАЙ ЯЛТСУУДЫГ ИОСЕФ СМИТЭД ӨГЧ БАЙГАА НЬ, К.К.А.КРИСТЭНСЭН

Сүмийн түүхийн туршид гишүүд Иосеф Смитийн алтан ялтсуудыг олж, орчуулсан түүхийг ойлгохыг хүсэж ирсэн. К.К.А.Кристэнсэний 1886 онд зурсан энэ зураг Иосеф Смит тэнгэр элч Моронайгаас алтан ялтсуудыг авч байгааг дүрслэн харуулдаг.

гэсэн оролдлогуудыг буддиулсан юм. Мартин Харрисын хэлснээр, Иосеф Мормоны Номын орчуулгын үеэр хөрвүүлэгчдээс гадна овор багатай болохоор нь үзмэрч чулуунуудынхаа нэгийг ашигладаг байжээ. Иосефыг орчуулгын зэмсгүүдээ сольсон тухай өөр бусад эх сурвалж баталдаг.[18]

Мормоны Ном хэвлэгдсэний дараа

1830 оны 3-р сард Мормоны Ном хэвлэгдсэний дараа Иосеф Смит болон түүний бичиг хэргийн ажилтнууд Библийн Иосеф Смитийн орчуулга хэмээн эдүгээ нэрлэгддэг Библийн Хаан Жэймсийн хувилбарын сүнсээр нөлөөлөгдсөн засвар дээр ажиллаж эхлэв.[19] Иосефын түүхэн баримтад дурдсанаар энэ орчуулгын ажилд нифайчуудын хөрвүүлэгчдийг ашиглах боломжгүй байжээ. Учир нь эдгээр нь түүнд байхаа больсон байв.

Иосефын түүхэнд "Бурханы мэргэн ухаанаар, тэдгээр нь миний гарт аюулгүй байдалд, гарт минь даалгасан тэдгээрийг биелүүлтэл үлдсэн юм. Тохиролцсоны дагуу, уг элч тэдгээрийг хүсэхэд би түүнд тэдгээрийг гардуулж өгсөн билээ; мөн тэрээр тэдгээрийг өөрийн мэдэлд энэ . . . өдрийг хүртэл байлгаж буй болой" (Иосеф Смит—Түүх 1:60) хэмээн тайлбарласан байдаг.

Ерөнхийлөгч Бригам Янг (1801–77) үүнийг "Иосеф орчуулгын ажлыг дуусгаад Урим ба Туммимыг ялтсуудтай хамт буцааж тавьсан" хэмээн тайлбарлажээ.[20]

Иосефт өөр үзмэрч чулуу байсан. Гэхдээ Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын, хожим Сүмийн түүхч байсан ахлагч Орсон Праттын (1811–1881) хэлснээр, энэ үед Иосефын сүнслэг ойлголт өндөр түвшинд хүрсэн байв. 1874 оны 6-р сарын 28-нд ерөнхийлөгч Бригам Янг болон өөр олон ерөнхий эрх мэдэлтэн оролцсон хурал дээр ахлагч Пратт Иосеф Смитийг "Шинэ Гэрээг орчуулж байхад" нь "олон удаа дэргэд" нь байсан гэж цуглаарагсдад хэлжээ. Орчуулгын үеэр хөрвүүлэх ямар ч зэмсэг олж хараагүй учраас тэрээр Иосефыг яагаад "Мормоны Номыг орчуулсан шигээ Урим ба Туммимыг ашиглахгүй байгаа юм бол" гэж бодож байв.

Ахлагч Пратт бошиглогчийн орчуулж байгааг ажиглаж байгаад, "Иосеф түүний бодлыг уншсан юм шиг түүн рүү харсан бөгөөд илчлэлтийн Сүнсэнд туршлагагүй байхад нь Их Эзэн өөрт нь Урим ба Туммимыг өгсөн, харин одоо бол тэр маш их ахисан ба Сүнс яаж ажилладгийг ойлгодог болсон учраас түүнд зэмсгийн дэмжлэг хэрэггүй болсон байв" хэмээн тайлбарлажээ.[21]

Бригам Янг хоёр жилийн дараа өөр хүмүүст үзмэрч чулуу хүлээн авах тухай үүнтэй төстэй бодлоо хуваалцсан байна. Тэрээр "Энэ чулууг олж авах хүсэл надад байхгүй" хэмээн хэлжээ.[22] Үзмэрч байхын тулд үзмэрч чулуу шаардлагагүй гэдгийг ойлгож байснаа Бригам энэ мэдэгдлээрээ илэрхийлдэг.

1831 оны 10-р сарын 25-нд Иосеф Смит Огайогийн Оранжид болсон чуулганд оролцжээ. Чуулганы үеэр түүний ах Хайрум "Мормоны Номын ирэх тухай хүн бүр өөрсдөө мэдэж авч болохын тулд уг мэдээллийг Иосеф өөрөө тэнд цугласан ахлагчдад хэлбэл хамгийн үр дүнтэй гэж бодсоноо" хэлсэн байна. Хурлын тэмдэглэлд бичигдсэнээр Иосеф "Мормоны Номын ирэх талаар бүх нарийн тодорхой зүйлүүдийг дэлхийд мэдүүлэх зорилго байгаагүй бөгөөд эдгээр зүйлийг ярих нь түүний хувьд шаардлагатай биш хэмээн хэлжээ."[23] Үзмэрчийн үүргэтээ дадлага туршлагатай болж, үзмэрч чулуу нь илчлэлт хүлээн авахад шаардлагатай биш гэдэгт итгэж эхэлсэн тэрээр хүмүүсийг уг номон дээр бус, харин яаж ирсэнд нь хэт их анхаарал хандуулах вий хэмээн санаа зовсон байж болох юм.

Мормоны Номын талаар Иосеф Смитийн хэлсэн хамгийн чухал зүйл нь тэрээр үүнийг "Бурханы бэлэг болон хүчээр" орчуулсан явдал юм.[24] Тэрээр Сүмийн

ОЙРОЛЦООГООР 1866 ОНЫ ГЭРЭЛ ЗУРАГ, СҮМИЙН ТҮҮХИЙН НОМЫН САНГИЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

Янгийн ах дүү нарын голд, Бригам Янгийн зүүн гар талд сууж байгаа Финеас Янг Мормоны Номын орчуулгад ашиглагдаж байсан үзмэрч чулууг Оливер Каудеригаас аваад, ах Бригам Янгдаа өгчээ.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ ВЕЛДЕН К.АНДЕРСЕН, БАГА РИЧАРД И.ТӨРЛИ

Зурган дээр харагдаж буй чулуу нь Иосеф Смиттэй болон Мормоны Номын орчуулгатай удаан хугацааны турш холбоотой байсаар иржээ. Мормоны Номыг орчуулах ажилд Иосеф Смитийн ашигласан чулууг ихэвчлэн шоколадны өнгөтэй зууван хэлбэртэй чулуу гэж хэлдэг байв. Энэ чулуу нь Иосеф Смитээс Оливер Каудерид, дараа нь Бригам Янг болон бусад хүнээр дамжин Сүмд ирсэн.

ҮЗМЭРЧ ЧУЛУУ ХААЧСАН БЭ?

Иосеф Смитийн түүхэнд өгүүлснээр, тэрээр Урим ба Туммим буюу нифайчуудын "хөрвүүлэгчдийг" тэнгэр элчид эргүүлэн өгчээ. Гэхдээ нөгөө нэг үзмэрч чулуу буюу Мормоны Номыг орчуулахад Иосефын хэрэглэж байсан чулуунууд хаачсан бэ?

Давид Витмер "1830 оны хаврын эхээр, 4-р сарын 6-наас өмнө Мормоны Номын орчуулга дууссаны дараа Иосеф уг чулууг Оливер Каудерид өгөөд, уг чулууг ашиглаж гүйцсэн гэдгээ надад болон бусад хүмүүст хэлсэн. Тэр чулууг дахин ашиглаагүй юм"[1] хэмээн бичжээ.

Оливер Сүмээс урваснаасаа хойш 10 жилийн дараа буюу 1848 онд дахин баптисм хүртэж, Юта дахь гэгээнтнүүдтэй хамт амьдрахаар явах гэж төлөвлөж байсан ч 1850 онд Миссурийн Ричмондод нас баржээ.[2] Оливер Каудериг Сүмд эргэж ирэхэд нь тусалсан Финеас Янг Оливерийн бэлэвсэн эхнэр болох Давид Витмерийн дүү, Элизабэт Эн Витмер Каудеригаас үзмэрч чулууг авсан. Финеас үүнийг Бригам Янг ахад өгчээ.[3]

"Иосефын эхний үзмэрч чулуу надад байгаа. Энэ нь надад Оливер Каудеригаас ирсэн" хэмээн ерөнхийлөгч Янг 1853 онд хэлсэн байдаг. Тэнд бас өөр хүмүүс байсан. "Иосефт байсан 3 чулуу Эммад байгаа. 2 жижиг, 1 том" хэмээн тэр нэмж хэлэв.[4] Хоёр жилийн дараа Бригам Янг цугласан Сүмийн удирдагчдад "Оливер Иосефын эхний үзмэрч чулууг надад өгсөн. Оливер үүнийг надад өгөх хүртлээ өөртөө хадгалж байсан" хэмээн хэлжээ.[5]

Бригам Янгийг нас барсны дараа түүний эхнэрүүдийн нэг, хожим Халамжийн нийгэмлэгийн гурав дахь ерөнхий ерөнхийлөгч болсон Зина Д.Х.Янг Мормоны Номыг орчуулахад Иосефын ашигласан чулуутай адил, бор өнгөтэй үзмэрч чулууг нөхрийнхөө эдлэн газраас олж аваад, Сүмд хандивлажээ.[6] Түүнээс хойш, үзмэрч чулуу Сүмийн эзэмшилд байгаа гэдгийг Сүмийн удирдагчид хэлж байв.[7]

ЭШЛЭЛҮҮД

1. Давид Витмер, *An Address to All Believers in Christ* (1887), 32.
2. Оливер Каудеригийн нас барахаасаа өмнө Сүмд эргэж ирсэн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Скотт Ф.Фалрингийн "The Return of Oliver Cowdery," in John W. Welch and Larry E. Morris, eds., *Oliver Cowdery: Scribe, Elder, Witness* (2006), 321–362-ыг үзнэ үү.
3. 1855 оны 9-р сарын 30-ны хурлын тэмдэглэл, Сүмийн түүхийн номын сан, Солт Лэйк хот; "Давид Витмер," *The Historical Record,* 1888 оны 10-р сар, 623; Maria L. Cowdery Johnson to David Whitmer, 1887 оны 1-р сарын 24, Community of Christ Library-Archives, Independence, Missouri; Франклин Д.Ричардсын тэмдэглэл, 1882 оны 3-р сарын 9, Сүмийн түүхийн номын сан.
4. Хурлын тэмдэглэл, 1853 оны 4-р сарын 17, Сүмийн түүхийн номын сан.
5. Хурлын тэмдэглэл, 1855 оны 9-р сарын 30, Сүмийн түүхийн номын сан.
6. Зина Янгаас Франклин Д.Ричардст, 1896 оны 7-р сарын 31, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн өдрийн тэмдэглэлийн түүх, 1896 оны 7-р сарын 31, 4, Сүмийн түүхийн номын сан.
7. Б.Х.Робэртс, *A Comprehensive History of the Church,* 6:230–231; Жозеф Фийлдинг Смит, *Doctrines of Salvation,* Брүс Р.Макконки эмхэтгэсэн, 3-р боть (1954–1956), 3:225; Брүс Р.Макконки, *Mormon Doctrine,* 2 дахь хэвлэл (1966), 818–819-ийг үзнэ үү.



СҮМИЙН ТҮҮХИЙН НОМЫН САНГИЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

Сүмээс эрхлэн гаргадаг* The Contributor *хэмээх сэтгүүл 1883 онд Мормоны Номын гурван гэрчийг онцолсон байна. Мормоны Номыг орчуулж мөн хэвлэхэд Иосеф Смитэд тусалсан энэ гурван хүний гүйцэтгэсэн үүргийг хожмын үеийн гэгээнтнүүд хүлээн зөвшөөрсөөр ирсэн.

удирдагчдад энэ ном нь өөрөө “энэ дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв нь, мөн манай шашны тулгуурын чулуу, түүнчлэн бусад ямар ч номноос илүүгээр, үүний заавРыг мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох болой”[25] хэмээн заажээ. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Сургаал ба Гэрээ 115-ыг үзнэ үү.
2. Preface to Book of Mormon, ca. Aug. 1829, in *Documents, Volume 1: July 1828–June 1831,* vol. 1 of the Documents series of *The Joseph Smith Papers* (2013), 93. Мөн Мормоны Номын “Гурван гэрчийн гэрчлэл”-ийг үзнэ үү.
3. Египетээс гарсан нь 4:1–5, 17, 20–21; 7:8–21; 8:16–19; 9:22–26; 10:12–15; 14:15–18; 17:1–13; Тооллого 17:1–10; 20:7–11; Еврей 9:4-ийг үзнэ үү.
4. Тооллого 21:7–9; Иохан 3:14–15-ыг үзнэ үү.
5. Египетээс гарсан нь 28:12; 35:9, 27; 1 Самуел 23:9–12; 30:7–8-ыг үзнэ үү.
6. Египетээс гарсан нь 28:30; Левит 8:8; Тооллого 27:21; Дэд хууль 33:8; 1 Самуел 28:6; Езра 2:63; Нехемиа 7:65-ыг үзнэ үү.
7. 19-р зууны шашны энэ соёлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл *Journals, Volume 1: 1832–1839,* vol. 1 of the Journals series of *The Joseph Smith Papers* (2008), xix; and *Revelations and Translations, Volume 3: Printer’s Manuscript of the Book of Mormon,* vol. 3 of the Revelations and Translations series of *The Joseph Smith Papers* (2015), xv–xvi; Даллин Х.Өүкс, “Recent Events Involving Church History and Forged Documents,” *Ensign,* 1987 оны 10-р сар, 68–69-ийг үзнэ үү.
8. Statement of Joseph Smith Sr., as quoted in Francis W. Kirkham, *A New Witness for Christ in America: The Book of Mormon,* vol. 2 (1959), 366; түүнчлэн Люси Мак Смит, “Lucy Mack Smith, History, 1844–1845,” book 3, х.10, josephsmithpapers.org/paperSummarylucy-mack-smith-history-1844-1845-ыг үзнэ үү. Мартин Харрис Иосефоор бухлан дотроос зүү олуулж, түүний чадварыг шалгаж байснаа дурссан байдаг (“Mormonism—No. II,” *Tiffany’s Monthly,* 1859 оны 7-р сар, 164-ийг үзнэ үү).
9. Жишээлбэл, Агуу Үнэт Сувд дахь Иосеф Смит—Түүх-ийг үзнэ үү.
10. Сургаал ба Гэрээ 130:10–11-ийг үзнэ үү. Эдүгээ Сургаал ба Гэрээ 8 буюу Мормоны Номыг орчуулах ажилд Иосеф Смитэд туслахыг хүсэх үед Оливер Каудерид өгөгдсөн хэсгийн хамгийн анхны хувилбарын үгсийг үзнэ үү (Revelation, Apr. 1829–B, in *Documents, Volume 1: July 1828–June 1831,* 44–47).
11. Joseph Smith, “History, ca. Summer 1832,” in *Histories, Volume 1: 1832–1844,* vol. 1 of the Histories series of *The Joseph Smith Papers* (2012), 14.
12. Иосеф Смит—Түүх 1:35; Иосеф Смит, “Church History,” in *Histories, Volume 1: 1832–1844,* 495; Мартин Харрис “Mormonism—No. II,” 165–66; “Lucy Mack Smith, History, 1844–1845,” book 5, хуудас 7–8, josephsmithpapers.org.
13. Тухайлбал, “Lucy Mack Smith, History, 1844–1845,” book 5, josephsmithpapers.org-ийг үзнэ үү.
14. Энэ ялгаа нь сурвалжлагчдад эргэлзээ төрүүлсэн нь ойлгомжтой. Жишээлбэл, Брүс Р.Макконки, *Mormon Doctrine,* 2nd ed. (1966), 307–8; Joseph Fielding McConkie and Robert L. Millet, *Doctrinal Commentary on the Book of Mormon,* 4 vols. (1987–92), 3:278; and Matthew B. Brown, *All Things Restored: Confirming the Authenticity of LDS Beliefs* (2000), 62-ыг үзнэ үү.
15. Иосеф Смит, Хайрум Смит нарын оршуулгын номлол, Виллям В.Фелпс, Сүмийн түүхийн номын сан, Солт Лэйк хот; Орсон Пратт, “Explanation of Substituted Names in the Covenants,” *The Seer,* 1854 оны 3-р сар, 229; Виллям В.Фелпс, letter to Brigham Young, 1854 оны 4-р сарын 10, in Brigham Young, Office Files, 1832–1878, Сүмийн түүхийн номын сан, Солт Лэйк хот. *Revelations and Translations, Volume 2: Published Revelations,* vol. 2 of the Revelations and Translations series of *The Joseph Smith Papers* (2011), 708–709.
16. Орчуулгын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл lds.org/topics/book-of-mormon-translation сайт дээрх “Book of Mormon Translation”-ийг үзнэ үү. Мөн Рассэлл М.Нэлсон, “A Treasured Testament,” *Ensign,* 1993 оны 7-р сар, 61–65; Нийл А.Максвэлл, “By the Gift and Power of God,” *Ensign,* 1997 оны 1-р сар, 36–41-ийг үзнэ үү .
17. Тухайлбал, Вилфорд Вүдрафф Наувуд харсан үзмэрч чулуугаа Урим ба Туммим гэжээ (Вилфорд Вүдраффын тэмдэглэл, 1841 оны 12-р сарын 27, Сүмийн түүхийн номын сан). Мөн *Revelations and Translations, Volume 3: Printer’s Manuscript of the Book of Mormon,* xix-ийг үзнэ үү.
18. *Revelations and Translations, Volume 3: Printer’s Manuscript of the Book of Mormon,* xviii–xix-ийг үзнэ үү.
19. Энэ ороолдлого хэрхэн эхэлсэн талаар товч мэдээлэл авахыг хүсвэл *Documents, Volume 1: July 1828–June 1831,* 150–152-ыг үзнэ үү.
20. Хурлын тэмдэглэл, 1853 оны 4-р сарын 17, Сүмийн түүхийн номын сан.
21. “Бригам хотод болсон хоёр өдрийн хурал, 1874 оны 6-р сарын 27, 28,” *Millennial Star,* 1874 оны 8-р сарын 11, 498–499.
22. Хурлын тэмдэглэл, 1855 оны 9-р сарын 30, Сүмийн түүхийн номын сан.
23. Хурлын тэмдэглэл, 1831 оны 10-р сарын 25, 26, in *Documents, Volume 2: July 1831–January 1833,* vol. 2 of the Documents series of *The Joseph Smith Papers* (2013), 84.
24. Мормоны Номын удиртгал хэсэг, ойролцоогоор 1829 оны 8-р сар, in *Documents, Volume 1: July 1828–June 1831,* 93. Мөн Мормоны Номын “Гурван гэрчийн гэрчлэл”-ийг үзнэ үү.
25. Иосеф Смит, Вилфорд Вүдраффын тэмдэглэлд, 1841 оны 11-р сарын 28, Сүмийн түүхийн номын сан; эсвэл Мормоны Номын удиртгал хэсэг.

БУРХАНЫ БЭЛЭГ БОЛОН ХҮЧЭЭР, СИМОН ДЮВЕЙ, ALTUS FINE ARTS КОМПАНИЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

ОРЧУУЛАХ ҮЙЛ ЯВЦЫГ ХАРУУЛЖ БАЙНА

Олон жилийн туршид уран бүтээлчид Мормоны Номын орчуулгын тухай үзүүлэхдээ үйл явцад нь оролцож байсан хүмүүсийг янз бүрийн нөхцөл байдлаар дүрслэн харуулахыг зорьсоор ирсэн. Уран бүтээл бүр нь уран бүтээлчийн өөрсдийнх нь үзэл бодол, судалгаа, төсөөлөл дээр тулгуурлагдсан, зарим үед бусад хүний санал бодлоос санаа авсан байдаг. Он жилүүдэд хүмүүсийн туурвисан зарим бүтээлийг харуулав.

ИОСЕФ СМИТ МОРМОНЫ НОМЫГ ОРЧУУЛЖ БАЙГАА НЬ, ДЭЛ ПАРСОН

Зураач Иосеф Смит, Оливер Каудери хоёрыг Мормоны Номын орчуулга дээр ажиллаж байгаагаар зуржээ. Энэ зургаас ялгаатай нь Оливер Каудери орчуулгын ажил дуусах хүртэл ялтсуудыг ***хараагүй*** *гэж өөрөө хэлсэн юм. Орчуулгын үеэр ялтсуудыг даавуугаар бүтээх зэргээр нүднээс халхалсан байсан гэдгийг энэ үйл явцын гэрчүүд хэлсэн байдаг.*

Энэ зураач Иосеф Смитийг ялтсуудыг судалж байгаагаар зуржээ. Иосеф ялтсууд дээрээс "нилээд олныг нь хуулбарлаж" авсан гэж хэлсэн байдаг. Түүнийг "Урим ба Туммимыг ашиглан," эдгээр бичгийг орчуулсны дараа Мартин Харрис орчуулгыг батлахын тулд бичгүүдийг Чарльз Антон болон өөр эрдэмтдэд үзүүлжээ (Иосеф Смит—Түүх 1:62–64).

Зураач Иосеф Смит орчуулж байхдаа чээжний хуягийг хожим нь Урим ба Туммим гэж нэрлэгдэх болсон хөрвүүлэгчид буюу шилтэй нь хамт зүүж байгаагаар зуржээ.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ РОБЭРТ Т.БАРРЭТТ

ЯЛТСУУДЫН ОРЧУУЛГА, ӨРЛ ЖОУНЗ, СҮМИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

Зураач Иосеф Смит, бичээч хоёрын хооронд хөнжил байгаагаар зуржээ. Хэдийгээр орчуулгын үйл явцыг дүрсэлж бичсэн зүйлүүдэд хөнжил дурдагдаагүй байдаг ч орчуулгын эхэн үед ялтсууд, нүдний шил, чээжний хуяг зэргийг бичээчээс далдлахын тулд хөнжил хэрэглэж байсан нь тодорхой байдаг. Орчуулгын ажлын сүүлчийн хэсэгт орчуулгын явцыг харах гэсэн сониуч хүмүүсээс орчуулагч, бичээч хоёрыг халхлахын тулд хөнжил ашигласан байж магадгүй юм.

БИДНИЙ амьдралыг ӨӨРЧЛӨХ ҮГС

Норман К.Хилл
Ганын Аккра баруун номлолын ерөнхийлөгч

Гана дахь нэгэн дүүргийн зөвлөл хамтдаа зөвлөлдөж, орон нутаг дахь нөөц бололцоогоо ашиглах нь хувийн өсөлт хөгжил, бусдад үйлчлэх боломжийг бий болгодгийг харуулав.

Ганын Вида Осэй эгч англиар унших, бичиж сурахыг хүсжээ. Тэрээр орон нутагтаа хэрэгждэг хөтөлбөрүүдийг турших үзсэн боловч шантран, хэдэн долоо хоноод л хөтөлбөрөөс гардаг байв. Нэг ням гарагт тэр хоёрдугаар салбарын цуглаанд оролцож байхдаа Асаманкэсэ дүүрэг англи хэлний сургалт явуулж байгааг олж мэджээ. Тэр боломжийг ашиглан, бүртгүүлээд үзэхээр шийдсэн байна.

Удалгүй тэрээр энэ хөтөлбөр бусдаас ялгаатай болохыг мэдэв. Тэрээр сүмийн найзуудтайгаа хамт сурах боломжтой болжээ. Судрууд сургалтын материалд ашиглагддаг учраас тэр англи хэл, сайн мэдээ хоёрыг нэг дор сурах болов.

Хичээл эхэлснээс хоёр сарын дараа Вида ангидаа анх удаа залбирч үзжээ. Гурван сарын дараа тэр анх удаа ариун ёслолын цуглаан дээр үг хэлсэн бөгөөд Африкийн нэг хэл болох тви хэлээр, бас англиар үг хэлжээ. Дөрвөн сарын дараа тэрээр оёдлын бизнесийнхээ захиалга, зарлага, үнэ ханшийг хуучирсан дэвтэрт бичиж эхэлсэн байна. Тэр үйлчлүүлэгчидтэйгээ харилцахдаа алдаа гаргах нь бага болж, материалаа хямд үнээр авдаг болж, мөн өмнөх сард олсноосоо илүү их мөнгө олжээ.

"Би хүмүүстэй хамт энэ хичээлд суухаас ичиж байсан" гэж тэр хэлэв. "Гэсэн хэдий ч бичиг үсэг заах анги цуглааны байранд хичээллэж, миний таньдаг гишүүд оролцож байсан нь надад урам зориг өгсөн. Одоо би судруудыг уншиж чадах төдийгүй англиар уншиж, бичиж байгаа учраас бизнес маань сайжирч байгаа.

Африкийн Саб-Сахарын орнуудад олон хүн, ялангуяа эмэгтэйчүүд уншиж, бичиж чаддаггүй. Бичиг үсэг тайлагдаагүй байдал өргөн тархсан учраас "ямар нэг зүйл нуухыг хүсвэл номон дотор бич" гэсэн Африкийн зүйр цэцэн үг хүртэл байдаг. Вида шиг хожмын үеийн гэгээнтэн эмэгтэйчүүдийн хувьд бичиг үсэгтэй болох боломж нээгдэж байна.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ТЭЙЛОР КАЛЛЭРИ

Хөтөлбөрийн оролцогчид ба гэр бүлийн гишүүд болон найзууд дүүргээс зохион байгуулсан бичиг үсэг заах хөтөлбөрийн төгсөлтийн баяраа тэмдэглэж байна.

Даван туулах ёстой саад бэрхшээл

Саб-Сахарын орнуудад дэд бүтэц тааруу, бүх нийтийн боловсрол хязгаарлагдмал байдгаас болж боломжууд хязгаарлагдмал байдаг. Ялангуяа охидын хувьд ийм байдаг. Сургуулийн төлбөр өндөр, охидын нийгэмд эзлэх байр суурь бага байдаг учраас уншиж сурах нь олон хүнд боломжгүй зүйл мэт санагддаг. Жишээ нь: Гана улсын албан ёсны хэл нь англи хэл боловч насанд хүрсэн эмэгтэйчүүдийн талаас бага хувь нь англиар ярьдаг гэсэн тоо баримт байдаг. Ганын хөдөө нутгуудад насанд хүрсэн эмэгтэйчүүдийн гуравны хоёр нь бичиг үсэгт тайлагдаагүй.

“Манай суурин, тосгодод амьдардаг насанд хүрсэн эмэгтэйчүүдийн ихэнх нь англиар ярьдаггүй” гэж Ганын Аккра баруун номлолын Абомосу дүүргийн ерөнхийлөгч Сет Оппонг хэлжээ. “Бидний төрөлх тви хэл олон зууны турш ярианы хэл байсаар ирсэн. Тви хэлний цагаан толгой саяхан бүтээгдсэн учраас цөөн хүн л уншиж чадна.”

“Эгч нар сайн мэдээний зарчим, Сүмийн бодлого журмыг ойлгохын тулд нөхрүүдээсээ, хэрэв гэрлээгүй бол найзуудаасаа тусламж авах ёстой болдог” гэж дүүргийн Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгч Жеоржина Амоака хэлжээ. “Олон хүн үйлчлэх их хүсэлтэй байдаг ч гарын авлага, сэтгүүлүүдийг уншиж чадахгүй учраас Сүм дэх тэдний оролцоо хязгаарлагдмал байдаг.”

Зөвлөлөөс өгсөн зөвлөгөө

Эмэгтэйчүүд гэртээ эсвэл зах дээр англиар ярьдаггүй учраас Сүмд тэдний оролцох оролцоо нь энэ хэлийг сурах гол хөшүүрэг болдог. Гэхдээ олон жил болсон гишүүд, шинэ хөрвөгчдийн гэр бүлийнхэн бичиг үсэг заах хөтөлбөрүүдийг эсэргүүцэх явдал гардаг. Дүүргийн зөвлөл үүний талаар ярилцаж, ерөнхийлөгч Оппонг дүүрэг даяар бичиг үсэг заах сургалтын талаар салбар бүрийн санваарын болон туслах бүлгүүдийн удирдагчдад хандан ярьжээ. Уг хөтөлбөр нь бүхий л эмэгтэйчүүдэд нээлттэй хэдий ч Сүм дэх эмэгтэйчүүд дээр төвлөрөх болно. Хувь хүмүүсийг тус тусад нь биш, бүлгээр нь уривал Халамжийн нийгэмлэг, Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл хамт хамрагдан мөн бие биенээ дэмжих болно.

Салбаруудтай ярилцсаны үндсэн дээр дүүргийн удирдлагууд бичиг үсэг заах ангиудыг салбар бүр дээр ням гарагт болон долоо хоногийн дундуур хоёр удаа явуулахаар шийджээ. Тэд зургаан сар шаргуу ажилласныхаа дараа, хичээлд тогтмол сууж, заавал хийх гэрийн даалгаврыг хийж дууссан хүмүүст төгссөн гэрчилгээ олгохоор болсон байна.

Нөөц бололцоогоо хэрэгцээ шаардлагадаа тохируулах нь

“Ярианы хэлтэй хүмүүст уншиж, бичихийг заах аргаа олоход бэрхшээлтэй байсан” гэж дүүрэгт үйлчилж байсан ахмад номлогч ахлагч Жим Далтон ярьжээ. “Тви хэл нь маш олон жилийн турш цагаан толгойгүй, ярианы хэл байсаар ирсэн учраас энэ хэлээр ярьдаг ихэнх хүн бичиж мэддэггүй. Тиймээс бид эхлээд яаж бичихийг заасан.

Абомосу дүүргийн Дээд зөвлөлийн гишүүн Рансфорд Дарква нь Францис Анса, Сисилиа Аманква нарын эргэж ирсэн номлогчдод орон нутагт хийгдсэн гарын авлагыг ашиглахад нь тусалжээ. Оролцогчдод зураг үзүүлж, дараа нь харсан зүйлээ бичихийг тэднээс хүссэн юм. Энэ нь англиар бодож сурч байсан тэдэнд анхан шатны бичих чадвартай болоход нь тусалсан байна. Үндсэн чадваруудыг эзэмшсэний дараа ахисан түвшний эх сурвалжуудыг ашиглах болно.

Бэлтгэл ба шинэ санаачлага

Хөтөлбөр эхлэхээс өмнө бичиг үсгийн мэргэжилтнүүд багш нарт суралцах арга барилыг заахаас гадна эрүүл ахуйн болон гэр бүлд хэрэг болох чадваруудыг хэрхэн заах талаар сургалт өгчээ. Хэдийгээр сургалт маш сайн байсан ч гэсэн зарим нэгэн бэрхшээлийг урьдчилан таамаглах боломжгүй байв. Ойр ойрхон цахилгаан тасардгаас болж оройн ээлжийн ангийн хичээлийг явуулахад хүндрэл учирч байлаа. Мөн танхай алтны уурхайчид орой үдэш гудамжаар явж байна гэсэн цуу яриа хүмүүсийн санааг зовоож, сүмийн байрны түлхүүртэй хүмүүс заримдаа цагтаа ирж сүмийн байрыг онгойлгож чаддаггүй байв.

Дүүргийн зөвлөл юу хийх хэрэгтэйгээ ярилцав. Тэдний өгсөн зөвлөгөөний дагуу хүмүүс бүлэг бүлгээрээ

ангид хамт ирж эхлэв. Тэдэнд явах замаа гэрэлтүүлэх гар чийдэн өгчээ. Цахилгаан үүсгүүр ашиглан, Сүмийн байрны гэрэлтүүлгийг асаахыг орон нутгийн удирдагчид зөвшөөрчээ. Байрнуудын ойролцоо амьдардаг, итгэл даах гишүүдэд байрны түлхүүрийг өгснөөр тэд байруудыг цагтаа онгойлгох боломжтой болов.

Төгсөлтийн үеэр хийсэн танилцуулга

Гишүүд, сонирхогчид нийлсэн жаран таван хүн хөтөлбөрийг эхлүүлжээ. Дөчин гурав нь бүх хичээлийг үзэж, гэрийн даалгавраа хийсэн байна. Төгсөлтийн үеэр тэднийг богино танилцуулга хийхэд урив.

"Бичиг үсэг заах хөтөлбөр эхлэхээс өмнө би огт уншиж чаддаггүй байсан" гэж Санкубэнасэ салбарын Сандра Обэнг Амо хэлэв. "Нөхрөө ажлаар хол явахад би хэзээ ч гэр бүлийн үдэш хийдэггүй байсан. Хэдэн долоо хоногийн өмнө нөхрийг маань байхгүй байхад том хүү минь надад гарын авлагаас уншихад тусалж, би хүүхдүүддээ англиар хичээл заав. Түүнээс хойш би нөхрөө байхгүй үед долоо хоног бүр хичээл заадаг болсон.

Англи хэл сайн мэдэхгүй боловч Абомосу хоёрдугаар салбарын итгэлтэй гишүүн хэвээр байгаа Проспэр Гаякэтэ өөрийн бичсэн гурван өгүүлбэр бүхий гэрчлэлээ уншсан юм. Тэр энэ ангид суухаасаа өмнө уншиж, бичиж чаддаггүй байсан бол одоо хүүхдүүддээ гэрийн даалгавраа хийхэд нь тусалж чаддаг болсон гэж хэллээ. "Би мэдсэн сурсан зүйлдээ талархалтай байгаа. Одоо би илүү сайн аав байж чадна" гэж тэр хэлэв.

"Одоо би судруудыг уншиж чадна" гэж Квабэнг салбарын Кваку Сасу хэллээ. "Өмнө нь би Мормоны Номыг уншиж чаддаггүй байсан ч гэсэн үнэн гэдгийг нь мэддэг байсан. Одоо би энэ номыг *уншиж* байхдаа үнэн гэдгийг нь мэддэг. Миний гэрчлэл улам бүр өсөж байгаа."

Асунафо салбарын Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд пүрэв гараг бүр нэг нэгэнтэйгээ зөвхөн англиар ярих цаг гаргажээ. "Тэр өдөр бид нэг нэгэндээ хэлэх оновчтой үгсээ олохгүй байсан учраас яриа минь сунжирдаг байсан" гэж Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгч Эвилин Агиеваа хэлэв. "Гэвч бид удалгүй нэг нэгэндээ орчуулж өгч, зөв үгнүүдээ олдог болсон. Бид хамтдаа суралцаж байсан учраас нэг ч хүн ичихгүй, буруу үг хэлэхээсээ айхгүй байсан. Бид зүгээр л бие биедээ тусалсан."

Ашиг тусаа бялхтал өгч байна

Абомосу дүүргийн бичиг үсэг заах хөтөлбөрийг дүүргэсэн эмэгтэйчүүд өөрсдөдөө илүү их итгэлтэй, сүмд үйлчлэх илүү их хүсэлтэй болжээ. Тэд дуудлага хүлээн авах, судраа унших, сүмд болон гэртээ заах илүү хүсэлтэй болсон юм. Түүнчлэн цөөн эрэгтэй уг хөтөлбөрийг дүүргэсэн байна. Газар тариалан эрхэлж амь зуудаг тэд ургацынхаа зардал, борлуулалтыг тооцох илүү чадвартай, мөн хүүхдүүдийнхээ гэрийн даалгаварт нь тусалж, хувиараа болон гэр бүлийнхэнтэйгээ хамт судруудаас уншиж чаддаг болжээ.

Абомосу дүүрэгт гарсан амжилтаас урам авсан зэргэлдээх Асаманкэсэ дүүрэг бичиг үсэг заах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэв.

"Уншиж, бичих чадвартай байх нь бидний болон хүүхдүүдийн маань амьдралыг өөрчилж байна" гэж Санкубэнасэ салбарын Гладис Асэду хэлжээ. "Энэ нь бидний амьдралыг өөрчилж байгаа бөгөөд бид Тэнгэр дэх Эцэгтээ талархаж байна." ■

СҮНСЛЭГЭЭР ӨДӨӨГДСӨН БИЕ ДААСАН БАЙДАЛ

"Сүмийн халамжийн хөтөлбөрийг нэг маягаар явуулах арга байхгүй. Энэ бол хувь хүмүүс өөрсдийнхөө бие даасан байдлыг хариуцах хөтөлбөр юм. Бидний эх сурвалжуудад хувийн залбирал, Бурханаас бидэнд өгсөн авьяас чадвар; гэр бүл, хамаатнуудаас авах боломжтой хөрөнгө, нийгмийн эх сурвалжууд, мөн санваарын чуулгын болон Халамжийн нийгэмлэгийн дэмжлэг зэрэг нь багтдаг. . . .

"Тэгээд та бүхэн бүх эрин үеийн Христийн дагалдагчдын нэгэн адил хамтдаа зөвлөлдөж, бүх л нөөц боломжоо ашиглан Ариун Сүнсний удирдамж ба Их Эзэний зөвшөөрлийг эрэлхийлж, ханцуй шамлан хөдөлмөрлөж эхлэх хэрэгтэй."

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, "Их Эзэний арга замаар хангах нь," *Лиахона,* 2011 оны 5-р сар, 53–56.

ДААВУУНЫ ГЭРЭЛ ЗУРГИЙГ AFRICANWAY/ISTOCK/THINKSTOCK



Кэрол Ф. Макконки
Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

АВРАГЧИЙН АРГА БАРИЛААР ХЭРХЭН УДИРДАХЫГ өсвөр үеийнхэнд заах нь

Өсвөр үеийнхэн маань зөвхөн ирээдүйн удирдагчид биш юм. Тэд өнөөдрийн удирдагчид. Аврагчийн арга барилаар удирдахад нь бид тэдэнд тусалж чадна.

Өсвөр үеийнхний эцэг эх, удирдагчдад хандан Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар бидний олох ёстой нарийн тэнцвэртэй байдлын тухай ярьсан юм: "Залуу хүмүүсийг үйлдэхэд нь урь. Та нар дэргэд нь байх хэрэгтэй ч замаас нь холдох хэрэгтэй. Та нар бүх зүйлийг удирдахгүйгээр зүг чигийг заах ёстой."[1]

Эцэг эхчүүд болон удирдагчид залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийг зөв шударга байдлаар удирдаж мөн дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулахад тэднийг бэлтгэх зарчмуудаас суралцахад нь тусалж чадна.

Би 14 настай байхдаа гайхалтай удирдах чадвартай залуу эмэгтэйчүүдтэй танилцсан. Тэр үед миний гэр бүл Нэгдсэн Улс дотроо нүүж, нэгэн шинэ тойргийн гишүүд болцгоосон байсан юм. Би тухайн үед Миа Мэйд ангийн ерөнхийлөгчийн зөвлөлд хэн үйлчилж байсныг одоо санадаггүй боловч залуу эмэгтэйчүүд надад найрсаг хандаж байсныг тод санадаг. Тэд шинээр ирсэн, айж эмээсэн, туранхай охиныг удаан уулзаагүй найз шигээ халуун дотно хүлээн авч билээ. Би Делавэрт байхдаа дунд сургуулийнхаа цорын ганц мормон охин байсан бөгөөд миний мэдэх цорын ганц энэ мормон охин манай гэрээс машинаар 1 цаг явж хүрэх зайд амьдардаг байсан. Тиймээс би дотроо *"Энэ* чинь л диваажин даа!" гэж бодож билээ.

Амьдралдаа анх удаа би *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь жишгүүдийн дагуу амьдардаг, намайг үйл ажиллагаанд урьдаг, сайн мэдээний талаарх гэрчлэлээ надтай хуваалцдаг найзуудтай болсон юм. Тэдний өгөөмөр хайрын жишээнүүд тухайн үедээ намайг ямар ч хэлсэн үгээс эсвэл хичээлээс илүүтэй Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд бат бөх үлдээж чадсан билээ. Тэд хайр ба Христийнхтэй адил гэрлээрээ дамжуулан Христийн сайн мэдээний элчүүд байж, Түүний сүрэгт намайг хөтлөн оруулсан хүмүүс байсан юм.

Чухам юу миний найзуудыг ийм агуу удирдагчид болгосон бэ?

Нэгэн залуу номлогч удирдлагын зарчмыг маш энгийн байдлаар тодорхойлсон. Тэр: "Бид Их Эзэний хүслийн дагуу үйлдэн, бидний тусламж хэрэгтэй байгаа хүнд тусалж, зөв газар зөв цагтаа байх хэрэгтэй. Энэ нь биднийг удирдагч болгодог" гэжээ.[2] Өөрсдийн мөн чанар, өөрсдийн дотор гэрэлтдэг Христийн гэрлээр дамжуулан Сүм даяарх итгэлтэй залуу эрэгтэй, эмэгтэйчүүд *Аврагчийн арга барилаар удирдаж,* "бусдыг Есүс Христийн жинхэнэ дагалдагчид болоходн нь туслах"[3] чадвартай байдаг.

Удирдагчдын хувьд бид залуу эрэгтэй, эмэгтэйчүүдээ удирдан, чиглүүлж, тэдний хажууд алхдаг. Гэхдээ ням гаргийн хичээлүүдийг сонгох, үйл ажиллагаануудыг төлөвлөх зэргээр анги, чуулгуудын ажлыг удирдаж, чиглүүлэх нь чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн үүрэг юм. Анги, чуулгын удирдагчид санваарын түлхүүр атгадаг хүмүүсийн удирдлаган дор дуудагдаж, онцгойлон адислагддаг. Тиймээс тэд бусад өсвөр үеийнхнийг

удирдаж, хүчирхэгжүүлэх эрх мэдэлтэй. Тэд Аврагчийн үлгэр жишээг даган, Түүн шиг үйлчилж, Түүн шиг тохинуулж сурдаг.

Өсвөр үеийнхэнд удирдах боломж олгох нь

Удирдах боломж гэр бүлээс эхэлдэг. "Эцэг эх ба удирдагч байхаар Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь гэртээ сайн мэдээний зарчмуудаар тогтмол, хичээнгүй амьдарч, үлгэр жишээгээр удирдахаас эхэлдэг" хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Робэрт Д.Хэйлс заасан. "Энэ нь өдөр бүр амлаж, хичээл зүтгэл гаргахыг шаарддаг."[4] Эцэг эхчүүд Христийн сургаалыг заадаг. Тэд өсвөр үеийнхнийг зорилго тавьж, биелүүлэхэд тусалдаг. Хувийн хөгжил дэвшил, Бурханы өмнө хүлээсэн үүрэг нь Есүс Христийн талаарх гэрчлэлээ хүчирхэгжүүлэх, ариун нандин гэрээнүүдийг хийж мөн сахихад бэлтгэх, тэнгэрлэг үүргээ гэр бүлдээ болон Сүм дээр биелүүлэхэд нь өсвөр үеийнхэнд тусалдаг.

Сүм дээр Аароны санваарын болон Залуу эмэгтэйчүүдийн удирдагчид чуулах, ангийн ерөнхийлөгчийн зөвлөлүүдэд үйлчилж буй өсвөр үеийнхэнд ариун нандин үүргүүдээ ойлгох, мөн чуулга, ангийн бусад гишүүнийг харж хандан, хүчирхэгжүүлэх дуудлагаа ойлгож, эрхэмлэн биелүүлэхэд тусалж чадна.

Насанд хүрсэн удирдагчдын хувьд бид өсвөр үеийнхнийг чуулга ба ангийн хурал, мючелийн үйл ажиллагаануудыг бэлтгэж мөн хөтлөхөд бэлтгэдэг. Өсвөр үеийнхнийг ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлууд дээр асуудал бэрхшээлтэйгээ тэмцэж байгаа хүмүүст туслах арга замуудыг тодорхойлон, бүх өсвөр үеийнхнийг ням гаргийн хичээлд хамруулах, үйл ажиллагаа, үйлчлэл, аялал, чуулгануудыг төлөвлөх үед нь бид тэдэнтэй уулздаг.

Бид өсвөр үеийнхний ерөнхийлөгчийн зөвлөлүүдийг чуулга, ангийн бүх гишүүндээ гишүүн номлогчийн ажил болон хөрвөгчид ба идэвх султай гишүүдийг идэвхжүүлэх, ариун сүм ба гэр бүлийн түүхийн ажил болон сайн мэдээг заах зэрэг авралын ажлын бүх хэсэгт оролцоход нь туслахад урамшуулдаг.[5] Өсвөр үеийнхний ерөнхийлөгчийн зөвлөлүүд бүх залуу эрэгтэй, эмэгтэйд Аврагчийн нэрээр үйлчилж, Түүний хоньдыг тэжээхийн баяр баясал, адислалыг мэдэж авахад тусалдаг.

Удирдагчийн ажилд сайхан тараах материал, баримт фактаар дүүрэн лекц тийм ч чухал биш. Удирдагчийн ажил нь залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийг Аврагчийн арга барилаар удирдахад нь *тэдэнд* туслах зарчмуудаас суралцаж, хэрэгжүүлэхэд тусалдаг. Доор дөрвөн зөвлөгөө өгөв.[6]

Сүнслэг байдлын хувьд бэлтгэ

Хувиараа сүнслэг байдлын хувьд бэлтгэхийн хүчийг ойлгоход нь өсвөр үеийнхэнд тусал. Ариун ёслолд хийдэг гэрээнүүддээ итгэх итгэлээ хөгжүүлэхийг тэдэнд заа. Христийн нэрийг өөрсөд дээрээ авах, Түүнийг дурсан санах, Түүний зарлигуудыг сахихад бэлэн байх нь тэдэнд Ариун Сүнсний нөхөрлөлтэй хамт байх боломж олгодог. Тэд Ариун Сүнсний өдөөлтүүдийг хүлээн авч, таньж мэдэн, тэдгээрийн дагуу үйлдэх боломжтой үедээ ганцаараа байдаггүй.

Тэд чин сэтгэлээсээ залбиран удирдамж эрэлхийлэх, судраас суралцан хариултуудаа хайх зэрэг арга замаар сүнслэг байдлаараа бэлтгэж байдаг. Тэд зарлигуудыг сахихыг хичээдэг. Ингэснээр Ариун Сүнс тэдний зүрх сэтгэл, оюунд ярьж, хэнд тэдний тусламж хэрэгтэй байгааг мөн юу хийж

ТОХИРОХ ХЭМЖЭЭНД НЬ УДИРДАМЖААР ХАНГАХ

Өсвөр үеийнхэн удирдахад суралцах үед тэдэнд өөр өөр хэмжээний дэмжлэг хэрэг болдог. Зарим нь өөрсдөө илүү ихийг хийж чадна. Бусдад нь илүү их удирдамж хэрэгтэй. Эцэг, эхчүүд хүүхдүүддээ удирдаж сурахад нь туслах үедээ хамтдаа зөвлөлдөж чадна. Залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд тойрог дахь өсвөр үеийнхэн бүрд хэр хэмжээний дэмжлэг үзүүлэхээ тодорхойлох үедээ хамтдаа болон бишопын зөвлөлтэй зөвлөлдөж болно. Зорилго: Залуу эрэгтэй, эмэгтэй бүрд, байгаа түвшингээс нь эхлэн туслах

чадахаа тэд мэдэх болно. Тэд анги эсвэл чуулгын гишүүн бүрийн төлөөх Христийн цэвэр хайрыг мэдрэх болно.

Сүнслэг бэлтгэл нь өсвөр үеийнхэнд Их Эзэний үйлчлэгчид гэдгийг нь, мөн Түүний ажлыг хийж байгаа гэдэгт итгэх итгэлийг өгнө (С ба Г 64:29-ийг үзнэ үү).

Зөвлөлд оролц

Өсвөр үеийнхнийг Их Эзэний Сүмийг удирддаг, мөн хувь хүн, гэр бүлүүдийг адисалдаг тэнгэрлэг үйл явц болох зөвлөлд оролцох үед зөвлөлийн үндсэн дэг журмыг болон илчлэлт авах хүчийг тэдэнд заа.[7] Бишопын залуучуудын хороо, чуулга, ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлууд нь өсвөр үеийнхэн үүргүүддээ суралцах мөн бусдад үйлчлэх үүрэг хариуцлага хүлээн авдаг зөвлөлүүд юм.

Зөвлөлийн гишүүд:

- Түлхүүрүүдийг атгадаг санваарын удирдагчидтай нэгдмэл байж, тэдний өгсөн удирдамжийг дагадаг.
- Өөрсдийн бодол, санаа зөв шударга болон ариун байдал, итгэл, ариун журам, тэвчээр, энэрэл, ах дүүсэг ёсны нинжин сэтгэлээр хуваалцдаг.
- Ариун Сүнсээр удирдуулан тусламж хэрэгтэй хүмүүст туслахын тулд юу хийхээ төлөвлөхөөр хамтдаа ажилладаг.

Бусдад үйлчил

Өсвөр үеийнхэн хайр, сайхан сэтгэлээр үйлчлэх үедээ Аврагчийн арга барилаар удирддаг. Иосеф Смит: "Хүмүүсийг гараас нь хөтөлж, анхааралтай харж хандахаас илүү, нүглээ орхиход хүргэдэг зүйл гэж үгүй. Хүмүүс надад жаахан ч атугай сайхан сэтгэл, хайрыг үзүүлэхэд энэ нь миний оюунд ямар их хүчтэй нөлөөлдөг гээч" хэмээн заасан.[8]

Аврагч бодгаль бүрийн үнэлж баршгүй үнэ цэнийн талаар заасан (С ба Г 18:10–15-ыг үзнэ үү). Есүс Христ амиа өгч, Өөрт нь ирэх замыг бүх хүнд нээж өгсөн гэдэг алдар суут үнэнийг ойлгоход өсвөр үеийнхэнд тусал. Их Эзэний жинхэнэ үйлчлэгчид Түүний хийсэн зүйлд талархаж, Аврагчийн өмнөөс бүхнээ золиосолсон залуу эрэгтэй, эмэгтэй бүрд өгөөмөр хайраар хүрч үйлчилдэг.

Есүс Христийн сайн мэдээг заа

Залуу эрэгтэй, эмэгтэйчүүдэд сайн мэдээ заах боломжийг таньж, үлгэр жишээгээрээ дамжуулан хамгийн сайн зааж чадна гэдгийг ойлгоход нь тусал. Өсвөр үеийнхэн бошиглогчдын үгс ба *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь жишгүүдийг даган амьдарснаараа Аврагчийн арга барилаар удирдаж байдаг. Тэд өөрсдийн үг, үйлдлийн үнэнч шударга байдлаар дамжуулан Есүс Христийн жинхэнэ шавь байх гэдэг нь юу гэсэн үг болохыг харуулдаг. Тэд хоёр нүүр гаргалгүйгээр Түүний гэрчүүд болон зогсдог. Дараа нь тэд гэрчлэл хуваалцан, ням гаргийн хичээл заахад тусалж, сайн мэдээний үнэнүүдийг найзуудтайгаа хуваалцах үедээ Ариун Сүнсээр дүүргэгдэж, үгс нь хөрвүүлэх хүчтэй байх болно.

Аврагчийн арга барилаар удирд

Аврагчийн арга барилаар удирдах нь ариун нандин боломж бөгөөд өсвөр үеийнхнээс гэртээ болон Сүмд, мөн нийгэмд Их Эзэнд үйлчлэхдээ чадах бүхнээ хийхийг шаардах болно. Аврагчийн арга барилаар удирддаг залуу эрэгтэй, эмэгтэйчүүд нь Есүс Христийн сайн мэдээний захиас болон хэн нэгний залбирлын хариу, мөн тусламж хэрэгтэй хүмүүст тэнгэр элч, дэлхийд Христийн гэрэл болдог. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Дэвид А.Бэднар, "Өсвөр үеийнхэн ба гэр бүлийн түүх," lds.org/youth/family-history/leaders.
2. Кэрол Ф.Макконки эгчийн ач хүүгээс ирсэн захидал, 2015 оны 3-р сарын 13.
3. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 3.1.
4. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Робэрт Д.Хэйлс, "Бурханы өмнө бидний хүлээсэн үүрэг: Өсвөр үеийнхний эцэг эх, удирдагчдын үүрэг зорилго," *Лиахона,* 2010 оны 5-р сар, 95, 98.
5. *Гарын авлага 2,* 5-ыг үзнэ үү.
6. *Гарын авлага 2,* 3,2-ыг үзнэ үү.
7. *Гарын авлага 2,* 4,1-ыг үзнэ үү.
8. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 394, 428.

ГЭР БҮЛИЙН ҮДШИЙГ ТЭМДЭГЛЭЖ БАЙНА

1915 онд хожмын үеийн бошиглогчид долоо хоногийн нэг үдшийг гэр бүлдээ зориулахыг зөвлөсөн. Энэ нь эхэндээ "гэрийн үдэш" гэсэн нэртэй байсан бөгөөд энэ амьдрал дээрх болон мөнхөд үргэлжлэх харилцаагаа хүчирхэгжүүлэхийн зэрэгцээ хамтдаа сайн мэдээнээс суралцах, хөгжилдөх цаг байв.

Нэг зуун жилийн дараа ч, гэр бүлийн үдэш нь мөнхөд орших гэр бүлүүдийг бий болгоход биднэд тусалсаар байна. Үүгээр дамжуулан бидний зүрх сэтгэлд илүү их итгэл, сүнслэг хүч чадал бий болох бөгөөд гэр оронд маань илүү их хамгаалалт, нэгдмэл байдал, амар амгалан орших болно хэмээн бошиглогчид амласан.

Бид бүгд дэлхий дээр гэр бүлтэй байдаг ба Тэнгэр дэх Эцэгийнхээ гэр бүлийн нэг хэсэг юм. Бид дэлхийн хаана ч, ямар ч нөхцөл байдалд байсан гэр бүлийн үдшийг тэмдэглэж мөн үүнд оролцож чадна. ■

***Зүүн гар талд:** Моуагийн гэр бүл саяхан Тайланд руу нүүсэн бөгөөд тэнд сайн мэдээнээс суралцаж, баптисм хүртжээ. Тэд гэр бүлийн үдшээрээ Мормоны Номыг өөрсдийн төрөлх хэл хмон, хоёр дахь хэл болох тай хэлээр судалдаг.*

***Доод талд:** Португалийн Сантосын гэр бүлийнхний хувьд хөгжилдөж, тоглоом тоглох нь гэр бүлийн үдшээр ойр дотно болох нэг арга зам юм.*

Баруун гар талд: Бүгд Найрамдах Конго улсад гэр бүл гэдэг ойлголт нь ээж, аав, хүүхдүүд гэдгээс илүү өргөн утгатай зүйл юм. Тиймээс Суэкамэно ахын гэр бүлийг гэр бүлийн үдэш хийхэд тосгоны олон хүн тэдэнтэй нэгддэг байна.

Дээд талд: Филиппиний Геркан эгч хүүхдүүддээ сайн мэдээнээс ирдэг баяр баяслыг заахын тулд Хүүхдийн хэсгийн болон үндэсний дуу хөгжим ашигладаг.

Дээд талд: АНУ-ын Жеоржиа дахь гэрийнхээ гал тогооны өрөөнд буй Андэрсоны гэр бүл жигнэмэг хийх дуртай. Тэд заримдаа тэдгээрийг хичээлийн нэг хэсэг болгон ашигладаг, эсвэл зүгээр л иддэг.

Дээд талд: АНУ-ын Вашингтоны Рэйнолдс ах, эгч хоёр бага насны хүүхдүүдийнхээ сурч, ойлгох түвшинд сайн мэдээг энгийн байдлаар заах арга замуудыг эрж хайдаг.

Өмнөх хуудсан дээр: Боливийн Эспинозагийн гэр бүлийнхэн гэр бүлийн үдшээр дуулж, сайн мэдээнээс суралцахдаа хүндтэй эмээгээ урьж авчирдаг.

АНУ-ын Жеоржиа дахь Жиний гэр бүлийнхний хувьд гэр бүлийн үдшээр хийх дуртай үйл ажиллагаа нь гэр бүлийн түүх юм. Тэд солонгос өв уламжлалынхаа талаар хүүхдүүддээ заах дуртай.

Австрали дахь Лайгартвүдийн гэр бүлийнхэн гэр бүлийн үдэш хийхдээ заримдаа зугаалж, хотынхоо үзэсгэлэнт хэсгүүдийг сонирхдог.

Гэр бүлийн үдшийн санаануудыг Лиахона сэтгүүлийн 3-р хуудсаас үзнэ үү.

Гэр бүлийн үдшийнхээ зураг, видео бичлэгийг #FamilyNight-ыг ашиглан хуваалц.

Илүү ихийг мэдэхийг хүсвэл facebook.com/liahona.magazine (англи, португаль, испани хэл дээр үзэх боломжтой) руу орно уу.

Бид Бурханы төлөвлөгөөг ойлгож, дуулгавартай дагаснаар Тэнгэрлэг Эцэг рүү хөтөлдөг замаас гажихгүй байх болно.

Ахлагч Робэрт Д.Хэйлс
Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Авралын төлөвлөгөө

БИДНИЙ ЗҮГ ЧИГИЙГ ЗААГЧ ЭРХЭМ НАНДИН МЭДЛЭГ

Мөнх бус байдлын өмнөх амьдрал дахь бидний амжилтын түлхүүр нь Эцэгийн төлөвлөгөөг дэмжих явдал байсан. Энэ нь мөнх бус амьдралд ч бидний амжилтын түлхүүр болдог.

Өөрсдийнхөө хэн болох, хаанаас ирсэн, яагаад дэлхий дээр байгаа, эсвэл мөнх бус амьдралын дараа хаашаа явах зэргийг мэдэхгүйгээр харанхуй, дүнсгэр орчлонд төөрөлдөж яваа Бурханы хүүхдүүдийн мухардмал байдлыг би олонтоо тунгаан бодож байсан.

Бид хэрэн хэсэх хэрэггүй. Бурхан эдгээр асуултад хариулдаг мөнхийн үнэнүүдийг илчилсэн. Тэдгээр үнэн нь хүүхдүүддээ зориулсан Түүний агуу төлөвлөгөөнд байдаг. Судруудад энэ төлөвлөгөөг “гэтэлгэлийн төлөвлөгөө,”[1] “аз жаргалын төлөвлөгөө,”[2] “авралын төлөвлөгөө”[3] гэж нэрлэдэг.

Бид Бурханы төлөвлөгөөг ойлгож, дуулгавартай дагаснаар Тэнгэрлэг Эцэг рүү хөтөлдөг замаас гажихгүй байх болно.[4] Тэгсэн үед л бид Түүний замнадаг амьдрал болох “Бурханы бүх бэлгүүдээс хамгийн агуу нь болох мөнх амьдрал”-тай[5] байх болно.

Мөнх амьдралын бэлэг нь авралын төлөвлөгөөг судалж, суралцаж, ашигласны хариуд ирдэг. Бүх хүн төрөлхтөн амилуулагдаж, үхэшгүй байдлын адислалыг хүлээн авах болно. Бурханы амьдрал[6] буюу мөнх амьдралыг олж авахын тулд бүх зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа авралын төлөвлөгөөний дагуу амьдрах ёстой.

ЭВЭР МОДОД, АШИР БРАУН ДЮРАНД, © THE METROPOLITAN MUSEUM OF ART, IMAGE SOURCE: ART RESOURCE, NY, ХУУЛБАРЛАЖ БОЛОХГҮЙ

Авралын төлөвлөгөөг ойлгох нь

Төлөвлөгөөг мэдэх нь ямар их итгэл найдвар өгдөг билээ! Авралын төлөвлөгөө бол хүн төрөлхтөнд өгөгдсөн хамгийн агуу мэдлэг юм. Яагаад гэвэл энэ нь амьдралын мөнхийн зорилгыг тайлбарладаг. Энэ мэдлэггүйгээр бид үнэхээр харанхуйд хэрэн хэсэх болно. Иймээс Бурхан "тэдэнд гэтэлгэлийн төлөвлөгөөг мэдүүлсний *дараа*" хүүхдүүддээ зарлигуудыг өгдөг.[7]

Миний зорилго бол энэхүү мэдлэгийг ашиглан авралын төлөвлөгөөг илүү сайн ойлгож, ойлголтоо өдөр тутмын амьдралдаа ашиглахад туслах явдал юм.

Сонгох эрх

Сонгох эрх нь энэ төлөвлөгөөний амин чухал хэсэг учраас үүнээс эхэлье. Эцэг маань бидэнд мөнхийн үнэнүүдийн дагуу үйлдэх эсвэл үйлдэхээс татгалзах чадварыг өгсөн.[8] Эдгээр үнэн нь Бурханыг болон тэнгэр дэх зүйлийг захирдаг.[9] Хэрэв бид эдгээр үнэнийг хүлээн зөвшөөрч, эдгээрийн дагуу амьдарвал мөнхийн баяр баяслыг хүлээн авна. Эсрэгээрээ, хэрэв бид дуулгаваргүй байж, Бурханы хуулиудыг эсэргүүцэхэд сонгох эрхээ ашиглавал зовлон, уй гашууг амсах болно.[10]

Есүс Христ эхлэлээс Эцэгийн хайртай, сонгогдсон, урьдчилан томилогдсон Хүү байсан.

Сонгох эрх нь авралын төлөвлөгөөний гурван бүлэгт яг тохирсон бүдүүвч зургийг гаргадаг: Мөнх бус байдлын өмнөх амьдрал, мөнх бус амьдрал, мөнх бус байдлын дараагийн амьдрал.

Мөнх бус байдлын өмнөх амьдрал

"Гэр бүл, Дэлхий дахинаа өргөх тунхагт" бичигдсэнээр бидний хүн нэг бүр "тэнгэрлэг эцэг эхийн сүнсэн хөвгүүд ба охид юм."[11] Мөнх бус байдлын өмнөх зөвлөлд Тэнгэрлэг Эцэг Өөрийн гэтэлгэлийн төлөвлөгөөг бидэнд тайлбарласан.[12] Уг төлөвлөгөө нь үргэлж оршин байсан сургаал, хууль, зарчмууд дээр үндэслэгдсэн.[13] Хэрэв бид уг төлөвлөгөөг хүлээн зөвшөөрч, дагахыг сонговол Эцэгийнхээ оршихуйг сайн дураараа орхиж, Түүний хууль, зарлигуудыг дагах эсэхээрээ соригдох болно гэдгийг ойлгосон.[14] Бид энэ боломжинд маш их баярласан[15] ба уг төлөвлөгөөг талархан дэмжсэн. Учир нь энэ нь бидэнд Тэнгэрлэг Эцэгтэйгээ адил болж, мөнх амьдралыг өвлөх арга замыг заадаг билээ.

Гэвч төлөвлөгөөнд эрсдэл байсан: хэрэв бид мөнх бус амьдралд Бурханы мөнхийн хуулиудын дагуу амьдрахыг сонгохгүй бол мөнх амьдралыг хүлээн авч чадахгүй.[16] Бид мөнх бус амьдралд туршлагаараа суралцахдаа бүдэрч мөн нүгэл үйлдэнэ гэдгийг Эцэг маань мэдэж байсан учраас Тэрээр наманчилдаг хүн бүрийг гэтэлгэх, дуулгавартай хүмүүсийн сүнслэг ба сэтгэл санааны шархыг эдгээх Аврагчийг бэлтгэсэн.[17]

Есүс Христ эхлэлээс Эцэгийн хайртай, сонгогдсон, урьдчилан томилогдсон Хүү байсан.[18] Тэрээр Эцэгийн төлөвлөгөөг дэмжиж, өөрийн хүслээр бидний Аврагч болсон: "Би энд байна, намайг илгээ."[19] Ийнхүү Есүс мөнх бус байдалд нүгэлгүй амьдралаар амьдарч, бидний нүгэл ба зовлонг цагаатгаж, үхлийн хүлээсийг тасдахын тулд амилахаар Эцэгээр томилогдсон байв.

Сатан гэж нэрлэгдэх болсон Люсифер бас мөнх бус байдлын өмнөх оршихуйд амьдарч байсан.[20] Тэр аминч үзлээсээ болж төлөвлөгөөг эсэргүүцэн, хүмүүний сонгох эрхийг устгахыг эрэлхийлж, Эцэгийн эсрэг бослого гаргасан.[21] Үүний үр дүнд Сатан болон түүнийг дагагсад хэзээ ч бие махбодтой болохгүй. Тэд Эцэгийн төлөвлөгөөнд оролцох боломж, тэнгэрлэг хувь тавилангаа алдсан.[22] Өнөөдөр тэд Бурханыг эсэргүүцэх дайнаа үргэлжлүүлж, хүн төрөлхтний оюун ба зүрх сэтгэлийг Түүний эсрэг эргүүлэхийг эрэлхийлсэн хэвээр байна.[23]

Энэ дэлхий нь Эцэгийн төлөвлөгөөг хүлээн зөвшөөрсөн хүмүүст зориулагдан бүтээгдсэн.[24] Энд бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн бие махбодыг хүлээж авдаг. Энд бид соригдож мөн өөрсдийгөө нотолдог. Энд бид мөнх амьдралыг өвлөн авахад шаардлагатай туршлагуудыг олж авдаг.[25]

Мөнх бус амьдрал

Бурхан Адам, Ева хоёрыг бүтээж, тэднийг нөхөр эхнэр болгон, Едений цэцэрлэгт байрлуулж, хүүхэдтэй болохыг тэдэнд зарлигласан.[26] Адам, Ева хоёр сонгох эрхээ ашиглан, Бурханы оршихуйгаас унасан бөгөөд мөнх бус хүмүүс болцгоосон.[27] Тэд хүүхдүүдтэй болох боломжтой болсноор Эцэгийн төлөвлөгөө хэрэгжсэн

ЭММАУС ДАХЬ ХРИСТ ЗУРГИЙН ХЭСГЭЭС, КАРЛ ХЭНРИ БЛОХ; ЭММАУС ДАХЬ АДАМ, ЕВА ХОЁР ЗУРГИЙН ХЭСГЭЭС, ДУГЛАС М.ФРАЙЕР

билээ.[28] Мөнхийн хуулийн дагуу, хүүхэд бүтээх тэнгэрлэг хүч нь Тэнгэрлэг Эцэгийн тогтоосон хүрээнд ашиглагдах ёстой. Ийнхүү үйлдэх нь мөнхийн баяр баясгалыг амсах боломж олгодог. Энэ ариун нандин хүчийг ямар нэг байдлаар Бурханы хил хязгаараас гадуур ашиглах нь уй гашууд хүргэх болно.[29]

Бүх хүнийг "өөрийн адил зовлонт байлгахыг"[30] хүсдэг Сатан Эцэгийн төлөвлөгөөгөөр дамжин ирдэг боломжуудаас биднийг хол байлгахыг хичээдэг. Тэнгэрлэг Эцэг яагаад биднийг уруу татахыг Сатанд зөвшөөрдөг вэ? Учир нь сөрөг тал нь бидний өсөлт ба мөнх бус байдал дахь сорилтод шаардлагатай гэдгийг Тэр мэддэг.[31] Сөрөг тал нь Бурханд хандаж мөн Түүнд найдах гайхалтай боломжийг бидэнд олгодог. Сайн ба муу нь бидний өмнө үргэлж байдаг учраас бид аль нэгийг нь сонгож, нөгөөхөөс нь татгалзсанаараа зүрх сэтгэлийнхээ хүслийг тодорхой харуулж чадна.[32] Сөрөг тал нь Сатаны уруу таталтууд болон бидний сул талууд, хүний мөн чанартай салшгүй холбоотой мөнх бус сул дорой чанаруудаар илэрдэг.[33]

Ухаалаг сонголт хийхэд бидэнд туслахын тулд Бурхан гэтэлгэлийн төлөвлөгөөгөө илчилж, зарлигууд,[34] Христийн Гэрэл,[35] Ариун Сүнсний нөхөрлөлийг өгсөн.[36] Эдгээр бэлэг байлаа ч гэсэн энэ унасан дэлхийд амьдарч буй бидний хүн нэг бүр нүгэл үйлдэж, ингэснээрээ өөрсдийн хүчээр Бурханы оршихуйд орох чадваргүй байдаг.[37] Тийм учраас Түүний нигүүлсэнгүй төлөвлөгөө бидэнд Аврагчийг өгдөг юм.

Есүс Христ дэлхийд Бурханы цорын ганц хайртай Хүү болж ирсэн бөгөөд бүх зүйлд Эцэгийн хүсэлд захирагдаж, томилогдсон үүргээ төгс биелүүлсэн.[38] Эцэгийн нигүүлсэнгүй төлөвлөгөөний дагуу Уналтын үр дагаврууд нь Аврагчийн амилалтаар төгсгөл болж,[39] нүглүүдийн үр дагаврууд арилж, бид Есүс Христийн Цагаатгалыг ашиглавал сул талаа давуу тал болгож чадна.[40]

Бид зарлигуудад дуулгавартай байснаараа мөнх амьдралыг авах боломжтой. Ингэж дуулгавартай байхад Их Эзэн Есүс Христэд

Адам, Ева хоёр сонгох эрхээ ашиглан, Бурханы оршихуйгаас унасан бөгөөд мөнх бус хүмүүс болцгоосон. Тэд хүүхдүүдтэй болох боломжтой болсноор Эцэгийн төлөвлөгөө хэрэгжсэн билээ.

Мөнх амьдралын утга учир нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг тэнгэрлэг эцэг эхтэйгээ адил болоход тусалдаг мөнхийн гэрлэлтийг багтаадаг

иттэх, наманчлах, баптисм хүртэх, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах, Аврагчийн үлгэр жишээг дагахад эцсээ хүртэл тэвчих зэргийг шаарддаг.[41] Энгийн үгээр хэлбэл бид санваарын бүх шаардлагатай ёслолыг хүлээн авч, тэдгээртэй холбогдсон гэрээнүүдийг сахин, эцсээ хүртэл тэвчих ёстой.

Мөнх бус байдлын дараах амьдрал

Бид нас барсныхаа дараа шүүгдэхээр нэгэн өдөр Аврагчийн өмнө зогсох болно.[42] Бурхан нигүүлсэнгүй учраас Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, наманчилсан хүмүүс өршөөгдөж, мөнх амьдралыг болон Эцэгт буй бүхнийг өвлөн авах болно.[43] Бурхан шударга учраас наманчилдаггүй хүн бүр мөнх амьдралын бэлгийг хүлээн авахгүй.[44] Хүн нэг бүр өөрийн итгэл, наманчлал, бодол, хүсэл, ажил үйлсийн дагуу шагнагдах болно.[45]

Авралын төлөвлөгөөг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх нь

Бид авралын төлөвлөгөөний том дүр зургийг мөн энэ нь бидэнд ямар хамаатай болохыг ойлгосон үедээ үнэлж баршгүй, амин чухал зүйл болох мөнхийн талаас нь харж чадахуйц болдог. Мөнхийн талаас харах төлөв нь бидний өдөр тутмын шийдвэр, үйлс үйлдлийг тодорхойлдог. Энэ нь бидний оюун ба бодгалиудыг тогтоон барьж байдаг. Үнэмшмээр боловч мөнхийн талаасаа буруу үзэл бодлууд биднийг хүрээлэх үед бид тууштай бөгөөд хөдөлшгүй байх болно.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл А.Максвэлл (1926–2004) "Авралын төлөвлөгөөний буюу мөнх бус байдлын өмнөх амьдрал, шүүлт, амилуулалтын тухай ойлголтгүйгээр энэ амьдралын утга учрыг олохыг хичээх нь гурван үзэгдэлт жүжгийн зөвхөн хоёрдугаар үзэгдлийг үзэхтэй адил юм" хэмээн заажээ.[46] Бид хоёрдугаар үзэгдэлд (мөнх бус амьдрал) хэрхэн хамгийн зөв сонголт хийхээ мэдэхийн тулд нэгдүгээр үзэгдлийг (мөнх бус байдлын өмнөх амьдралыг) ойлгох ёстой. Хоёрдугаар үзэгдэл нь гуравдугаар үзэгдэлд (мөнх бус байдлын дараагийн амьдралд) бидэнд юу тохиолдохыг тодорхойлдог.

Өөрөөр хэлбэл, авралын төлөвлөгөөний тухай ойлголт ба чин сэтгэлийн залбирал нь амьдралыг болон эргэн тойрондоо буй хүмүүсийг, мөн өөрсдийгөө үзэх үзлийг маань өөрчилдөг. Уг төлөвлөгөөг ойлгох нь бидний сүнслэг харааг сайжруулж, аливаа зүйлсийг байгаагаар нь харах боломжийг бидэнд олгодог.[47] Урим ба Туммим нь бошиглогч Иосеф Смитэд илчлэлт ба удирдамж хүлээн авах боломжийг олгосонтой адилаар[48] төлөвлөгөөний тухай ойлголт нь Их Эзэний өгсөн "ёс суртахууны сонгох эрхийн дагуу хүн болгон ирээдүйд хамаарах сургаал хийгээд зарчимд үйлдэж болохыг" үзүүлэх болно.[49] Тиймээс бидний итгэл хүчирхэгжиж, бид амьдралынхаа зүг чигийг хэрхэн чиглүүлэхийг мэдэж, мөнхийн үнэнүүдтэй нийцэх шийдвэрийг гаргаж байх болно.

Бидний өнөө үед ихээхэн тустай байж болох хэдэн жишээг доор харуулав:

Бурханы төлөвлөгөөнд гэрлэлт яагаад чухал байдаг шалтгаан

Гэрлэлт, гэр бүл нь мөнх амьдралыг олж авахад Бүтээлт, Уналт, Есүс Христийн Цагаатгал, амилалт зэрэгтэй адил чухал гэдгийг Сатан мэддэг учраас тэдэн рүү дайрдаг.[50] Сатан төлөвлөгөөний гол багана болсон зүйлүүдийг устгаж чадаагүй учраас гэрлэлт ба гэр бүлийн талаарх бидний ойлголтыг устгахыг эрэлхийлдэг.

Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөтэй холбон авч үзвэл, гэрлэлтийн зорилго нь тодорхой болдог. Эцэг эхээ орхин, нэг нэгэнтэйгээ гэрлэлтээр нэгдэн нийлж,[51] өсөж үржин дэлхийг дүүргэ[52] хэмээх зарлиг нь Түүний төлөвлөгөөг боломжтой болгодог. Бид гэрлэлтээр дамжуулан Түүний сүнсэн хүүхдүүдийг дэлхийд авчирч, төлөвлөгөөнд оролцоход хүүхдүүдэд нь туслах ажилд Түүний хамтрагчид болдог.[53]

Эцэгийн төлөвлөгөө нь тэнгэрлэг эцэг, эхийн маань амьдардаг мөнх амьдралыг өвлөн авах арга замыг бидэнд өгдөг. Төлөвлөгөөнд "Эзэн дотор эр хүнгүйгээр эмэгтэй хүн гэж үгүй бөгөөд эмэгтэй хүнгүйгээр эр хүн гэж үгүй юм."[54] Мөнх амьдралын утга учир нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг тэнгэрлэг эцэг эхтэйгээ адил болоход тусалдаг мөнхийн гэрлэлтийг багтаадаг.[55]



Эцэгийн нигүүлсэнгүй төлөвлөгөөний дагуу Уналтын үр дагаврууд нь Аврагчийн амилалтаар төгсгөл болсон

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох гэрлэлт

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс өвөрмөц, маш чухал ялгаатай учраас гэрлэлтэд бид нэг нэгнийхээ дутууг нөхдөг. Нөхөр, эхнэр болохын хувьд бид мөнх бус байдалд хамтдаа өсөж, дуулгавартай байснаараа Аврагчид илүү ойртож, Бурханы хүслийг биелүүлэхийн тулд золиослол хийн, хамтдаа Түүний хаант улсыг байгуулдаг. Бид мөнхийн гэрлэлт бол Бурханы зарлиг бөгөөд Тэрээр өөрийн зарлигуудыг биелүүлэх арга замыг бүх хүүхдэдээ бэлтгэж өгнө[56] гэдгийг мэдсэнээрээ хийсэн гэрээнүүдээ сахих үед гэрлэлт маань амжилттай байна гэдгийг мэдэж чадна.

Бид мөнх бус байдлын саад бэрхшээлийг даван туулахдаа санваарын ёслолууд ба тэдэнтэй холбоотой гэрээнүүдийг сахихыг сонгосноороо бурханлаг байдлын хүчийг хүлээн авах болно.[57] Ариун сүмийн ёслолууд нь бидэнд дээрээс хүч чадал өгч, Тэнгэрлэг Эцэгийнхээ оршихуйд буцаж очих боломжийг олгодог.[58] Лацдан холбох ёслол нь нөхөр, эхнэрийг Бурханы хүчээр хамтдаа өсөж, Их Эзэнтэй нэг байхад тусалдаг.[59] Үүнээс өөр байдлаар гэрлэх нь бидний болон ирээдүй хойч үеийнхний төлөөх Түүний зорилгыг биелүүлж чадахгүй.[60]

Сэтгэл татагдах ба дур хүсэл

Бидний хүн нэг бүр энэ унасан дэлхийд хүн төрөлхтний салшгүй сул дорой байдал буюу бэрхшээлийг амсдаг.[61] Бурханы төлөвлөгөөг ойлгох нь Түүний төлөвлөгөөтэй үл нийцэх сэтгэл татагдах явдал, дур хүсэл гэх мэт хүмүүний бүх сул дорой чанарыг олж харахад тусалдаг.[62] Энэ амьдралаас өмнө бид тэнгэрлэг эцэг, эхийн хайртай хөвгүүд, охид байсан гэдгээ мэдэх нь тэнгэрлэг гарал үүслээ ойлгоход тусална. Бидний сул дорой чанарууд эсвэл чиг хандлагуудаас илүүгээр Бурханы хөвгүүд, охид гэсэн ойлголт нь бидний жинхэнэ мөн чанар юм.[63]

Ийм ойлголттойгоор бид Их Эзэнийг илүү даруу, тэвчээртэй хүлээж,[64] итгэл, дуулгавартай байдал, эцсээ хүртэл тэвчих байдлаар дамжуулан хандлага, хүслүүд маань цэвэршигдэж, бие махбод маань ариусгагдан, бид

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЖЭЙМС ЖОНСОН; *ХРИСТИЙН ЗУРГИЙГ*, ХЭЙНРИХ ХОФФАНН

Бид Эцэгийн төлөвлөгөөний талаарх ойлголтоо өдөр тутам амьдралдаа ашигладаг байвал бидний амьдрал илүү утга учиртай болно.

Христийн Цагаатгалаар төгс болж, Түүний жинхэнэ хөвгүүд, охид болох болно.

Энэ төлөвлөгөөний мөнхийн талаас харах үзэл нь итгэлтэй хүмүүст баталгаа өгч, "Тэр тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. . . .Тэнд цаашид . . . өвдөх гэж үгүй болно. Анхны юмс өнгөрөн одлоо"[65] хэмээх өдөр ирэх болно. Энэхүү "найдварын төгс гэрэл"[66] нь бидний оюун, зүрх сэтгэлийг хамгаалж, Их Эзэнийг тэвчээртэй, итгэлтэй хүлээхэд тусална.

Итгэлтэй тэвчдэг хүмүүст өгөгдсөн амлалтууд

Одоогийн нөхцөл байдал нь өөрсдөдөө мөнх амьдралыг авахад саад болох эсэх дээр эргэлзэж байгаа хүмүүс "Эцэгийн хүүхдүүддээ өгөхөөр бэлтгэсэн бүхнээс багыг хүлээн авахаар сонгогдсон хүн гэж байхгүй" гэдгийг санах ёстой.[67]

Итгэлтэй хүмүүс ямар ч адислалаа алдахгүй. Ерөнхийлөгч Лорэнзо Сноу: "Итгэлтэйгээр амьдарсан боловч боломж бүрдээгүй байснаас болж зарим зүйлийг хийж чадаагүй ямар ч хожмын үеийн гэгээнтэн ямар ч адислалаа алдахгүй. Өөрөөр хэлбэл, хэрэв залуу эрэгтэй эсвэл эмэгтэй гэрлэх боломжгүй байсан ч нас барах хүртлээ итгэлтэйгээр амьдарвал тэд гэрлэх боломжтой байсан хүмүүсийн адилаар бүх адислал, өргөмжлөл, алдар суут хүлээн авах болно. Энэ бол баттай ба тодорхой зүйл юм" хэмээн хэлжээ.[68]

Төлөвлөгөөг мэддэг, өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлдэг хүмүүст зориулагдсан амлалтууд

Бидний хүн нэг бүр мөнх бус байдлын өмнөх амьдралд Эцэгийн төлөвлөгөөг бүрэн дэмжсэн. Түүнийг бидэнд хайртай гэдгийг бид мэдэж байсан ба Өөрт байгаа бүхнийг болон мөнх амьдралыг бидэнд өвлүүлэх Түүний өгөөмөр занг гайхан биширсэн. Мөнх бус байдлын өмнөх амьдрал дахь бидний амжилтын түлхүүр нь Эцэгийн төлөвлөгөөг дэмжих явдал байсан юм. Энэ нь мөнх бус амьдралд ч бидний амжилтын түлхүүр болдог.

Тиймээс хамтдаа Эцэгийн төлөвлөгөөг дэмжихээр дахин хамтдаа зогсохыг би уриалж байна. Бид бүх хүнд хайртай учраас үүнийг хийдэг. Учир нь уг төлөвлөгөө нь өөрөө Бурханы хайрын илэрхийлэл юм.

Бид Эцэгийн төлөвлөгөөний талаарх ойлголтоо өдөр тутам амьдралдаа ашигладаг байвал бидний амьдрал илүү утга учиртай болно. Бид зовлон бэрхшээлтэйгээ илүү агуу итгэлтэйгээр нүүр тулж чадна. Бид мөнх амьдралын баттай, тод найдвар тээн, урагш тэмүүлэх болно. ■

ОЙЛГУУЛАХЫН ТУЛД ТЭДЭНД ЗАА, УОЛТЭР РЭЙНИЙ ЗУРАГ

ЭШЛЭЛҮҮД

1. Иаков 6:8; Алма 12:25–26, 30, 32; 17:16; 18:39; 29:2; 39:18; 42:11.
2. Алма 42:8, 16.
3. Жером 1:2; Алма 24:14; 42:5; Мосе 6:62.
4. Алма 12:32-ыг үзнэ үү; мөн Боид К.Пакэр, “The Great Plan of Happiness and Personal Revelation”-ийг үзнэ үү (Сүмийн боловсролын системийн залуучуудад зориулсан нэвтрүүлэг, 1993 оны 11-р сарын 7).
5. Сургаал ба Гэрээ 14:7.
6. Харолд Б.Лий, *The Teachings of Harold B. Lee,* ed. Clyde J. Williams (1996), 72-ыг үзнэ үү; мөн Брүс Р.Макконки, in Conference Report, April 1970, 26-г үзнэ үү.
7. Алма 12:32; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн; мөн 25-р шүлгийг үзнэ үү.
8. 2 Нифай 2:13–16; Сургаал ба Гэрээ 101:78-ыг үзнэ үү.
9. George Q. Cannon, *Gospel Truth: Two Volumes in One: Discourses and Writings of President George Q. Cannon* sel. Jerreld L. Newquist (1974), 296-г үзнэ үү.
10. Ричард Г.Скотт, “How to Live Well amid Increasing Evil,” *Лиахона,* 2004 оны 5-р сар, 102; Робэрт Д.Хэйлс, *Return: Four Phases of Our Mortal Journey Home* (2010), 33-ыг үзнэ үү.
11. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Лиахона,* 2010 оны 11-р сар, 129; мөн Үйлс 17:29; Ром 8:16–17; Еврей 12:9; Абрахам 3:18–25-ыг үзнэ үү.
12. Алма 12:30-ийг үзнэ үү; мөн Иов 38:4–7; Абрахам 3:22–28-ыг үзнэ үү.
13. 2 Нифай 2:13-ыг үзнэ үү; мөн Ховард В.Хантэр, “To Know God,” *Ensign,* 1974 оны 11-р сар, 97-г үзнэ үү; *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Хибэр Ж.Грант* (2002), 30: “Зарлиг бүр нь биднийг буцаж, Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд амьдрахад бэлттэх зорилгоор өгөгдсөн юм. Эдгээр үүрэг хариуцлага нь биднийг бурханлаг шинж чанартай болгох зорилготой. Тэдгээр нь биднийг бурхад болгож, Их Эзэн, Аврагч Есүс Христтэй хамтран залгамжлагчид болгох зорилготой юм.”
14. Сургаал ба Гэрээ 136:31; Абрахам 3:24–25-ыг үзнэ үү.
15. Иов 38:7-г үзнэ үү.
16. Сургаал ба Гэрээ 88:34–36, 39–40-ийг үзнэ үү.
17. Исаиа 53:3–5; 2 Нифай 2:8; 9:10–11; 31:21; Мозая 3:17; Алма 7:11–13-ыг үзнэ үү.
18. 1 Петр 1:20; Мосе 4:2-ыг үзнэ үү.
19. Абрахам 3:27.
20. Исаиа 40:12–16-г үзнэ үү.
21. Мосе 4:3–4-ийг үзнэ үү; мөн 1:19-ийг үзнэ үү.
22. Илчлэлт 12:7–9-ийг үзнэ үү.
23. Сургаал ба Гэрээ 10:26–27-г үзнэ үү.
24. Сургаал ба Гэрээ 59:18–19-ийг үзнэ үү.
25. Абрахам 3:24–26-г үзнэ үү.
26. Эхлэл 1:26–28-ыг үзнэ үү.
27. Алма 42:2–6; Мосе 4:25, 28–31-ийг үзнэ үү.
28. 2 Нифай 2:23; Мосе 5:11-ийг үзнэ үү; мөн Боид К.Пакэр, “Аз жаргалын төлөвлөгөө,” *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулганы материал,* 26–28-ыг үзнэ үү.
29. Алма 39:3–5; 41:3–4, 10–15-ыг үзнэ үү.
30. 2 Нифай 2:27
31. 2 Нифай 2:11-ийг үзнэ үү.
32. 2 Нифай 2:26–29; Алма 34:32–35-ыг үзнэ үү.
33. Иаков 4:7; Ифер 12:27; Сургаал ба Гэрээ 62:1-ийг үзнэ үү.
34. Алма 12:30–32-ыг үзнэ үү.
35. Моронай 7:16–19; Сургаал ба Гэрээ 88:7, 11–13-ыг үзнэ үү.
36. 2 Нифай 31:12–14, 18-ыг үзнэ үү.
37. 1 Иохан 1:8-ыг үзнэ үү.
38. Лук 22:39–42; Сургаал ба Гэрээ 19:16-19-ийг үзнэ үү.
39. 1 Коринт 15:20–23; 2 Нифай 9:10–13; Алма 11:42–45-ыг үзнэ үү.
40. Алма 42:2–15, 22–31; Моронай 10:32–33-ыг үзнэ үү.
41. 2 Нифай 31:10–21; 3 Нифай 27:13–22-ыг үзнэ үү.
42. Иохан 5:22; Ром 14:10; Илчлэлт 20:12–13; 2 Нифай 9:41; Алма 11:41–44; 3 Нифай 27:14–17, 20, 22-ыг үзнэ үү.
43. Алма 34:14–17-г үзнэ үү.
44. Мозая 3:21–27; Хиламан 14:15–19; Сургаал ба Гэрээ 88:21–24, 29–32-ыг үзнэ үү.
45. Мормон 3:20–22-ыг үзнэ үү.
46. *The Neal A. Maxwell Quote Book,* ed. Cory H. Maxwell (1997), 252.
47. Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Be Thou an Example,” *Лиахона,* 2005 оны 5-р сар, 113-ыг үзнэ үү.
48. Иосеф Смит–Түүх 1:35-ыг үзнэ үү.
49. Сургаал ба Гэрээ 101:78.
50. Д.Тодд Кристоффэрсон, “Гэрлэж, гэр бүлтэй болох шалтгаан,” *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулганы материал,* 52.
51. Матай 19:5-ыг үзнэ үү.
52. Эхлэл 9:1-ийг үзнэ үү.
53. Сургаал ба Гэрээ 93:36–40-ийг үзнэ үү.
54. 1 Коринт 11:11.
55. Даллин Х.Өүкс, “Apostasy and Restoration,” *Ensign,* 1995 оны 5-р сар, 87-г үзнэ үү; мөн Даллин Х. Өүкс, “Өөр бурхадтай байж болохгүй,” *2013 оны 10-р сарын Ерөнхий чуулганы материал,* 73-ыг үзнэ үү.
56. 1 Нифай 3:7-г үзнэ үү.
57. Сургаал ба Гэрээ 84:19–21-ийг үзнэ үү.
58. Сургаал ба гэрээ 109:13–26, 38-ыг үзнэ үү.
59. Сургаал ба Гэрээ 132:1–21-ийг үзнэ үү.
60. 1 Петр 3:7; Сургаал ба гэрээ 131:1–4-ийг үзнэ үү; мөн Жозеф Филдинг Смит, *Answers to Gospel Questions,* 5 vols. (1957–66), 4:197-г үзнэ үү: “Ариун сүмд энэ амьдралд болон үүрд мөнхөд гэрлэсэн хүмүүс *мөнх амьдралыг* хүлээн авах болно. Би *мөнх амьдрал* гэдгийг онцолж байна. Мөнх амьдрал бол Бурханы амьдрал буюу түүнтэй адил болно гэсэн үг. *Мөнх амьдрал* гэдэг нь илчлэлтүүдэд хэлснээр мөнхөд үргэлжлэх үр удамтай байх мөнхийн өсөлт юм. Ариун сүмээс гадуур гэрлэх нь зөвхөн энэ амьдралд хүчинтэй. Тэд энэ амьдралд наманчилж мөн ариун сүмд орж гэрлэхгүй бол үхэл тэднийг үүрд тусгаарлах болно.”
61. Ифер 12:27-г үзнэ үү.
62. Ифер 12:37-г үзнэ үү.
63. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” 129-ийг үзнэ үү; мөн *God Loveth His Children* (товхимол, 2007), 1-ийг үзнэ үү.
64. Исаиа 40:31-ийг үзнэ үү.
65. Илчлэлт 21:4; мөн 1–3-р шүлгүүдийг үзнэ үү.
66. 2 Нифай 31:20.
67. Д.Тодд Кристоффэрсон, “Гэрлэж, гэр бүлтэй болох шалтгаан,” 52.
68. *Teachings of Presidents of the Church: Lorenzo Snow* (2012), 130. Гордон Б.Хинкли, “Daughters of God,” *Ensign,* 1991 оны 11-р сар, 98: “Гэрлэж амжаагүй зарим хүн өөрсдийн буруугаас болоогүй ч гэсэн селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлд орж чадах эсэхтээ эргэлздэг. Хайраар дүүрэн Эцэг ба тэнгэрлэг Гэтэлгэгчийн төлөвлөгөөний дагуу та нараас ямар ч адислал авагдахгүй гэдэгт би итгэлтэй байна.



Офицеруудын хоолны өрөөнд орж ирэхэд хөлгийн ахмад нэгэн залуу офицер руу хашгирч, хуруугаараа чичиж байлаа.

ЭНЭ ХЭР ЧУХАЛ БАЙВ ГЭЖ ДЭЭ?

Намайг хилийн чанадад *ЮСС Вест Виржиниа* шумбагч онгоцны аяллаар явж байх үед португаль хэлээр ярьдаг офицерийг гурван долоо хоногийн турш Бразилийн тэнгисийн цэргийн солилцооны хөтөлбөрт явуулах зар ирсэн юм. Шумбагч онгоцны багт португалиар ярьдаг ганц хүн нь би байлаа.

Надад эхэндээ явахгүй гэсэн бодол төрж байв. Би гурван сар хилийн харуул хийгээд дууссан байсан бөгөөд гэр бүлтэйгээ уулзахыг тэсэн ядан хүсэж байсан ч солилцооны хөтөлбөр миний бодлоос гарахгүй байлаа. Би Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, явах ёстой гэсэн тодорхой хариулт хүлээж авсан болохоор энэ даалгаврыг биелүүлэхийг зөвшөөрөв.

Бэлтгэл ажлын үеэр маш олон саадтай тулгарч байв. Нэг удаа би явахаа болих талаар бодож байлаа. “Энэ хэр чухал байв гэж дээ?” гэж би бодов. Гэсэн хэдий ч Ариун Сүнс энэ ажлаа үргэлжлүүлэхэд намайг өдөөсөн юм.

Эцэст нь, хэдэн өдрийн дараа би Бразилийн нэгэн хөлөг онгоцон дээр ирэв. Офицеруудын хоолны өрөөнд орж ирэхэд хөлгийн ахмад нэгэн залуу офицер руу хашгирч, хуруугаараа чичиж байлаа. Ахмад намайг хараад, хийж байсан зүйлээ зогсоож, “Өө, миний америк найз ирсэн байна. Тавтай морилно уу. Би таныг уух юмаар дайлж болох уу?” гэж буруу хазгай англиар хэлэв.

Би номлолоосоо хойш уугаагүй байсан Бразилийн алдарт согтууруулах бус ундааг уумаар байгаагаа португалиар хэлэв. Онгоцон дээр бүх төрлийн согтууруулах ундаа байгаа гэж тэр хэлсэн ч би архи уудаггүй гэдгээ хэлсэн юм.

Тэр орой нь нэг хүн өрөөний минь хаалгыг тогшив. Хаалгаа нээтэл, хоолны өрөөнд харсан залуу офицер зогсож байлаа.

“Чи америк хүн.” “Чи архи уудаггүй. Чи португалиар ярьдаг. Чи Мормон юм биш биз?” гэж тэр хэлэв.

“Тийм ээ, мөн” гэж би хариулав.

Тэр намайг тэврээд уйлж эхлэв.

Дэслэгч Мендез гэдэг энэ офицер шинэхэн хөрвөгч бөгөөд Бразилийн Тэнгисийн Цэргийн Академийг төгсөөд удаагүй байв. Хөлөг онгоц зогсох боомт бүр дээр түүнийг бусад цэрэгтэй адил муу зүйл хийхийг ахмад түүнээс хүсдэг байсан гэдгийг би удалгүй мэдэж авсан юм. Харин дэслэгч Мендез харуулын ажлыг

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АЛЛЕН ГАРНС

байнга сайн дураараа хийж, боомт дээр болдог үйл ажиллагаануудаас зайлсхийдэг байв. Ахмад үүнээс нь залхсан байжээ. Намайг хоолны өрөөнд орох үед дэслэгч Мендезийг цэргүүдтэй нэгдээгүй болохоор нь ахмад түүн рүү хашгирч байжээ.

"Дараагийн боомт дээр зогсох үед чи бусад офицертой хамт гарах болно" гэж тэр дэслэгчид тушаав. "Чи айлчилж ирсэн америк офицерт яаж наргиж цэнгэдгийг үзүүлэх болно. Тэр биднээс ийм зүйл хүлээж байгаа."

Ахмадыг өөрийнх нь зарчмуудыг ойлгож, хүлээн зөвшөөрөөсэй гэж дэслэгч Мендез олон сар залбирчээ. Намайг ирснээс хойш сайн мэдээний талаарх яриа хоолны өрөөнд болдог ихэнх ярианы гол сэдэв болох болов. Бид бусад офицертой Иосеф Смит, Сэргээлт, мэргэн ухааны үг, ариун явдлын хууль зэргийн талаар ярилцдаг байв. Хүмүүсийн дэслэгч Мендезэд хандах хандлага удалгүй өөрчлөгдөж эхэлсэн юм. Офицерууд ил гаргаж тавьсан порнографтай материалуудаа далд хийж, дараагийн боомт дээр бид клубт очихын оронд хамтдаа ресторанд хоол идэж билээ.

Гурван долоо хоногийн дараа гэхэд, ахмадтай төдийгүй офицеруудтай олон удаа ярилцсаны үр дүнд эрчүүд зүрх сэтгэлээ зөөлрүүлсэн юм. Намайг явахаас өмнө ахмад "би одоо ойлгож байна" гэж дэслэгч Мендезэд хэлээд, түүнийг зарчмуудынхаа эсрэг яв гэж дахин ятгахгүй гэлээ.

Би энэ явдлыг хэзээ ч мартахгүй. Тэнгэр дэх Эцэг маань биднийг нэг бүрчлэн мэддэг, хайрладаг, бидний хувийн амьдралд санаа тавьдаг гэдгийг дэслэгч Мендез бид хоёр ойлгож авсан юм. ■

Кэлли Лэйнг, АНУ, Вашингтон

СПАФФОРД ЭГЧ НАДАД ХАНДАН ЯРЬЖ БАЙЛАА

Намайг нэг орой онлайнаар ресторан ажиллуулдаг тоглоом тоглож байхад нөхөр минь хажуугаар өнгөрөхдөө орондоо орох гэж байгаагаа хэлэв.

"Би удахгүй унтлаа" гэж намайг түүнд хэлэхэд,

"Чамайг хүрч ирэхэд чинь л итгэе дээ" гэж тэр хэллээ.

Би бодит бус үйлчлүүлэгчдэд зориулсан бодит бус ресторанд бодит бус хоол хийдэг тоглоом тоглож байсан юм. Би компьютерийн дэлгэцээ хараад, "Арай болоогүй байна, 15 минутын дараа хоол бэлэн болно" гэж хэллээ.

Би хүлээх зуураа цаг нөхцөөхийн тулд Халамжийн нийгэмлэгээс авснаас хойш ширээн дээр дэлгээстэй байсан *Миний хаант улсын охид: Халамжийн нийгэмлэгийн ажлын түүх* номыг уншихаар авав. Би өмнөх үгийг уншиж эхлэв. Гурав дахь хуудсан дээрээс би Халамжийн нийгэмлэгийн ес дэх ерөнхийлөгч Бэллэ С.Спаффордын хэлсэн дараах үгийг олж уншлаа.

"Өнөө үед жирийн эмэгтэй хүн хувийн ашиг сонирхлоо тодорхойлж, оролцдог бүхий л үйл ажиллагаагаа үнэлж дүгнэхэд тун гаргуун байж, нэн чухал зүйлээ нэн чухалд тавих, гавьяа шагнал нь хаана хамгийн агуу бөгөөд урт удаан хугацааных байна, түүн дээр онцгой анхаарах, өөрийгөө бага үр бүтээлтэй зүйлээс чөлөөлөх зэргээр амьдралаа энгийн байлгах алхмуудыг хийдэг" хэмээн тэрээр бичжээ.

Судруудаас гадна миний уншсан ямар ч зүйл надад ийм гүнзгий сэтгэгдэл төрүүлж байгаагүй юм. 30 гаруй жилийн өмнө нас барсан энэ эмэгтэй надад хандан ярьж байлаа. Түүний үгс тэр үед гэхээсээ өнөө үед илүү ач холбогдолтой байгаа мэт санагдав.

Би тэр даруй дахин хэзээ ч онлайн тоглоом тоглохгүй гэж шийдсэн юм. Би компьютерээ унтраагаад орондоо орж, гаргасан шийдвэрээ нөхөртөө хэлэв. Маргааш нь би компьютерээ асаасангүй. Харин би өдөр бүр энэ тоглоомыг тоглож, хэчнээн цагийг дэмий үрснээ тооцоолов.

Би өдрийн гурван цагийг 365-аар (жилийн нийт өдрөөр) үржүүлээд, 24-т (өдрийн нийт цагт) хуваасан. Би жилд 45.62 өдрийг дэмий үрснээ олж мэдээд, маш их цочирдож билээ. Тэрхүү үнэт цаг, өдрүүд мөнхөд үгүй болсон. Би тэдгээр цаг хугацааг судраа уншин, нөхөр хүүхдүүдтэйгээ хамт байж, бусдад үйлчлэхэд, эсвэл дуудлагаа биелүүлэхэд зориулж болох байсан.

Ерөнхий эрх мэдэлтнүүд Ерөнхий чуулган дээр энэ сэдвийг олон удаа хөнддөг. Гэсэн хэдий ч энэ нь надад хэзээ ч нөлөөлж байгаагүй бөгөөд би энэ сэдэв надад хамаагүй гэж боддог байлаа.

Ерөнхий эрх мэдэлтнүүд болон Бэллэ С.Спаффорд надад хандан ярьж байсан гэдгийг анзаарахад минь Ариун Сүнс тусалсанд би талархалтай байна. ■

Сэнди Хоусон, АНУ, Огайо

БИ ЯАГААД ТЭНД БАЙСНАА МЭДЭЭГҮЙ

Ээж бид хоёр орой залбираад дуусаж байлаа. Бид хоёр нэг нэгнээ тэврэч, "би чамд хайртай" гэж хэлцгээв. Дараа нь би унтлагын өрөө рүүгээ алхсан юм. Хаалганы бариулаас барих гэтэл гэнэт ээж минь маргааш нас барна гэсэн хүчтэй мэдрэмж надад төрөв.

Миний тархи, зүрх хоёр энэ бодлыг эсэргүүцэж байлаа. Ээжид минь яагаад ч тийм зүйл тохиолдохгүй. Тэр зүгээр байх болно.

Өрөөндөө ороод би өвдөг сөгдөн залбирч, ээжийнхээ талаарх мэдрэмжийг үнэн байж таарахгүй гэдгийг Тэнгэрлэг Эцэгт хэлэв. Би Түүнээс энэ бодлыг арилгаж өгөхийг хүссэн боловч арилсангүй. Би аав, ээжийнхээ өрөө рүү буцаж очоод, унтахаасаа өмнө ээжийгээ дахин нэг тэврэч, үнсмээр байна гэдгээ хэлэв. Бид дахин бие биедээ "би чамд хайртай" гэж хэлцгээгээд, би өрөө рүүгээ явсан. Тэр шөнө би нэлээн удаж байж унтсан юм.

Маргааш өглөө нь сэрээд би айж байлаа. Аз болоход ээж минь эрүүл саруул байж байв. Гэтэл ямар нэг зүйл тохиолдоно гэсэн нөгөө таагүй бодол миний толгойд байсаар байлаа. Тэр өдөр мацаг ба гэрчлэлийн цуглаан дээр ээж минь маш гайхалтай гэрчлэл хуваалцав.

Ариун ёслолын цуглааны дараа тэрээр Хүүхдийн хэсэгт заахаар явж, би Ням гаргийн анги руугаа орсон юм. Надад босоод, Ням гаргийн ангиас гар гэсэн бас нэгэн хүчтэй мэдрэмж төрөв. Би хүмүүсийн анхаарлыг татахыг хүсээгүй боловч ямар нэг зүйл намайг сандлаас минь босгож, хаалгаар гаргалаа. Хэдхэн минутын дараа би Хүүхдийн хэсэгт суугаад ээжийнхээ зааж буй хичээлийг сонсож байлаа. Би яагаад тэнд байснаа мэдээгүй ч, байх ёстой газраа байгаа гэдгээ мэдэж байв.

Тэр өдрийн үдээс хойш биднийг ахынхаа гэрт байж байтал ээж минь уушгины судас нь бөглөрснөөс болж ухаан алдан, нас барахаасаа өмнө сүүлчийн удаа миний нүд рүү ширтсэн юм. Тэнгэрлэг Эцэг Өөрийн тодорхой зорилго, шалтгааны учир намайг бэлтгэхийн тулд Ариун Сүнсээ илгээсэн байв. Тэдгээр өдөөлт нь ээжтэйгээ хамт байх хугацааг надад өгсөн. Хэрэв би намуун зөөлөн дуу хоолойг үл тоосон байсан бол энэ боломжоо алдах байсан юм.

Ээжийг нас барсны дараа болсон үйл явдлуудаас өмнө би Тэнгэрлэг Эцэгийн хайрыг ийм их мэдэрч байгаагүй билээ. Бидэнд Ариун Сүнсний бэлэг өгч, биднийг хайрладаг Тэнгэр дэх Эцэгтэй байгаа нь ямар их адислал вэ. ■

Амбер Чини, Алабама, АНУ

Би аав ээжийнхээ өрөө рүү буцаж очоод, унтахаасаа өмнө ээжийгээ дахин нэг тэврэч, үнсмээр байна гэдгээ хэлэв.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КАТЛИН ПЕТЕРСОН

Би тэр даруй усан онгоцны удирдах газар руу ярьж, аяллаа хоёр өдрөөр хойшлуулахыг гуйсан юм.

БИ РОТУМАД ОЧИХЫН ТУЛД ЗАЛБИРСАН

"*Вестерланд* өчигдөр явсан" гэж бэр эгч минь Фижигийн Нади олон улсын нисэх онгоцны буудал дээр биднийг угтах үедээ хэлэв.

Энэ мэдээг сонсоод миний урам хугарч, гуниглав. *MB Вестерланд* гэдэг нь биднийг ахын маань амьдардаг Ротума арал дээр хүргэж өгөх ёстой усан онгоц байсан юм. Ротума нь Фижигийн хамгийн том арал болох Вити Лэвүгээс ойролцоогоор 600 км зайд оршдог. Хэрэв усан онгоцноос хоцорвол дараагийн онгоц иртэл хэдэн өдөр, бүр хэдэн долоо хоног хүлээх хэрэгтэй болдог байв.

Нэг жилийн өмнө би эмээгийнхээ байшинд засвар хийхэд нь ахдаа туслахаар Ротумад очсон бөгөөд ажилтай холбоотой зүйл дээр түүнтэй санал зөрснөөс болоод тэндээс явчихсан юм. Одоо би түүнтэй нүүр тулан уулзаж, уучлалт гуйхыг хүсэж байлаа.

Миний эхнэр Аката бид хоёрыг Австралиас Фижи рүү нисэхээс нэг долоо хоногийн өмнө *Вестерланд* биднийг очихоос нэг өдрийн өмнө Ротума руу явна гэж үеэл дүү минь хэлсэн. Би тэр даруй усан онгоцны удирдах газар руу ярьж, аяллаа хоёр өдрөөр хойшлуулахыг гуйхад,

"Бид хүсээд ч хойшлуулж чадахгүй" гэсэн хариу өгөв. "Ротума арлын зөвлөл зоог бэлтгэсэн бөгөөд усан онгоц хуваарийн дагуу явах ёстой."

Надад нэг бодол төрж, би мацаг барьж, залбирахаар шийдлээ.

"Хайрт Тэнгэрлэг Эцэг минь, би Ротума явах тэр онгоцонд суухыг маш их хүсэж байна. Тэд аяллаа нэг эсвэл хоёр өдрөөр хойшлуулж чадахгүй боловч Танд үүнийг хийх хүч бий. Та онгоцон дээрх аль нэг эрэг шургийг сулруулж, аяллыг хойшлуулж өгнө үү? Би Ротумад очиж, ахтайгаа эвлэрэх хэрэгтэй байна" гэж залбирлаа.

Бид энэ таагүй мэдээг сонсоод, арлын нөгөө талын боомт руу явлаа. Гэтэл тэнд байхдаа нөгөө усан онгоцны хөдөлгүүрт асуудал гарсан бөгөөд аялалдаа гараагүй байгаа гэдгийг бид сонссон юм. Тэнгэрлэг Эцэг миний залбиралд хариулсан байв. Тос алдалтыг зогсоохын тулд нэг эрэг шураг биш харин хөдөлгүүрийг бүхлээр нь авах шаардлагатай болсныг бид мэдсэн юм.

Долоо хоногийн дараа онгоцыг аялалд гарах үед би тэнд суусан байлаа. Ротумад ирээд би ахыгаа тэврэч, уучлал гуйсан бөгөөд бидний харилцаа сэргэсэн юм. Энэ бол үнэхээр сайхан өдөр байлаа.

Би энэ гайхалтай сүнслэг тохиолдол болон Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээнд үргэлж талархаж байх болно. Энэ явдал гайхамшгууд өнөөдөр ч гэсэн тохиодог ба Тэнгэрлэг Эцэг амьд, бидний чин сэтгэлийн залбирлуудад хариулдаг бөгөөд залбирах, мацаг барих нь хамтдаа салшгүй байдаг, Ротума хэмээх жижиг арал дээр ч гэсэн сайн мэдээ үнэн байдаг гэдгийг гэрчилсэн юм. ■

Жон К.Муарор, Австрали, Нью Саут Уэльс

(Зохиогч нь нас барсан.)

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АЛЛЕН ГАРНС

Рандалл Л.Ридд
2013–2015 онд Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөхөөр үйлчилсэн

Үнэн хүсэлтэй

АМЬДРАХ НЬ

Би үнэн хүсэлтэй хандах нь ямар чухал болох талаар семинарын ангийн залуу суралцагч байхдаа мэдэж авсан. Багш маань бидэнд Мормоны Номыг унших даалгавар өгсөн юм. Хэрхэн ахиц гаргаж байгаагаа тэмдэглэхэд маань туслахын тулд тэрээр нэг талд нь бидний нэрийг, мөн дээд талд нь номуудыг жагсаасан хүснэгт хийсэн байв. Номыг унших бүрд нэрний ар талд од тавьдаг байлаа.

Эхэн үедээ би хүч чармайлт гаргаж уншдаггүй байсан бөгөөд удалгүй хоцорч байгаагаа ухаарав. Би ичсэндээ, мөн төрөлхийн шазруун зандаа хөтлөгдөн, уншиж эхэллээ. Од авах бүрд сайхан санагддаг байв. Од нэмэгдэх тусам би илүү их урамшиж, хичээлийн завсарлагаанаар болон сургуулиа тараад, мөн олдсон минут болгонд уншдаг болов.

Хэрвээ би ангидаа хамгийн түрүүлж уншиж дуусгасан гэвэл сайхан төгсгөл болох байсан ч түрүүлж чадаагүй юм. Мөн би түрүүлж дуусгахаас ч илүү сайн зүйл буюу Мормоны Номын талаар гэрчлэл олж авсан гэвэл зүгээр байхсан. Гэвч иим зүйл тохиолдоогүй. Би гэрчлэлтэй болоогүй. Харин би олон од л авсан. Би од авахыг хүсэж уншсан учраас однуудаа л авсан. Моронайн хэлснээр энэ нь л миний "үнэн хүсэл" байсан юм.

Мормоны Номын үнэн эсэхийг хэрхэн олж болохыг Моронай маш тодорхой тайлбарласан байдаг: "Мөн та нар эдгээр зүйлийг хүлээн аваад, та нар Бурхан, Мөнхийн Эцэгээс, Христийн нэрээр, эдгээр зүйлүүд үнэн эсэхийг асуухыг та нарт ухуулъя би; мөн хэрэв та нар Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, *үнэн хүсэлтэйгээр* асуух аваас, тэрбээр үүний үнэнийг Ариун Сүнсний хүчээр та нарт мэдүүлэх болно." (Моронай 10:4; тодруулгыг нэмж оруулав.)

Зөв шалтгаан

Эргэн санахад, Их Эзэн надад тун шударга хандсан байв. Би өөрийнхөө хайснаас илүү зүйлийг яагаад авна гэж бодож болох билээ? Үнэн хүсэлтэй хандах гэдэг нь зөв зүйлийг зөв зорилгоор хийхийг хэлдэг юм. Би зөв номыг *буруу* зорилгоор уншсанаа олж мэдэв.

Үнэн хүсэлтэй хандах гэдэг нь зөв зүйлийг зөв зорилгоор хийхийг хэлдэг юм.

Би олон жилийн дараа, номлолд гарах эсэхээ шийдэх гэж зүдэрч байхдаа Мормоны Номыг үнэн хүсэлтэйгээр уншсан юм. Би Мормоны Номыг үнэн хүсэлтэй уншсан тул энэ ном Есүс Христийн амьдралыг болон номлолыг гэрчлэх агуу зорилгыг биелүүлдэг болохыг мэднэ.

Үнэн хүсэл, Мормоны Номын талаар авсан сургамж хоёр нь

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ISTOCK/THINKSTOCK

бид бүгдийн амьдралын бүх хэсэгт хамаатай. Ихэвчлэн бид олон жилийн турш бий болсон загвар, дадал хэвшлийг юу ч бодолгүйгээр дагадаг. Бид хийж буй зүйлүүдээ биднийг хааш нь аваачиж байгааг анхааралтай бодож үздэггүй. Үнэн хүсэлтэй амьдрах нь бидний амьдралд утга учир, зорилго нэмдэг бөгөөд маш том өөрчлөлт авчирч чадна. Үнэн хүсэлтэй амьдрах гэдэг нь "яагаад" гэдгийг ойлгож, хийж буй үйлдлүүдийнхээ цаадах зорилгыг мэддэг байхыг хэлнэ. Сократ "Ухаарч ойлгоогүй амьдралыг туулж өнгөрүүлэх нь утга учиргүй хэрэг" гэж хэлсэн.[1] Цагаа юунд зарцуулдгаа бодож, өөрөөсөө үе үе "Яагаад?" гэж асууж байгаарай. Энэ нь зөвхөн өнөө маргаашийг биш, алсыг харах чадвараа хөгжүүлэхэд тань тусална. Ирээдүйгээ хараад, "Би үүнийг яагаад хийх ёстой гэж?" хэмээн асуух нь өнгөрсөн рүүгээ хараад, "Яагаад? Би үүнийг яах гэж хийв дээ?" гэж халаглахаас хамаагүй дээр.

Үнэн хүсэлтэй амьдрах гэдэг нь "яагаад" гэдгийг ойлгож, хийж буй үйлдлүүдийнхээ цаадах зорилгыг мэддэг байхыг хэлнэ. Сократ "Ухаарч ойлгоогүй амьдралыг туулж өнгөрүүлэх нь утга учиргүй хэрэг" гэж хэлсэн.

Их Эзэн та нарыг юу хийгээсэй хэмээн хүсдэг вэ?

Би залуу байхдаа бараг л номлолд явахгүй байхаар шийдсэн юм. Би коллежид нэг жил сурч, армид нэг жил алба хаасныхаа дараа орон нутгийнхаа эмнэлэгт рентген аппаратын техникчийн давгүй сайн ажилтай боллоо. Амьдрал сайхан байсан бөгөөд номлолд үйлчлэх нь шаардлагагүй юм шиг санагдаж байв.

Нэг өдөр эмнэлгийн нэгэн мэс засалч эмч Жэймс Пингри намайг өдрийн хоолонд урилаа. Биднийг ярилцаж байх зуур Пингри эмч намайг номлолд үйлчлэх бодолгүй байгааг мэдээд, яагаад гэж асуулаа. Би түүнд миний нас жаахан явчихсан болохоор номлолд гарахад оройтсон байх гэж хэлэв. Тэр наадах чинь номлолд үйлчлэхгүй байх ноцтой шалтгаан биш гэдгийг, мөн тэр анагаах ухааны сургуулиа төгссөнийхөө дараа номлолд үйлчилсэн гэдгээ надад хэлэв. Дараа нь тэр номлолынх нь ажил хэр чухал байсан талаар гэрчлэлээ надтай хуваалцсан юм.

Түүний гэрчлэл надад тун их нөлөөлсөн бөгөөд намайг урьд нь хэзээ ч залбирч байгаагүйгээрээ, *чин сэтгэлээсээ* залбирахад хүргэсэн юм. Би номлолд явахгүй байх олон шалтгаан олж болохоор байв. Би маш ичимхий байсан. Надад дуртай ажил байв. Надад номлолын дараа боломжгүй байх магадлалтай сургалтын тэтгэлэг авах боломж байв. Хамгийн гол нь армид алба хааж байхад маань намайг хүлээсэн найз охин минь байлаа. Тэр дахин хоёр жил намайг хүлээхгүй гэдгийг би мэдэж байв! Би миний шалтгаанууд үндэслэлтэй, мөн миний зөв болохыг баталж өгөхийг хүсэн, маш их залбирч билээ.

Гэвч миний хүсэж байсан шиг амархан, тийм эсвэл үгүй гэсэн хариулт надад ирсэнгүй. Тэгж байтал "Их Эзэн чамайг юу хийгээсэй хэмээн хүсэж байгаа бол?" гэсэн бодол надад орж ирсэн юм. Тэрээр намайг номлолд яваасай гэж хүсэж байгааг би хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болсон бөгөөд энэ нь миний амьдралын шийдвэрлэх мөч болсон юм. Би өөрийн хүслийг дагах уу, эсвэл Их Эзэний хүслийг дагах уу? Энэ бол бидний өөрсдөөсөө байнга асууж байвал зохих асуулт юм.

Би номлолд үйлчлэх шийдвэрээ дуртайяа гаргаж, Мексикийн Хойд номлолд үйлчлэхээр болов.

Мөнхийн үр дагаврууд

Гучин таван жил өнгөрсний дараа миний хүү намайг Мексик рүү түүнтэй хамт явахыг санал болгосон юм. Би заасан хүмүүсээс минь байж

ГЭРЭЛ ЗУРГИЙГ JUPITERIMAGES/STOCKBYTE/THINKSTOCK

юуны магад гэж бодов. Бид миний номлолын ажлаа эхлүүлсэн жижиг хотод очиж, ариун ёслолд нь суулаа. Нэг ч хүн олдсонгүй. Цуглааны дараа би бишопт заасан хүмүүсийнхээ жагсаалтыг үзүүлж, таньдаг хүн байгаа эсэхийг асуухад тэр бас нэг ч хүнийг таньсангүй. Би түүнтэй цуг жагсаалтыг харж, ямар ч амжилт олохгүй явсаар хамгийн сүүлчийн нэр болох Леонор Лопез де Энрикез дээр ирлээ.

"Өө тийм" гэж тэр хэлэв. "Энэ гэр бүл нөгөө тойрогт байдаг ч энэ байранд Сүмд явдаг. Тэдний ариун ёслол нь одоо болох учир тэд удахгүй ирэх байх" гэж хэллээ.

Биднийг хүлээгээд удаагүй байтал Леонор орж ирэв. Хэдийгээр тэр 70 гаруй нас хүрсэн ч, би түүнийг харангуут таньсан бөгөөд тэр ч бас намайг танив. Бид нулимс дуслуулан, удаан гэгч тэврэлдэж билээ.

Тэр надад "Бидний амьдралд сайн мэдээг авчирсан чамд талархлаа илэрхийлэхийн тулд чамайг эргэн ирээсэй хэмээн бид 35 жил залбирсан" гэж хэлсэн юм.

Гэр бүлийнх нь бусад гишүүнийг орж ирэхэд бид мөн тэврэлдэж, нулимс дуслуулцгаав. Бид ариун ёслолд оролцож байхдаа Леонорын хөвгүүдийн нэг нь уг тойргийн бишоп, ач хүү нь төгөлдөр хуурч, ач охин нь удирдаач болохыг, мөн Aароны санваартнуудын дунд хэд хэдэн ач хүү нь байгааг олж мэдсэн юм. Түүний охидын нэг нь гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнтэй гэр бүл болсон байв. Өөр нэг охин нь ойрхон байрлах тойргийн бишоптой гэр бүл болсон байв. Леонорын ихэнх хүүхэд номлолд үйлчилсэн байсан бөгөөд ач хөвгүүд нь мөн номлолд үйлчилсэн байв.

Леонор биднээс хавьгүй илүү сайн номлогч байсныг бид бас олж мэдэв. Өнөөдөр түүний үр хүүхдүүд сайн мэдээний талаар уйгагүй заасан түүний хүчин чармайлтыг талархан дурсан санадаг. Тэрээр хүүхдүүддээ хувь хүний олон жижиг сонголт нь хэсэг хугацаа өнгөрсний дараа бүрэн дүүрэн, зөвт, аз жаргалтай амьдрал руу хөтөлдөг болохыг заасан бөгөөд тэд ч бас тэдгээр зүйлийг бусдад заасан ажээ. Бүх хүнийг тооцож үзвэл, энэхүү гайхамшигтай гэр бүлийн хүчинд 500 гаруй хүн Сүмд нэгдсэн байна.

Энэ бүх үйл явдал үдийн хоолны үеэр болсон энгийн ярианаас эхэлсэн. Хэрвээ Пингри эмч өөрийн ажил эсвэл дэлхийн зүйлс дээр анхаарлаа илүү төвлөрүүлсэн байсан бол намайг яагаад номлолд гарахгүй байгаа талаар хэзээ ч асуухгүй байсан байх даа гэж би олонтоо боддог. Гэвч түүний анхаарал бусдад, мөн Их Эзэний ажлыг урагшлуулахад төвлөрсөн байсан юм. Түүний суулгасан үр өсөж урган, үр жимсээ өгч хуримтлагдсаар, эсвэл асар хурдацтай өсөж үржсээр байгаа билээ (Марк 4:20-ийг үзнэ үү). Миний номлол Их Эзэний хүслийг эрэлхийлэхийн мөнхийн үр дагаврын талаар надад зааж өгсөн билээ.

Мөнхийн зорилгоо сана

Би өөрийн амьдралыг эргэн харахдаа, номлолд явах шийдвэр гаргах нь надад яагаад тийм хэцүү байсан талаар их боддог. Миний анхаарал өөр зүйл рүү хандаж, мөнхийн зорилго руу чиглээгүй байсан учраас л надад хэцүү байж.

Миний хүсэл сонирхол Их Эзэний хүсэлтэй нийлэхгүй байсан юм. Хэрвээ нийлж байсан бол шийдвэр гаргахад амархан байх байлаа. Яагаад нийлэхгүй байсан юм бол? Би ням гарагт сүмдээ очиж, ариун ёслолоос хүртдэг байсан ч, үнэн хүсэлтэйгээр хүртдэггүй байв. Би залбирдаг байсан боловч үүний утга учирт анхаарал тавьдаггүй байлаа. Би судраа уншдаг байсан ч, тогтмол бус, мөн үнэн хүсэлтэйгээр уншдаггүй байв.

Та нар өмнө нь тогтмол хийж байгаагүй ч гэсэн зорилготой амьдрахад би та нарыг урамшуулж байна. Та нар өмнө нь хийсэн болон хийгээгүй зүйлийнхээ талаарх бодлуудад бүү бууж өгөөрэй. Бүх зүйлийг шинээр эхлүүлэхэд тань Aврагч туслаг. "Харин тэд *үнэн сэтгэлээсээ* наманчилж мөн өршөөлийг эрэлхийлэх болгондоо, тэд өршөөгддөг байлаа" хэмээн Их Эзэн хэлснийг санацгаая (Моронай 6:8; тодорхойлолтыг нэмж оруулав).

Одоо эхэл. Зорилготой амьдар. Хийж буй зүйлээ яагаад хийж байгаа болон энэ нь хаашаа хөтлөхийг ойлгодог бай. Эдгээр зүйлийг хийх үед таны хийж буй бүх зүйлийн хойно байх "Яагаад" гэх том асуултын хариултаас та Их Эзэнийг хайрладгийг, мөн таныг хайрлах Түүний агуу хайрыг таньж мэдсэн болохыг олж мэдэх болно. Та бүхэн төгс байдлыг болон Түүний хүслийг ойлгож, үүний дагуу үйлдэхийг эрэлхийлэх явцдаа хүн нэг бүр агуу их баяр баяслыг олох болтугай. ■

2015 оны 1-р сарын 11-нд Aйдахо дахь Бригам Янгийн Их Сургууль дээр болсон залуучуудад зориулсан дэлхий даяарх онцгой цугларалт дээр хэлсэн "Зорилготой амьдрах нь: Үнэн хүсэлтэй хандахын ач холбогдол" үгнээс авав. Бүрэн эхээр нь үзэх бол devotionals.lds.org хаягаар орно уу.

ЭШЛЭЛ

1. Socrates in Plato, *Apology* (2001), 55.

Итгэл ба үйлчлэл, мөн ганц талх

Ниссанка (Ниш) Муту Мудалигэ

Би 2007 онд сургуульд сурахаар Шриланкаас Армен руу нүүж ирсэн бөгөөд энд номлогчидтой танилцаж, жилийн дараа баптисм хүртсэн. Би баптисм хүртсэнийхээ дараа бүрэн цагийн номлолд үйлчлэхийг маш их хүсэж байв. Би хорин таван нас өнгөрсөн байсан болохоор номлолд үйлчлэх боломжгүй болсон байлаа. Гэтэл номлолын ерөнхийлөгч намайг богино хугацааны номлолд үйлчлүүлэхээр дуудав. Миний үүрэг хариуцлага бусад ахлагчтай хамт ажиллаж, сайн мэдээг номлох байв. Би энэ ажилдаа дуртай байлаа.

Эр зориг шалгасан сорилт

Тэр үед миний санхүүгийн байдал хүнд байсан. Удалгүй аавын минь бизнес дампуурч, тэр надад мөнгө явуулж чадахаа болив. Надад ердөө хэдхэн өдрийн хүнс авах мөнгө байсан. Их сургууль гэртэй минь ойрхон байсан ч номлолын оффис руу автобусаар 30 минут явж очихоор байв. Тийшээ очиж, буцаж ирэх тээврийн зардал 200 драм (0.50 ам.доллар) болдог байв.

Би номлолын үйлчлэлээ сайн хийхийг хүсэж байлаа. Нэг ахлагч надад хэдэн гишүүний гэрээр хамт айлчлах хүсэлт тавьж, төв салбарын байран дээр уулзъя гэхэд нь би 40 минут автобусаар явж хүрэх ёстой байсан ч за гэж хэллээ. Тэр үед надад ганцхан талх авах мөнгө л байсан. Би төв салбарын байр руу алхав. Энэ нь зуны халуун өдөр байсан учраас би замдаа амарч, ус уух хэрэгтэй байлаа. Би хоёр цаг гаруй алхаж ирэв. Гэртээ харихаар хоёр цаг алхах замдаа би сүүлийн зоосоороо талх авсан.

Илүү хүнд сорилт

Гэртээ ирээд удаагүй байтал хамт явсан ахлагч над руу залгав. Тэрээр “Ниш, дахиад залгасанд уучлаарай. Гэхдээ нэг гишүүн өвчтэй байна. Түүнд адислал өгөх үеэр миний хамтрагч байж болох уу?” гэж асуув. Би халуунд дөрвөн цаг алхаад, маш их ядарсан гэдгээ түүнд хэлэхийг хүссэн боловч зүрх минь үүнийг хориглов. Итгэл минь надад хүч чадал, зориг өгсөн учраас би очно гэж хэллээ.

Яг тэр үед өрөөний найз минь орж ирэв. Би номлолын оффис руу автобусаар явах зардлын мөнгө байгаа эсэхийг түүнээс асуув. Түүнд энэ сард хэрэглэх хоол хүнс авах л мөнгө байгаа учраас надад зээлдүүлж чадахгүй гэж тэр хэлэв.

Гэнэт би саяхан худалдаж авсан шинэ талхаа орж харлаа. Надад үүнээс өөр идэх юм байсангүй. Би талхаа авчраад, “Би энэ талхыг өнөөдөр худалдаж авсан. Чи энэ талхыг аваад оронд нь надад 100 драм өгч чадах уу?” гэж асуулаа. Тэр инээмсэглээд, тэгье гэж

Би гэр рүүгээ алхаж байхдаа ядарсан шинжгүй байлаа. Миний бодож байсан ганц зүйл бол нэгэн настай эмэгтэйн инээмсэглэл байсан юм.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДОУГ ФАККЭЛ

хэлсэн юм. Би мөнгийг аваад, автобусаар номлолын оффис руу явав.

Бид хоёр хэвтэрт орсон Сүмийн настай гишүүн эгчийнд очлоо. Тэр эгч бараг нүдээ нээж чадахгүй байсан ч над руу инээмсэглэв. Тэр надтай ярьж, залуу насныхаа дурсамжуудаас хуваалцсан юм. Биднийг гэрт нь ирсэнд тэр маш их баяртай байсан. Ахлагч бид хоёр хамтдаа түүнд адислал өгсөн. Тэр бидэн рүү дахин инээмсэглэх үед би түүний нүүрэн дэх гэрлийг харсан. Түүний охин олон сарын дараа ээжийнхээ инээхийг анх удаа харж байгаагаа хэлэв.

Би буцаад гэр рүүгээ хоёр цаг алхсан ч энэ удаа ядарсан шинжгүй байлаа. Миний бодож байсан ганц зүйл бол настай эмэгтэйн инээмсэглэл, бидний ярилцсан зүйлүүд байв. Тэнгэрлэг Эцэг намайг түүн дээр очоосой гэж хүссэн гэдгийг би мэдэрсэн. Магадгүй энэ нь түүний амьдралын сүүлийн өдрүүдэд түүнд илүү их аз жаргалыг өгсөн байж болох юм. Би тэр эгчийн гэрт айлчлах боломжтой байсандаа маш их талархалтай байсан. Би Тэнгэрлэг Эцэгээс тэр эмэгтэйг адислахыг гуйлаа. Түүнчлэн би санхүүгийн хүндрэлтэй байгаа үед маань намайг өдөр бүр хоолоор адислахыг Түүнээс хүссэн.

Дээрээс ирдэг адислалууд

Бурхан намайг орхиогүй. Тэр сарын турш найз минь надтай хоолноосоо хуваалцсан. Халаасандаа нэг ч төгрөггүй байсан ч би хоолгүй хоножүзээгүй. Би өдөр бүр номлолын оффис руу алхдаг байсан ба хэзээ ч ядардаггүй байлаа. Энэ золиослол нь намайг аз жаргалтай болгодог байсан.

Тэр сард би олон айлд өдөр, оройн хоолонд уригдсан. Нэг өдөр өрөөний найз бид хоёр мөнгөгүй, ганц жижиг талхнаас өөр юмгүй байсан. Тэр орой бид хоёр маш их өлсөж байлаа. Бид нэг найзаасаа мөнгө зээлэх санаатай гудамжаар алхаж явтал нэг машин ирж зогсов. Дотор нь хоёр армен хүн байв. Тэд биднийг хаанаас ирснийг асуув. Бид хоёр Шриланкаас ирсэн гэдгээ хэлэхэд тэд биднийг гэртээ оройн хоолонд урилаа. Тэд нар Шриланкийн тухай сонсох дуртай байсан бөгөөд бид сайхан оройн хоол идсэн.

Би Тэнгэрлэг Эцэгтээ хайртай бөгөөд Түүний надад тогтмол өгдөг адислалуудад талархдаг. Тэр надад туслахад бэлэн байдаг бөгөөд би өдөр бүр Түүний хайр, халамжийг мэдэрдэг. ■

Зохиогч нь Арменд амьдардаг.

Ахлагч Даллин Х.Өүкс
Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

ПОРНОГРАФЫН
УРХИНААС МУЛТРАХ НЬ

Бид бүгд сексийн утга агуулгатай хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зөв хандлагаар хандаж сурах ёстой.

Би арван жилийн өмнө Ерөнхий чуулган дээр порнографын талаар үг хэлсэн юм. Би порнографын аймшигт сүнслэг үр нөлөөний талаар сэрэмжлүүлсэн бусад удирдагчийн дуу хоолойтой өөрийн дуу хоолойг нэгтгэсэн. Би дэндүү олон эрэгтэйчүүд, мөн хөвгүүд “хууль бус бэлгийн харилцааг сурталчилсан ном сонин”[1] үзсэнээс болж хохирсон тухай анхааруулсан. Порнографын бүх төрөл нь хилэнцэт бөгөөд энэ нь сүнслэг мэдрэмтгий чанарт хөнөөлтэй байдаг ба санваарын хүчийг ашиглах чадварыг сулруулж, мөн эрхэм нандин харилцаануудыг сэвтүүлдэг.

Одоо 10 жил өнгөрөхөд, олон хүн бошиглогчдын сэрэмжлүүлгийг анхааран, порнографын аюулаас зайлсхийж, цэвэр үлдэж чадсанд би талархаж байна. Мөн олон хүн бошиглогчдын урилгыг анхааран сонсож, порнографаас татгалзан, шаналж шархалсан зүрх сэтгэлээ анагаан, харилцаагаа засаж, мөн дагалдагчийн замаар урагшилж байгаад талархаж байна. Гэсэн хэдий ч бидний дундаас зарим хүн, ялангуяа залуу эрэгтэйчүүд, тэр бүү хэл залуу эмэгтэйчүүд порнографын урхинд орооцолдож байгаа явдалд тун их санаа зовж байна.

Порнографын асуудал улам бүр нэмэгдэж байгаагийн гол шалтгаан бол өнөө үед бэлгийн харьцааг харуулсан үг, зураг, нөлөө хаа сайгүй байна. Тэдгээр нь кино, телевизийн нэвтрүүлгүүд, олон нийтийн сүлжээ, мессеж, утасны аппликейшн, зар сурталчилгаа, ном, дуу хөгжим болон өдөр тутмын харилцан ярианд гарч байна. Улмаар бид бүгдээрээ секс өнгө аястай мэдээллүүдээр тогтмол бөмбөгдүүлж байна.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ DOMIBNIC/ISTOCK/THINKSTOCK

Даруухнаар Их Эзэн рүү эргэх нь тодорхой үнэнүүдийг хүлээн зөвшөөрөхөд хүнийг хөтөлдөг ба эдгээр үнэнийг бүрэн ойлгосон үед хүч чадал ирж, ичгүүрийн мэдрэмж арилдаг.

I. Порнографт холбогдох түвшин

Газар авч буй энэ хилэнцтэй тэмцэхэд туслахын тулд порнографт холбогдох хэд хэдэн өөр төрлийн түвшингүүдийг болон тэд бүгдэд хэрхэн хариу үйлдэл үзүүлж болохыг үзүүлмээр байна.

Хэдэн жилийн өмнө порнографын талаарх бидний зөвлөгөө нь хүмүүсийг анх удаа үзэхээс сэрэмжлүүлэх эсвэл донтолтоос ангижрахад нь туслах тал дээр голлон анхаарч байсан. Эдгээр хүчин чармайлт нь чухал хэвээрээ байгаа боловч өнгөрсөн туршлага, одоогийн нөхцөл байдлуудаас үүдэн, порнографаас зайлсхийхээс эхлээд донтолт хүртэлх бүх л түвшинг хамарсан зөвлөгөө хэрэгтэй байгаа нь харагдаж байна. Порнографт автах явдлыг авч үзэхдээ: (1) санамсаргүй байдлаар өртөх, (2) зарим тохиолдолд хэрэглэх, (3) тогтмол хэрэглэх, мөн (4) өөрийн мэдэлгүй хэрэглэх (донтолт) гэсэн дөрвөн өөр төрлийн түвшин дээр анхаарал төвлөрүүлэх нь тустай юм.

Есүс Христийн ач ивээлээр дамжуулан бүх хүн өршөөгдөн, өөрчлөгдөх хүч чадлыг хүлээн авч чадна.

1. **Санамсаргүй байдлаар өртөх.** Хүн бүр л порнографыг санамсаргүй байдлаар үзсэн гэж би бодож байна. Бид энэ үед л нүүр буруулах хэрэгтэй бөгөөд цааш үзэхгүй бол энэ нь нүгэл биш. Энэ нь наманчлал гэхээсээ илүү засаж залруулах шаардлагатай алдаатай адил юм.[2]
2. **Заримдаа үзэх.** Порнографыг заримдаа эсвэл бүр тогтмол ашигладаг байж болох ч энэ нь санаатай үйлдэл байдаг бөгөөд хилэнцэт үйлдэл юм.

   Порнограф нь бэлгийн харьцааны хүчтэй мэдрэмжүүдийг өдөөж, оргилуулдаг. Бүтээгч Өөрийн мэргэн зорилгын тулд эдгээр мэдрэмжийг бидэнд өгсөн боловч эдгээрийг зөвхөн гэрлэсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд илэрхийлэх ёстой гэсэн зарлигуудыг өгсөн. Порнограф нь бэлгийн харьцааны зөв илэрхийллийг гутааж, гэрлэлтээс гадуурх бэлгийн харьцааг хөхиүлэн дэмждэг. Порнограф үздэг хүмүүс амьдралыг бүтээх эсвэл устгах асар их хүчинд хөнгөмсөг хандаж байгаа хэрэг юм. Тийшээ бүү яв!

   Порнографыг санаатай, хэчнээн гэм зэмгүйгээр эсвэл ховор тохиолдолд үздэг байсан ч энэ нь үргэлж илүү ойр ойрхон үзэх хүслийг төрүүлж, ингэснээр бэлгийн харьцааны мэдрэмж болоод зан араншинд автуулах аюултай. Эрдэмтэд садар самуун утга агуулгатай зураг тархинд бэлгийн харьцааны мэдрэмжийг ихэсгэдэг бодис ялгаруулдаг бөгөөд энэ нь бэлгийн зан хандлагыг өөгшүүлдэг гэдгийг нээжээ.[3] Ямар ч төрөл эсвэл түвшний бай, аливаа ёс суртахуунгүй бэлгийн зан авир нь хүний дотор бат бөх гэгчийн ичих мэдрэмжийг төрүүлдэг байна.
3. **Тогтмол үзэх.** Порнографыг санаатай тогтмол үзэх нь хэрэглээг зуршил буюу "өөрийн мэдэлгүй хийх хэмжээнд хүртэл үргэлжилдэг зан авирын загвар"[4] болгодог. Ийм зуршилтай болсон хүмүүс сэтгэл ханамж авахын тулд улам л илүү үзэхсэн гэсэн хэрэгцээг мэдэрдэг.
4. **Өөрийн мэдэлгүй хэрэглэх (донтолт).** Хүний зан авир "хараат байдалд" (энэ нь хар тамхи, архи, өөрийн мэдэлгүй мөрийтэй тоглох гэх мэт зүйл дээр хэрэглэгддэг анагаах ухааны хэллэг) орсон үедээ донтолтын шинжтэй болдог бөгөөд "амьдралын бусад бүх зүйлээс илүү чухал," "давшгүй албадлага" болж хувирдаг.[5]

II. Эдгээр түвшинг ойлгохын ач холбогдол

Бид эдгээр өөр түвшинг таньснаараа порнографыг үздэг хүн бүр түүнд донтсон байдаггүй гэдгийг ойлгодог. Чухамдаа, порнографт холбогдсон ихэнх залуу эрэгтэй, эмэгтэй донтоогүй байдаг. Энэ ялгааг ойлгох нь туслахыг хүссэн эцэг эх, эхнэр нөхөр, удирдагчдад төдийгүй уг асуудалтай тэмцэж буй хүмүүст тустай юм. Хариулт нь энд байна.

Нэгдүгээрт, хүн санамсаргүй байдлаар өртөхөөс эхлээд зарим тохиолдолд хэрэглэх эсвэл тогтмол хэрэглэх, мөн (4) өөрийн мэдэлгүй хэрэглэх (донтолт) гэх

мэтээр илүү гүнзгий түвшинд орох тусам үүнээс ангижрахад төдий чинээ хэцүү байх болно. Хэрэв бүх зан төлөвийг донтолт гэж буруу ангилбал порнограф үздэг хүн сонгох эрхээ болон асуудлыг давж гарах чадвараа алдсан гэж бодож магадгүй. Энэ нь засрах, наманчлах шийдвэрийг сулруулж болно. Нөгөө талаас, асуудал хэр ноцтой байгаа талаар тодорхой ойлголттой болж, тухайн байдал нь бодож байсан шиг байнгын эсвэл архаг болоогүй гэдгийг мэдэх нь хүнд үүнийгээ зогсоож, мөн наманчлах найдвар, сонгох эрхээ ашиглах нэмэлт чадварыг өгч болно.

Хоёрдугаарт, нүгэлт зан авирын бүх хэлбэрийн адилаар порнографыг санаатай үзэх нь Ариун Сүнсийг холдуулдаг. Үүнийг мэдэрсэн зарим хүн наманчлах ёстой гэсэн өдөөлтийг мэдэрдэг. Бусад хүн харин ичиж мөн худал хэлэн, гэм буруугаа нуухыг хичээдэг. Тэд түүнчлэн ичиж зовж эхэлдэг бөгөөд энэ нь тэднийг өөрсдийгөө үзэн ядахад хүргэдэг. Ийм зүйл тохиолдвол, тэд Сатаны хамгийн аймшигтай худал зүйлүүдийн нэгэнд итгэж эхлэх болно. Энэ бол тэдний хийсэн эсвэл хийж буй зүйл нь тэднийг муу хүн, Аврагчийн ач ивээлийг хүртэх зохисгүй, наманчлах боломжгүй болсон гэх мэхлэлт юм. Энэ нь зүгээр л үнэн биш. Бид Аврагчаас болон Түүний Цагаатгалаас тусламж авахад хэзээ ч оройтдоггүй.

Эцэст нь, порнографын байнгын эсвэл зуршил болсон хэрэглээг донтолт гэж нэрлэхгүй байх нь чухал. Яагаад гэвэл энэ нь нөхцөл байдлыг, эсвэл шаардлагатай наманчлал, ангижрах үйл явцын бүрэн мөн чанарыг оновчтой дүрсэлдэггүй. Хүн үйл явцын аль хэсэгт байгааг илүү сайн ойлгох нь үүнээс ангижрахад ямар ямар үйлдэл шаардлагатайг илүү сайн ойлгоход туслах болно.

III. Порнографаас зугтах нь

Одоо хувь хүмүүсийг порнографын хавхнаас хэрхэн зугтаж мөн ангижирч болох талаар ярилцъя. Энэ нь порнограф үздэгтэйгээ тэмцэлдэн, ялах гэж хичээж буй хүмүүст туслаад зогсохгүй, тэдэнд тусалдаг эцэг эх, удирдагчдад тус болох болно. Хүмүүс энэ сэдвээр эцэг эх, удирдагчидтайгаа ярилцвал порнографаас зайлсхийж мөн ангижрахдаа илүү амжилттай байх болно.[6]

Порнографыг санаатайгаар үзэх нь аль түвшинд байгаагаас үл хамааран эдгэрэл, цэвэр ариун байдал, наманчлалд хүрэх замаар явахдаа даруу байх, шавь байх, мөн өөрчлөгдөх хувийн төлөвлөгөө, хариуцлагатай

Эдгээр үнэний дагуу үйлдэх нь хүнээс Их Эзэн Есүс Христийн шавь шиг амьдрах мөн ирээдүйд учрах уруу таталтуудыг эсэргүүцэхэд тэднийг цэвэршүүлж мөн хүчирхэгжүүлдэг зүйлүүдийг хийх амлалтыг дахин өгөхийг шаарддаг.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ MAJIVECKA/ISTOCK/THINKSTOCK

байдал ба дэмжлэг, итгэлтэйгээр тэвчих гэсэн үндсэн зарчмуудыг дагах шаардлагатай юм.

А. Даруу байдал

Порнограф болон үүнтэй холбоотой зан авиртай тэмцэн, үнэхээр ялахын тулд хүмүүс даруу байдлыг хөгжүүлэх хэрэгтэй (Ифер 12:27). Даруухнаар Их Эзэн рүү эргэх нь тодорхой үнэнүүдийг хүлээн зөвшөөрөхөд хүнийг хөтөлдөг ба эдгээр үнэнийг бүрэн ойлгосон үед хүч чадал ирж, ичгүүрийн мэдрэмж арилдаг. Эдгээр үнэний заримаас харуулав:



Асуудал хэр ноцтойгоос шалтгаалан хүмүүс сул дорой болох үедээ хэзээ ч ярилцаж болох, мөн өөрсдийг нь хариуцлагатай байлгаж чадах итгэлтэй, туршлагатай хүний юм уу мэргэжлийн зөвлөхийн дэмжлэгийг хүсэж болно.

- Бидний хүн нэг бүр нь Тэнгэрлэг Эцэгийн хайртай хүүхэд юм.
- Бидний Аврагч, Есүс Христ хүн нэг бүрийг хайрладаг ба мэддэг.
- Аврагчийн Цагаатгал Бурханы бүх хүүхдэд нөлөөлдөг.
- Есүс Христийн ач ивээлээр дамжуулан бүх хүн өршөөгдөн, өөрчлөгдөх хүч чадлыг хүлээн авч чадна.
- Бидний хүн нэг бүрд Цагаатгалын хүчийг ашиглах боломж олгодог үнэлж баршгүй сонгох эрх байдаг.
- Порнографтай тэмцэж буй хүмүүс энэ тэмцэлд өөр хүмүүс амжилт гаргасан гэдэг баттай үнэнээс найдвар олж авч чадна.
- Порнограф нь хилэнцэт зүйл боловч үүнийг үзэх нь хүнийг хилэнцэт болгодоггүй.
- Ямар ч хүн порнографын хавхнаас зугтаж, бүрэн ангижирч чадах боловч энэ нь зөвхөн Цагаатгалын хүчийг ашигласнаар боломжтой болдог.
- Порнографын хэрэглээг бүрэн наманчлахад зүгээр нэг хийхээ болихоос ч илүү зүйлийг хийх шаардлагатай болдог. Ийм наманчлал нь Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан зүрх сэтгэлийн өөрчлөлтийг шаарддаг.

Эдгээр үнэнийг хүлээн зөвшөөрөх нь тэдгээрийн дагуу үйлдэхэд хүнийг бэлтгэдэг бөгөөд энэ нь наманчилж мөн ангижрахад хэрэгтэй өөрчлөлтүүдийг хийх Их Эзэний тусламжийг хүлээн авах үүд хаалгыг нээдэг.

Б. Шавь байх нь

Эдгээр үнэний дагуу үйлдэх нь хүнээс Их Эзэн Есүс Христийн шавь шиг амьдрах мөн ирээдүйд учрах уруу таталтуудыг эсэргүүцэхэд тэднийг цэвэршүүлж мөн хүчирхэгжүүлдэг зүйлүүдийг хийх амлалтыг дахин өгөхийг шаарддаг. Үүнд өдөр тутам утга учиртай залбирах, судраас судлах, сүмийн цуглаануудад оролцох, үйлчлэл хийх, мацаг барих, мөн (бишоп зөвшөөрсөн үед) ариун ёслолоос хүртэх, ариун сүмд шүтэн бишрэх гэх мэт шашны зан үйлүүдийг хийнэ гэсэн амлалт өгөх шаардлагатай.

В. Хувийн төлөвлөгөөн дэх амлалт

Есүс Христийн даруухан дагалдагчид порнограф үзэхэд уруу татдаг гүн мэдрэмж, нөхцөл байдал, хүрээлэн буй орчноо таньж мэдэх чадварыг хөгжүүлнэ. Эдгээр өдөөгч хүчин зүйлсийг үнэлж дүгнэснийхээ дараа тэд өөрсдөдөө туслах, тэдгээрээс зугтах төлөвлөгөө боловсруулна.

- Өдөөгч ба хийх хүсэл төрүүлэх үеүдийг таньж мэд.
- Уруу таталтаас татгалзахад тэдэнд туслах тодорхой үйлдлүүдийг бий болго.
- Бодол санаа, эрч хүчээ Их Эзэн рүү хандуул.
- Зөв шударга амьдрах тэдний хувийн амлалтыг хүчирхэгжүүлэх өдөр тутмын тодорхой үйлдлүүдийг тоймлон гарга.

Хувийн төлөвлөгөө гаргаж байхдаа хувь хүмүүс Сүмийн санал болгож буй онцгой сайн эх сурвалжуудыг ашиглах хэрэгтэй. Жишээлбэл, Сүмийн overcomingpornography.org хэмээх вэбсайт нь хувь хүмүүс, тэднийг дэмждэг гэр бүлийнхэн, санваарын удирдагчдад зориулсан материалыг агуулсан байдаг. Үүнээс гадна, Сүмд хэрэгждэг Донтолтоос ангижрах хөтөлбөр нь аль ч

ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ INGRAM PUBLISHING/ISTOCK/THINKSTOCK

төрлийн донтолттой тэмцэж буй бүх гишүүнд нээлттэй ба тэдний гэр бүлүүдэд ч бас тус болох юм.

Г. Хариуцлагатай байдал ба дэмжлэг

Өөрсдөд нь Аврагч хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрдөг Есүс Христийн даруухан дагалдагчид тэдний санваарын удирдагч байхаар Их Эзэнээр дуудагдсан мөн наманчлах боломж олгоход шаардлагатай түлхүүрүүдийг атгадаг бишопынхоо тусламжийг эрэлхийлдэг. Хэрэв тухайн хүн зөвшөөрч, бишоп сүнслэгээр өдөөгдвөл, бишоп уг хүнтэй хамт ажиллаж мөн түүнд туслах хүнийг дуудаж болно. Аль ч нөхцөл байдалд байснаас үл хамааран ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн (1910–2008) өгсөн дараах зөвлөгөө тус болно:

"Өөрийг тань боолчилсон донтолтоос салгаж өгөхийг бодгалийнхаа гүнээс Их Эзэнээс гуй. Мөн та нар бишопынхоо удирдамжийг эрэлхийлж, шаардлагатай бол мэргэжлийн хүнээс зөвлөгөө авах зоригтой байх хэрэгтэй."[7]

Асуудал хэр ноцтойгоос шалтгаалан хүмүүс сул дорой болох үедээ хэзээ ч ярилцаж болох, мөн өөрсдийг нь хариуцлагатай байлгаж чадах итгэлтэй, туршлагатай хүний юм уу мэргэжлийн зөвлөхийн дэмжлэгийг хүсэж болно.

Бидний хүн нэг бүрд Цагаатгалын хүчийг ашиглах боломж олгодог үнэлж баршгүй сонгох эрх байдаг.

Д. Итгэлтэй тэвчих

Наманчилж, мөн порнографын асуудлаас ангижирсан хүмүүс үргэлжлүүлэн сонор сэрэмжтэй байх ёстой. Учир нь чөтгөр тэдний сул талыг ашиглахыг оролдох болно. Зайлсхийхийн тулд чадах бүхнээ хийж байгаа ч гэсэн санамсаргүй өртөх тохиолдол гарч болно. Хүмүүс амьдралынхаа турш Бурханаас өгөгдсөн бэлгийн мэдрэмжээ хэрхэн хянахыг сурч, мөн цэвэр ариун байх эрмэлзлээ хадгалах ёстой.

IV. Бүх хүнд нигүүлсэнгүй байх нь

Порнографын урхинд орсон хүмүүст хэрхэн хандах тухай одоо хэдэн үг хэлье. Бид бүгдэд Есүс Христийн Цагаатгал хэрэгтэй. Порнографтай тэмцэж буй, хэрэгтэй зарчим, ангижрах алхмуудыг хийж буй хүмүүст бидний нинжин сэтгэл болоод хайр хэрэгтэй. Тэднийг битгий буруутгаарай. Тэд хилэнцэт биш бөгөөд тэдэнд найдвар бий. Тэд бол Тэнгэрлэг Эцэгийн маань охид, хөвгүүд. Тэд зөв бөгөөд бүрэн дүүрэн наманчилснаараа бүх гэрээ ба Бурханы амласан ариун сүмийн адислалуудыг авахуйц цэвэр, ариун, мөн зохистой болж чадна.

Гэрлэх цаг нь ирэхэд гэрлэх хүнээ анхааралтай сонгож, мөнхийн хань байж чадах, Их Эзэний өмнө цэвэр мөн ариун сүмд орохуйц зохистой хүнийг сонгоход би залуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг урамшуулж байна. Порнографын асуудлаа бүрэн наманчилсан хүмүүс эдгээр адислалыг авах нь зохистой юм.

V. Дүгнэлт

Бид амьдралынхаа турш садар самуун утга агуулга бүхий зүйлстэй таарах болно. Бид Түүний Сүнсийг үргэлж өөрсөдтэйгөө хамт байлгах (С ба Г 20:77) болно гэсэн ариун ёслолын гэрээнээс ирдэг баталгааны тусламж зэрэг Аврагчийн удирдамжтайгаар үргэлж зөв хариу үйлдэл үзүүлж чадна. Бид өөрсдийн шүтэн биширдэг Түүний адислалуудыг хүлээн авахын тулд үүнийг хийх ёстой гэдгийг би гэрчилж байна. Үүнийг хийснээр бид Аврагчийн амар амгаланг илүү бүрэн дүүрэн хүлээн авч, өргөмжлөлд хүрэх зам дээр үлдэх болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Даллин Х.Өүкс, "Pornography," *Лиахона,* 2005 оны 5-р сар, 87–90-ийг үзнэ үү.
2. Даллин Х.Өүкс, "Sins and Mistakes," *Ensign,* 1996 оны 10-р сар, 62–67-г үзнэ үү.
3. Donald L. Hilton Jr., M.D., "Pornography Addiction—a Supranormal Stimulus Considered in the Context of Neuroplasticity," *Socioaffective Neuroscience and Psychology,* vol. 3 (2013), socioaffectiveneuroscipsychol.net/index.php/snp/article/view/20767; see also "Porn Changes the Brain," fightthenewdrug.org-ийг үзнэ үү.
4. *Webster's Encyclopedic Unabridged Dictionary of the English Language* (1989), "habit."
5. *American College of Physicians Complete Home Medical Guide* (1999), 564.
6. Үүнээс гадна, залуучууд ба тэдний эцэг эхчүүд нөхөн үржихүйн талаар илэн далангүй боловч болгоомжтой ярилцах ёстой. Бэлгийн харьцааны тухай эцэг эхээсээ бус, харин үеийнхнээсээ сонссон өсвөр үеийнхэн энэ талаарх мэдээллийг порнографаар дамжуулан авах магадлал өндөр байдаг.
7. Гордон Б.Хинкли, A Tragic Evil among Us," *Лиахона,* 2004 оны 11-р сар, 62.

ЗӨВ ГАЗАР ЗӨВ ЦАГТАА

НЯМ ГАРГИЙН ХИЧЭЭЛҮҮД

Энэ сарын сэдэв:
Христтэй илүү адил болох нь

Та нарын хийсэн эсвэл хэлсэн зүйл хэн нэгэнд яг хэрэгтэй зүйл нь байсан гэдгийг та нар сонсож байсан уу? Заримдаа ийм зүйл тохиолддог. Учир нь Тэнгэрлэг Эцэг та нарыг яг зөв мөчид хэн нэгэнд туслуулахаар явуулдаг. Та нар Сүнстэй ойр байсан учраас Тэнгэрлэг Эцэгээс ирсэн тэр өдөөлтийг таньж чадсан гэсэн үг. Зохистой бөгөөд бусдад туслах хүсэлтэй бай. Учир нь Тэрээр та нарыг хэзээ, хэн нэгний тэнгэр элч болгон явуулахыг та нар мэдэхгүй.

Ийнхүү үйлдсэн хоёр хүний түүхийг харуулав:

АВТОМАШИНЫ ЗОГСООЛЫН ТАСАЛБАР

Фатима Роча Гутиеррез

Би сүмийн зарим найзтайгаа хамт кино үзэхээр явав. Биднийг их дэлгүүр рүү орох үед бидэнд автомашины зогсоолын тасалбар өгсөн юм. Кино дууссаны дараа бид зогсоолын тасалбараа алга болгосноо мэдэв. Бид эхлээд тасалбарын төлбөрийг төлнө гэж бодсон боловч бидний хэнд нь ч 180 песо байсангүй.

Зогсоолын төлбөр төлөхгүй бол машинаа дэлгүүр дээр үлдээж, ачуулах ба бүр их торгууль төлөх болно. Миний найзууд, ялангуяа машин жолоодож явсан найз минь сэтгэлээр унасан байв. Учир нь уг машин аавынх нь байжээ. Би залбирахаар хэдэн алхам холдлоо. Би Тэнгэрлэг Эцэгээс бидэнд асуудлаа шийдэж, гэртээ аюулгүй харих арга зам өгөхийг бүхий л итгэл, даруу байдлаараа гуйв. Залбирч дууссаны дараа юу тохиолдсон талаар би хэзээ ч мартахгүй.

Машин руу алхаж байхад хэн нэгэн намайг нэрээр минь дуудав. Энэ бол дунд сургуулийн найз Франциско байлаа. Тэр надаас юу хийж байгааг маань асууж, би юу болсон талаар түүнд хэлэв. Тэр шууд л хэтэвчээ гаргаж ирээд, алдагдсан тасалбарын төлбөрийг төлөх хангалттай мөнгийг надад өгсөн. Энэ сайхан сэтгэлийн үйлдэл нь Тэнгэрлэг Эцэгт хандсан залбирлын минь хариулт байсан.

Франциско ямар их тус хүргэснээ мэдэхгүй байж болно. Гэхдээ би үүнд нь насан туршдаа талархаж явах болно.

Заримдаа Тэнгэрлэг Эцэг бидний залбиралд гайхалтай байдлаар хариулдаг бөгөөд тохиолдлын зүйл гэж байдаггүй. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр биднийг төгс мэддэг ба бидний амьдралд тусалдаг.

Бид зөв шударга амьдарвал, гагцхүү Тэнгэрлэг Эцэгийн өгч чадах олон адислалыг, “хэрэв



[бид] эдгээр зүйлийг хийх аваас эцсийн өдөр өргөгдөх болно” (Алма 37:37) гэсэн Түүний амлалтыг хүлээн авч чадна гэдгийг би мэднэ. ■

Зохиогч нь Мексикийн Баяа Калифорнид амьдардаг.

ЦАГАА ОЛСОН ДУУДЛАГА

Чен Чин Чуан

Би бага байхдаа Бурхан байдаг гэдэгт итгэдэггүй байсан. Миний амьдрал үймээн самуунаар дүүрсэн байсан бөгөөд хамгийн хүнд үеүдэд би амиа хорлох талаар ч бодож байв. Тэр үед номлогчид хаалгыг минь тогшсон юм. Надад хамгийн хэрэгтэй зүйл бол сайн мэдээ байсан. Би яг л соронз шиг үүнд татагдсан.

Сүмийн гишүүн болсны дараа саад бэрхшээл маань алга болоогүй ч би чөтгөрийн нөлөөг эсэргүүцэх илүү хамгаалалттай болсон байв. Би амьдралдаа анх удаа аз жаргал ямар байдгийг мэдэрсэн.

Гэсэн хэдий ч сэтгэл санааны хямрал тийм ч амар салаагүй юм. Нэг удаа би дахин бууж өгөхийг хүсэж байлаа. Тэр үед бишопын эхнэр Тин эгч над руу утасдав. Тэр над руу залгах хэрэгтэй гэсэн мэдрэмж төрсөн гэдгээ хэлсэн. Тэр намайг ямар байгааг асуув. Би түүнд сэтгэлээ уудлан ярьж билээ. Миний хувьд тэр Бурханаас илгээгдсэн тэнгэр элч байсан юм.

Энэ явдал надад үнэхээр урам зориг өгсөн. Миний итгэл хүчирхэгжсэн. Би үхлийг ялж чадах юм шиг санагдаж байлаа. Би Алма 36:2–3-т гардаг шиг чөлөөлөгдсөн мэт мэдрэмжтэй байв:

“Тэд дарангуйлалд байлаа, . . . мөн Бурханаас өөр хэн ч тэднийг чөлөөлж чадахгүй байв. . . .

“. . . Бурханд найдлага тавьсан хэн боловч өөрсдийн зүдгүүрүүдэд, мөн өөрсдийн бэрхшээлүүдэд хийгээд өөрсдийн зовлонгуудад дэмжигдэх болно, мөн эцсийн өдөр өргөгдөх болно гэдгийг би мэднэ.”

Надад саад бэрхшээл тулгарч байгаа хэдий ч би амар дийлдэхгүй. Бурхан намайг бүхий л бэрхшээл, зовлон шаналалтай үед маань дэмжсээр ирсэн. Тэр намайг сүнслэг шорон, боолчлол, бүр үхлээс аварсан. Тэр бол миний Аврагч. ■

Зохиогч нь Тайваний Тайчунд амьдардаг.



БУРХАН БИДНИЙГ ХАРЖ ХАНДДАГ

“Бурхан биднийг ажиглаж, бидний дээрээс харж байдаг. Гэвч ингэхдээ бидний хэрэгцээг ихэвчлэн өөр хүнээр дамжуулан хангадаг. Тиймээс, бид хаант улсад бие биедээ үйлчлэх нь нэн чухал юм.

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985), *Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* (2006), 82.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРАЙН БИЙЧ

ТАНЫ АМЬДРАЛЫН НОМ

Та үүн дотор юу бичих вэ?

Өдөр бүр шинэ хуудас нээгддэг. Хуудас болгон дээр “Би үүнийг хийсэн ч болоосой” гэж биш, харин “Би үүнийг хийсэндээ баяртай байна” гэж бичигдсэн байхаар амьдар.

(Л.Том Пэрри, “How to Fill Your Book of Life,” *Liahona,* 2014 оны 2-р сар, 61.)

ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ВЭЛДЭН С.АНДЭРСЭН, ТРАВИС С.ДЭМИНГ, ЧЭРИЛ И.ЖОНСОН; STOCK PHOTOGRAPHS © HEMERA/THINKSTOCK, PHOTODISC/THINKSTOCK, БА ISTOCK/THINKSTOCK

Эхлэл 1:26–27

Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн гэдэг нь юу гэсэн утгатай вэ?



БУРХАНЫ ДҮР ТӨРХ

"Өөрөөсөө илүү хүч чадалтай нэгэн байдаг гэдгийг мэдэх нь хүний үнэ цэнийг бууруулах бус, харин нэмэгдүүлдэг. Бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн гэдгээ ойлгох юм бол Түүнд залбирч хандах нь хэцүү түвэгтэй бус болохыг мэдэх болно. . . . Итгэлээр олж авдаг энэ мэдлэг нь дотоод тайван байдал болоод асар их амар амгаланг авчрах болно."

Томас С.Монсон, "The Lighthouse of the Lord," *Ensign,* 1990 оны 11-р сар, 95-96.

БИД

Энэ үг олон тоон дээр хэрэглэгдсэн байгаа нь Бурхан өөр хүнтэй ярьж байгаа юм шиг сонсогдож байна. Тэрээр үнэхээр өөр хүнтэй ярьж байгаа юм. Иосеф Смит "Эхлэлд, Бурхдын тэргүүн Бурхдын зөвлөлийг хуралдуулж, тэд цуглаж, дэлхийг бүтээж мөн үүнийг хүмүүсээр дүүргэх төлөвлөгөөг хамтдаа бэлтгэсэн" хэмээн заажээ (*History of the Church,* 6:308). Энэ зөвлөлд Их Эзэн Есүс Христ болон өөр хүмүүс байсан (Мосе 2:26–27; Абрахам 4:26–27-г үзнэ үү).

ӨӨРСДИЙН ДҮР ТӨРХӨӨР

"Бурхан Өөрөө нэгэнтээ одоогийн бидэн шиг байсан бөгөөд эдүгээ өргөмжлөгдсөн хүмүүн Тэрбээр тэнгэрт хаан ширээндээ заларч байгаа билээ! Энэ бол агуу нууц юм. Хэрэв хөшиг өнөөдөр нээгдэг юм аа гэхэд . . . хэрэв та нар Түүнийг өнөөдөр харж чаддаг юм аа гэхэд, Тэрбээр дүр төрх, хэлбэр дүрсээрээ, яг л хүн шиг, өөрсөдтэй чинь адилхан болохыг та нар харах болно."

***Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 40**

26 Тэгээд Бурхан-Бид Өөрсдийнхөө дүр төрхийн дагуу Өөрсөдтэйгөө адилхан хүнийг бүтээж, далайн загас, огторгуйн шувууд, мал адгуус, бүх газар дэлхий, газраар мөлхөгч бүгдийг тэдэнд захируулъя хэмээн айлдав.
27 Тэгээд Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж, Бурханы дүр төрхөөр эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээв.

"Хүн бол Бурханы хүүхэд бөгөөд Түүний тэнгэрлэг дүр төрхөөр бүтээгдэж, тэнгэрлэг зан чанарыг хүлээн авсан ба дэлхий дээрх эцэг эхээс төрсөн нялх хүүхэд цаг нь болоход тэдэнтэй адил хүн болдог шиг селестиел эцэг эхээс төрсөн хүүхдүүд олон сая жилийн туршлагаар дамжуулан Бурхан болох чадвартай байдаг."

Тэргүүн Зөвлөл, "The Origin of Man," *Improvement Era,* 1909 оны 11-р сар, 81; *Ensign,* 2002 оны 2-р сар, 30.

ЗАХИРУУЛЪЯ

"Дэлхий ба үүн дээрх бүх зүйл нь хүмүүний гэр бүлийг тэтгэхийн тулд зохистой ашиглагдах ёстой. Гэсэн хэдий ч, бүх хүн энэ дэлхий ба үүн дээрх зүйлсийн эзэн нь бус, харин даамал нь бөгөөд Бурханы бүтээлүүдэд хэрхэн хандсанаараа Түүний өмнө хариуцлага хүлээх болно."

"Environmental Stewardship and Conservation," mormonnewsroom.org; мөн Сургаал ба Гэрээ 104:13–15-ыг үзнэ үү.

ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮН

"Бүх эрэгтэй, эмэгтэй хүмүүс орчлон ертөнцийн Эцэг, Эхийн дүр төрхөөр бүтээгдсэн бөгөөд үнэхээр Бурханы хөвгүүд, охид юм."

Тэргүүн Зөвлөл, "The Origin of Man," *Improvement Era,* 1909 оны 11-р сар, 78; *Ensign,* 2002 оны 2-р сар, 29.

"Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнх амьдралын тодорхойлолт ба зорилгын салшгүй шинж чанар юм."

"Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг" *2010 оны 10-р сарын Ерөнхий чуулганы материал,* 129.

Редакторын тэмдэглэл: Энэ хуудас бол семинарын сонгосон судрын шүлгийн бүх талыг хамарсан тайлбар биш бөгөөд зөвхөн таны судар судлах судалгааны эхлэх цэг юм.

ҮНЭНИЙ ЭРЭЛД

Би бага байхаасаа Бурхан байдаггүй гэж заалгасаар ирсэн боловч үүнийг өөрөө олж мэдэхээр шийдсэн юм.

Пен Хуа

Өрсөлдөөн ихтэй, шашингүй, Азийн нэгэн оронд төрж өссөнийхөө хувьд би үргэлж л амжилттай хүн болохыг хүсдэг байсан хэдий ч намайг удирдах мөнхийн зарчим эсвэл үнэн гэж байгаагүй юм. Манай оронд “амжилттай” гэдэг ойлголт нь баян, эрх мэдэлтэй байх гэсэн утгатай байсан.

Эцэг эх минь Бурхан байдаггүй гэж надад үргэлж заадаг байлаа. Тэдний бодлоор шашин эсвэл Бурхан гэдэг нь утгагүй зүйл байсан бөгөөд зөвхөн сул дорой хүмүүст зориулагдсан зүйл байв. Олон жилийн турш би өөрийгөө шашингүйн үзэлтэн гэж боддог байсан. Өөрөөсөө өөр хэнд ч бүү итгэ гэж тэд надад заадаг байлаа. Миний хүсэл эрмэлзэл бага наснаас минь шаргуу суралцаж мөн ажиллах гол үндэс болдог байв.

Эцэг, эх хоёр минь надаас их зүйлийг хүсэн хүлээдэг байсан. Тэд намайг дүнгээ үргэлж онц байлгахыг хүсдэг байв. Би муу дүн авсныхаа дараа тэдний урам хугарсан царайг эсвэл нэг нэгэнтэйгээ маргалдахыг харах нь намайг гунигтай болгодог байлаа. Би хичээлийнхээ хажуугаар амралтын өдрүүдэд нэмэлт гэрийн даалгавар хийж байж дундаж дүнгээ A байлгадаг байсан.

Тавьсан зорилгуудаа хүрснийхээ дараа ч гэсэн амьдралд илүү зүйл хийх ёстой юм шиг санагддаг байв. Илүү сайхан зүйл байх ёстой гэдгийг би зүрх сэтгэлийнхээ гүнд мэдэрч байсан.

Нэг өдөр би Бурхан байдаг эсэхийг өөрөө мэдэж авахаар шийдэв. Хэрэв Тэр оршдог бол миний талаар ямар хүсэлтэй байдгийг эсвэл шашин гэж хүний төсөөллөөс бий болсон утгагүй зүйл мөн эсэхийг мэдэхийг хүссэн юм. Би энэ хоёр хариултын алиныг нь ч хүлээн авахаас айхгүй байлаа. Би үнэнийг мэдэхийг л хүссэн.

Энэ үеэр би сагсан бөмбөгийн багийнхаа Тэйлор гэдэг залуутай найзалдаг болсон байв. Нэг өглөө би түүнээс машинаараа сургууль хүргэж өгөхийг хүслээ. Тэр за гэж хэлсэн боловч би түүнтэй хамт семинарт явахын тулд нэг цагийн өмнө босох ёстой болов. Би тэр нь юу байсныг мэдэлгүй дурамжхан гэгч за гэж хэлсэн. Семинар надад таалагдав. Сурсан зүйлээс илүү мэдэрсэн зүйл маань чухал байсан.

Үүнээс хойш удалгүй Тэйлор өөртэй нь хамт сүмд очихыг надаас хүсэв. Эхэндээ сүм бага зэрэг уйтгартай бас хачин санагдаж байсан ч яваандаа цуглааны үеэр мэдэрсэн дулаан, тайван мэдрэмж надад нөлөөлсөн юм.

Гэсэн хэдий ч би энэ сайхан мэдрэмж нь Бурхантай ямар нэг байдлаар хамаатай гэж бодоогүй. Энэ мэдрэмж нь миний дотроос ирээгүй гэдгийг би яаж мэдэх юм бэ? Би өөрөө өөртөө ийм мэдрэмж төрүүлээгүй гэдгээ яаж мэдэх юм бэ?

Энэ тухай олон дахин бодсоны эцэст би хариултаа олохоор Тэйлорын ээж дээр очлоо. Хайж буй хариултаа судруудыг уншиж, залбирснаар авч чадна гэж тэр хэллээ. Би залбирч, ямар ч хариулт хүлээн аваагүй ба шинээр сурч байсан зарлигуудынхаа дагуу амьдрахад ч бэрх байв. Би байнга бухимддаг болов. Би Бурханыг ер бусын байдлаар үзэгдэхийг, эсвэл өөр ямар нэг гайхамшигт үйл явдал болж, Бурхан байдаг гэдгийг батлахыг хүлээж байсан. Би нэг дор баттай гэрчлэл авахыг хүсэж байв. Үнэнийг хэлэхэд, би залбирах тусам амьдралаа илүү тод томруун харж байлаа. Зарлигуудыг дагах тусам би илүү их аз жаргалтай болсон. Судраас унших тусам би илүү их илчлэлт хүлээн авч байсан. Аажмаар, миний гэрчлэл яг л өглөөний мандаж буй нар шиг өсөн нэмэгдсэн юм.

Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болох шийдвэр гаргах гэж хоёр жил болсон. Өмнө нь би ёс суртахууны олон сайн жишиг ба

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДАН БӨРР

зарчмаар амьдардаг байсан ч одоо бол мөнхийн бөгөөд туйлын үнэнийг олсон. Энэ бол Бурхан амьд гэдэг үнэн юм. Би Есүс бол Христ, бидний Аврагч бөгөөд Гэтэлгэгч мөн болохыг гэрчилж байна. Тэнгэрүүд дахин нээгдсэн байгаа. Бурханы бошиглогч өнөөдөр дэлхий дээр амьдардаг. Есүс Христийн Цагаатгал бол бодитой. Бурхан наманчилсан хүмүүсийг үнэхээр өршөөдөг. Би бусад хүний адил ухаантай эсвэл авьяастай биш байж болно. Гэхдээ надад буй мэдлэг нь үнэлж баршгүй юм. ■

Зохиогч нь АНУ-ын Калифорнид амьдардаг.

БИД ИТГЭХИЙГ СОНГОЖ ЧАДНА



“Найдвар, гэрчлэл, итгэл нь зүгээр сууж байгаад олж авдаг зарчмууд биш юм. Тэдгээр нь бидэнд зүгээр хүрээд ирдэггүй. Найдвар нь бидний сонгодог зүйл бөгөөд бид үүнд найдан, үүний төлөө ажиллаж мөн золиослол хийдэг. Бид санаандгүй байж байгаад гэнэт залбирч, гэнэт аравны нэгээ төлдөггүй шигээ санаандгүй байж байгаад гэнэт Аврагчид болон Түүний сайн мэдээнд итгэдэг болчихно гэж байхгүй. Бид бусад зарлигийг дагахыг сонгодог шигээ итгэхийг мөн сонгон үйлддэг.”

Далын ерөнхийлөгчийн зөвлөлийн ахлагч Л.Витни Клэйтон, “Итгэхийг сонго,” *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулганы материал*, 21–22.

СУДРУУД ДАХЬ *гайхалтай* ЗАЛУУ ЭРЭГТЭЙЧҮҮД БА ЭМЭГТЭЙЧҮҮД

Та нар судруудад түүх нь хадгалагдаж буй олон зөв шударга өсвөр үеийнхнээс суралцаж, тэдний жишээг дагаж чадна.

Жизела Гутиер

Их Эзэн Сүмийн өсвөр үеийнхэнд хайртай. Тэр та нарт маш их итгэдэг. Бүх цаг үед Их Эзэн хүчтэй залуу эрэгтэй, эмэгтэйчүүдэд сүнслэгээр нөлөөлж, тэднээр Өөрийн хүмүүсийг удирдуулсан байдаг. Түүнд тэдний бүтээлч сэтгэлгээ, эр зориг ба жинхэнэ чанар хэрэгтэй. Ийм ч байсаар ирсэн бөгөөд цаашдаа ч ийм байх болно.

Залуу баатруудын жишээ судруудад алтан утас мэт хөвөрдөг. Хэдийгээр тэд олон жилийн өмнө амьдарч байсан ч та нар тэдний үлгэр жишээг дагаж, тэдний амьдралаас суралцаж чадна. Тэдний гэр бүлүүдэд асуудлууд байсан. Тэд зөв шударга бус хүмүүсийн дунд амьдарч байсан. Тэд "голиатуудтай" нүүр тулж байсан ч тэдний зориг, дуулгавартай байдал, Есүс Христэд итгэх итгэл тэднийг бэрхшээлээс нь аварч байсан юм. Эдгээр чанар нь та нарт ч бас тусалж чадна.

Абрахам

Ёс бус байдлын эсрэг дуу хоолойгоо өргөсөн Абрахамын шийдэмгий байдал, эр зориг, хүсэл нь гайхалтай байсан. Учир нь түүний аав хиймэл шүтээн шүтдэг байв. Залуу байхдаа тэрээр зөв шударга байдлын төлөө зогссон бөгөөд тахилын ширээн дээр алагдах дөхсөн билээ. (Абрахам 1:2–7-г үзнэ үү.)

Египетийн Иосеф

Том ах нар нь түүнийг боол болгон зарах үед тэрээр 17 настай байсан ч гэсэн Их Эзэн адисалсны дагуу энэ хүнд нөхцөл байдлыг сайн зүйл болгож чадсан юм. Тэр хэзээ ч бууж өгөөгүй учраас ялагдаагүй. Тэр Их Эзэнд итгэсэн хэвээр байсан. Иосеф өөрийн амссан шударга бус явдлыг уучилснаар өөрийнхөө дотоод хүч чадлыг харуулсан. (Эхлэл 37:45-ыг үзнэ үү.)

Давид

Давид өсвөр насандаа хоньчин байсан бөгөөд аавынхаа хонийг хамгаалахын тулд баавгай, арслан зэрэгтэй тулалдсан. Түүний өөртөө итгэлтэй байдал нь хоньчин байснаас болоогүй, харин Тэнгэрлэг Эцэгт итгэлтэй байснаар ирсэн юм. Энэ нь Голиаттай тулалдах үед харагддаг. (1 Самуел 17:32–54-ийг үзнэ үү.)

Естер

Тэр өөрийн хүмүүсийг аврахын тулд өөрийнхөө амьдралыг эрсдэлд оруулахаар шийдэмгий байсан. Естерийн гоо үзэсгэлэн бус, харин түүний сүнслэг хүч чадал түүнийг агуу хүн болгосон. (Естер 4–5-ыг үзнэ үү.)

Даниел

Эргэн тойрны хүмүүс нь дуулгаваргүй байсан ч тэр Их Эзэний эрүүл мэндийн хуулийг

ЗУРАГ: ЧИМЭГЛЭЛИЙГ ЭНДРЮ БОСЛИ



дуулгавартай дагасан. Хаан залбирч болохгүй гэж тушаасан ч тэрээр Тэнгэрлэг Эцэгт хандан залбирсан билээ. Даниел зөв шударга байдал ба Сүнсний өдөөлтөд нээлттэй байдаг учраас Их Эзэн түүнийг зүүд, үзэгдэл тайлах бэлгээр адисалжээ. Тэрээр аюултай цаг мөчид Тэнгэрлэг Эцэгээс хүч чадал, мэргэн ухаан авсан бөгөөд тэнгэрийн хүч түүний мэдэлд байв. (Даниел 1; 6-г үзнэ үү.)

Нифай

Нифай "Би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно" (1 Нифай 3:7-г үзнэ үү) хэмээн хэлэхдээ гайхалтай жишээ үзүүлсэн. Тэр өөрөөс нь шаардагдсан зүйлийг хийх зоригтой байсан. Тэр тав тухтай гэрт амьдардаг байсан уу? Үгүй, тэр аглаг буйдад олон жил амьдарсан. Түүний амьдрал бүтэлтэй байсан уу? Үгүй, ах нар нь түүнд байнга уурлаж, мөн зарим үед түүнийг алахыг оролдож байсан. Түүнд эдгээр зүйл тохиолдсон ч тэр Их Эзэний зарлигийг дуулгавартай дагасан юм.

Хоёр мянган залуу дайчин

Эдгээр залуу эрэгтэйг итгэлтэй эцэг эх нь өсгөсөн бөгөөд тэд ээжүүдийнхээ үгэнд итгэлтэй байснаараа адислагдсан. Тэд сонсож мөн яг таг дуулгавартай байхыг сурсан бөгөөд Тэнгэр дэх Эцэг тусламжтайгаар тэднийг хамгаална гэдэгт эргэлзээгүй юм. (Алма 56:45–48-ыг үзнэ үү.)

Мормон

Эргэн тойрны хүмүүс нь ёс суртахуунгүй байсан ч даруу, цэвэр, мөн ариун байсан учраас Мормоныг 15 настай байхад Их Эзэн түүнд үзэгджээ. Түүнчлэн 15 насандаа Мормон цэргийн удирдагч болсон. Хожим тэрээр судруудыг хадгалахаар итгэмжлэгдсэн юм. (Мормон 1–2-ыг үзнэ үү.)

Иосеф Смит

14 настайдаа аль сүмд нэгдэхээ мэдэхийн тулд судруудыг судалж, залбирсан. Их Эзэн түүнийг Есүс Христийн сайн мэдээг болон Сүмийг сэргээлгэхээр дуудсан. Иосефт олон бэрхшээл хүндрэл байсан хэдий ч энэ үүргээ биелүүлэхэд бүхий л амьдралаа зориулсан билээ. 17 настайд нь тэнгэр элч Моронай түүн дээр айлчлан ирж мөн алтан ялтсуудыг үзүүлсэн. Иосеф Смит бага залуу байхаасаа эргэн тойрныхоо хүмүүст гайхалтай багш, агуу үлгэр жишээ үзүүлэгч байсан юм. (Иосеф Смит–Түүх 1-ийг үзнэ үү.)

Та нарын өдөр

Гайхалтай залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн үе өнгөрсөн гэж үү? Үгүй ээ! Иоелын бошиглол удахгүй биелнэ гэдгийг тэнгэр элч Моронай Иосеф Смитэд хэлсэн:

"Түүний дараа Би Өөрийн Сүнсийг бүх хүн төрөлхтөнд цутгана. Та нарын хөвгүүд, охид эш үзүүлэн, өвгөд чинь зүүд зүүдэлж, залуус чинь үзэгдлүүд үзнэ.

"Тэдгээр өдрүүдэд Би боолууд, шивэгчингүүд дээр ч Өөрийн Сүнсээ цутгана" (Иоел 2:28–29; Иосеф Смит—Түүх 1:41-ийг үзнэ үү). ■

Зохиогч нь Германд амьдардаг семинарын багш байсан бөгөөд 2012 онд нас барсан.

“Ээжийгээ өвчтэй байхад бид түүний төлөө мацаг барьж, залбирсан ч ээж минь нас барсан юм. Бид үүнтэй хэрхэн эвлэрэх вэ?”

Энэ бол чиний амьдрал дахь тун гунигтай үе. “Тэр яагаад эдгэрсэнгүй вэ?” гэх мэт олон асуултдаа баталгаа, хариулт авахыг хүсэх нь хэвийн зүйл юм. Би түүнтэй дахин уулзах уу? Би түүнгүйгээр хэрхэн амьдарч чадах вэ?

Есүс Христийн сайн мэдээ тайтгарал ба хариулт өгдөг. Их Эзэн “гашуудах тэд бүгд адислагдах болно, учир нь тэд тайвшруулагдах болно” (3 Нифай 12:4) хэмээн амласан. Ариун Сүнсийг эрэлхийл, учир нь Тэр бол тайтгаруулагч юм.

Залбирлууд чинь Бурханд хүрсэн эсэх дээр эргэлздэг байж болно. Тэнгэрлэг Эцэг чиний залбирлыг үргэлж сонсдог гэдэг нь баттай зүйл юм. Энэ нь үнэн гэдгийг судрууд болон амьд бошиглогчид бидэнд амладаг. Их Эзэний Иосеф Смитэд хэлсэн зүйл чамд ч бас хамаатай: “чиний залбирлууд хийгээд ах нарын чинь залбирлууд миний сонорт ирсэн” (С ба Г 90:1). Гэхдээ Тэнгэрлэг Эцэг оюун бодолдоо мөнхийн талаас нь харах үзэлтэйгээр бидний залбиралд хариулдаг гэдгийг бид санах хэрэгтэй (Исаиа 55:8–9-ийг үзнэ үү). Тиймээс бид Аврагчийн үлгэр жишээг дагаж адислалуудыг хүсдэг боловч Эцэгийн хүсэл биелэгдэхийг чин сэтгэлээсээ хүсдэг (Лук 22:42-ыг үзнэ үү).

Энэ сорилт хүнд ч гэсэн чиний хувьд өсөж хөгжих боломж байж болно. Ээж чинь эдгэрээгүй ч гэсэн чи Бурханы таалалд итгэлтэй байхад суралцаж чадна. Чи түүнийг амьдраасай гэж хүссэн нь мэдээж. Гэвч энэ мөнх бус амьдралын сорилт нь бүх үед, ялангуяа хүнд цаг үед Бурханд итгэх явдал юм. Хэрэв чи Түүнд итгэвэл, “та нарын сайн сайхны тулд бүх зүйл хамтдаа ажиллах болно” (С ба Г 90:24).

Үхэл бол төлөвлөгөөний нэг хэсэг юм.

Тэнгэрлэг Эцэгийн бидэнд зориулсан аз жаргалын төлөвлөгөөний дагуу Түүний оршихуйд буцаж очихын тулд бид үхэл, амилуулалтыг амсах ёстой. Ингэснээр бид зуурдын байдлаас үхэшгүй байдалд шилжих болно. Чи үхэл бол төлөвлөгөөний нэг хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрч, хэзээ нэгэн өдөр ээжтэйгээ дахин хамт байх болно гэдэгт итгэх хэрэгтэй. Ээж чинь сүнсний дэлхийд байгаа бөгөөд чамайг хүлээж байгаа гэдгийг сана.

Дэвид М., нас 18, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Вестерн Касай

Тэр Сүнсний дэлхийд байгаа

Ээж минь хоёр жилийн өмнө хавдартай гэж оношлогдсон. Түүний өвдөж, зовж байгааг харах нь надад хэцүү байсан бөгөөд би өөрийгөө ямар нэгэн юм хийж чаддаг ч болоосой гэж хүсэж байв. Хэдийгээр ээжийн минь бие сайжирсан ч энэ нь хүндхэн туршлага байсан. Ээж чинь өвчин, зовлонг мэдрэхээргүй газар байгаа. Түүнийг харахгүй байх нь хэцүү ч гэлээ, чи хэзээ ч ганцаараа биш. Ээж чинь чамайг үргэлж хайрлах бөгөөд сэтгэлээр унасан үед чинь Тэнгэрлэг Эцэг чамайг өргөхөд үргэлж бэлэн байх болно. Чамайг хэзээ ч ганцааранг орхихгүй. Есүс Христ дэлхийн өвдөлтийг тэвчсэн учраас Тэр чиний юу мэдэрч, туулж байгааг мэддэг. Миний хийснийг хий: Түүнд ханд, тэгвэл Тэр чиний ачааг хөнгөн болгоно.

Шило В., нас 18, Мексик, Чихуахуа

Эдгээр хариулт нь тусламж, ойлголтуудыг өгөх зорилготой бөгөөд Сүмийн сургаалын албан ёсны мэдэгдэл биш юм.

Чиний гэр бүл эргэн нэгдэх болно
Намайг дөнгөж 12 настай байхад ээж минь нас барсан. Тэр үед би Сүмийн гишүүн байгаагүй. Ээж минь өвчтэй байхад би түүний биеийг сайжраасай гэж маш их залбирсан. Би маш их итгэлтэй байсан ба Бурханд итгэж, түүний эрүүл мэнд сайжирна гэж найдаж байв. Харамсалтай нь түүний бие сайжирсангүй. Ээж минь яагаад намайг өсвөр настай байхад залуугаараа нас барсан юм бол гэж би асуудаг байсан. Би уурлаж, Бурхан байдаг эсэхэд эргэлзэж эхлэв. Одоо би Сүмийн гишүүн болсон учраас авралын төлөвлөгөөг ойлгодог. Тэр намайг хүлээж байгаа ба манай гэр бүл эргэж нэгдэх болно гэдгийг би мэднэ.
Инае Л., нас 19, Бразиль, Минас Жераис

Бэрхшээлүүд бидэнд заадаг
Миний ээж гурван жилийн өмнө нас барсан. Хэрэв чи тусламж хэрэгтэй үедээ Тэнгэрлэг Эцэг ба Аврагчид хандвал тэдэнтэй харилцах харилцаа чинь бэхжих болно. Энэ бэрхшээл хэдий хүнд ч гэсэн бас адислал байж болно гэдгийг чи ойлгоно. Амар амгалан болоод баталгааны төлөө Тэнгэр дэх Эцэгтээ залбир. Чамд зориулсан Их Эзэний төлөвлөгөөнд итгэ. Бидний хаашаа явж байгаа мөн тэнд очихын тулд юу хийх ёстойг Тэнгэрлэг Эцэг мэддэг гэдгийг хүлээн зөвшөөр. Их Эзэн чамайг хайрладаг ба чамайг баяр баясгалантай байгаасай гэж хүсдэг. Бэрхшээлүүд нь бидэнд зааж мөн биднийг хүчтэй болгох зорилготой.
Меган Б., нас 18, Канадын Онтарио

Чи түүнтэй дахин уулзана
Ээжийг минь 17 настай байхад эмээ нас барсан. Түүнийг нас барахаас хэдэн долоо хоногийн өмнө гэр бүл нь түүний төлөө мацаг барьжээ. Тэр бас санваарын адислал авсан байна. Ээжид минь амар амгаланг өгсөн гол зүйл нь дараагийн амьдралд ээжтэйгээ уулзана гэсэн мэдлэг байсан юм. Ээж минь тэр адислалыг авахуйц зохистой амьдрах зорилготой. Би энэ амьдралд түүнтэй дахин хэзээ ч уулзахгүй гэдэгтээ харамсдаг ч уулзах өдрөө тэсэн ядан хүлээж байна.
Кари Р., нас 15, АНУ, Юта



ЧИ ЧАДАХ БҮХНЭЭ ХИЙСЭН
"Өвчтөнүүдийг эдгээх талаар [Их Эзэн] 'Мөн дахин, мөнхүү улиран тохиох дор надад эдгэрэх итгэлтэй *мөн үхэлд оноогдоогүй* тэр нь эдгэрэх болно' хэмээн тодорхой хэлсэн юм (С ба Г 42:48 онцлон тэмдэглэлт нэмэгдсэн). Маш олон тохиолдолд бид 'мөн үхэлд оноогдоогүй' гэсэн хэллэгийг анзаардаггүй. . . .Чин сэтгэлээсээ залбирч, санваарын адислалууд өгөгдсөн ч хайртай хүний чинь бие дээрдэхгүй бол эсвэл нас барвал бүү цөхөр. Чи чадах бүхнээ хийсэн гэдэг мэдлэгээс тайтгарал олж ав. . . . Залбирах, мацаг барих, итгэлээрээ үйлдэх нь *бидний* ашиг тусын төлөө байж болно."

Ахлагч Ланс Б.Викман, 1994- 2010 онд Далын гишүүн, "But If Not," *Лиахона,* 2002 оны 11-р сар, 30–31.

ДАРААГИЙН АСУУЛТ

"Өөрийн жишгийг хүчирхэгжүүлэхийн тулд өөрийнхтэйгээ адил жишгүүдийг дагадаггүй найзуудтай байх хэрэгтэй гэж зарим хүн хэлдэг. Энэ үнэн үү?"

Хариултаа, хэрэв хүсвэл өндөр нягтралтай зургийн хамт liahona.lds.org хаягаар, э-мэйл бичих бол liahona@ldschurch.org хаягаар, эсвэл шуудангаар илгээх бол 3-р хуудсан дээрх хаягаар 2015 оны 11-р сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Э-мэйлдээ эсвэл захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) овог нэр, (2) төрсөн огноо, (3) тойрог эсвэл салбар, (4) гадас эсвэл дүүрэг, (5) таны хариулт ба гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн бичгээр хийсэн өөрийн тань зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой болгохын тулд хянан засварлаж магадгүй.

Хожил авчирсан шийдвэр

Хожиж буй багт тоглох боломж гарч байхад тэр яаж үгүй гэж хэлж чадах билээ?

Марисса Виддисон
Сүмийн сэтгүүлүүд
Бодит түүхээс сэдэвлэв

"Хүндэтгэлийн өдрийг, үүнийг ариунаар хадгалахын тулд сана" (Мозая 13:16).

Миранда урд хаалгаар хурдхан орж ирээд, байшин нь зуны гаднах халуунаас сэрүүхэн байгаад баяртай байлаа. Тэр хөлбөмбөгийн улирлын сүүлчийн тоглолтоо хийгээд хөлөрсөн байсан ба Тийл Турбос багийг хожигдсонд бухимдаж байв. Дахиад л.

Ээж усны сав ба тэмцээний үеэр илүү гарсан ууттай зүссэн жүржийг барьсаар өрөөнд орж ирэв. "Чи маш сайн тоглосон. Хаалгач байна гэдэг бол хэцүү ажил."

Миранда *сайн* тоглосон. Тэр маш олон цохилтыг хааж, ердийнхөөсөө илүү хүчтэй өшиглөсөн. Гэвч түүний багийн бусад охидын ихэнх нь урьд өмнө хэзээ ч хөлбөмбөг тоглож байгаагүй бөгөөд өнөөдрийн тоглолттой нийлээд энэ улирлын бүх тоглолтонд хожигдсон байлаа.

"Би хаая ч гэсэн хождог багт тоглодог байсан ч болоосой" Мирандагийн нүднээс хэдэн дусал нулимс урсаж, түүний цэнхэр ногоон өмсгөл дээр дусав. Түүнийг нүдээ аних үед утас дуугарав.

Ээж утас аваад хэсэг хугацааны дараа "чамтай ярья гэж байна" гэж хэлэв.

"Сайн уу, Миранда юу? Би Чили Кикэрс багийн дасгалжуулагч Том байна. Би өнөөдөр чиний тоглохыг үзсэн. Чи маш сайн байсан."

Мирандагийн зүрх хурдан цохилж эхлэв. Чили Кикэрс бол хөлбөмбөгийн лигийн хамгийн шилдэг баг байв.

"Манай баг ирэх сард бүсийн аваргын тэмцээнд явах гэж байгаа. Чи өнөөдөр маш сайн тоглосон болохоор би чамайг бидэнтэй хамт нөөц хаалгачаар яваасай гэж хүсэж байна."

Мирандагийн зүрх амаар нь гарах дөхөв. Энэ бол хожиж буй багт тоглох түүний боломж байсан юм.

"Би хамт явахыг хүсэж байна!" Миранда ингэж хэлжээ. Тэд зарим тодорхой зүйлийн талаар хэдэн минут ярьсны дараа тэр утсаа тавиад, ээждээ хэлэхээр нөгөө өрөө рүү гүйв. Тэр хоёр хамтдаа гэр бүлийнхээ хуанли дээр бэлтгэл ба тэмцээний өдрүүдийг бичиж эхлэв.

Гэнэт ээж нь бичихээ больж, балных нь үзүүр

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРЭД ТИАРЭ

хуанлийн нэг дөрвөлжин нүдэн дээр эргэлдэж байлаа.

"Яана аа. Миранда, тэмцээнүүд ням гарагт болох юм байна. Үүнийг хар даа." Тэр тэмцээний хуваарийг заагаад, Миранда руу санаа зовсон байдалтай эргэж харав. "Бид яах ёстой гэж чи бодож байна?"

Миранда гуниглаж, боломжит хувилбаруудаа бодох зуураа уруулаа хазаж байв. Хэрэв гуйвал ээж нь түүнийг тоглуулж магадгүй. Гэхдээ түүнийг ням гарагт тоглож, сүмийн цуглаанд сууж чадахгүй гэж бодохоор түүнд таагүй мэдрэмж төрж байв. Ням гараг бол сүмд явж, Тэнгэрлэг Эцэгийг шүтэн биширэх өдөр бөгөөд тэр хөлбөмбөг тоглох юм бол тэдгээр зүйлийг хийж чадахгүй гэдгээ мэдэж байв.

"Би түүн рүү буцаж залгаад, тоглож чадахгүй гэдгээ хэлэх хэрэгтэй байх" гэж Миранда хэлэв. Тэр уйлахгүй байхыг хичээж байв. Хэдийгээр энэ нь зөв сонголт гэдгийг тэр мэдэж байсан ч маш их хүссэн зүйлээсээ татгалзана гэдэг хэцүү байлаа.

"Намайг юу бодож байгааг чи мэдэх үү?" Ээж нь охиноо чанга тэвэрч хэлэв. "Чи бол гайхалтай сайн хүүхэд."

Тэр ням гарагт Миранда Хүүхдийн хэсэгт сууж байхдаа өөрийнхөө гаргасан зөв шийдвэрийнхээ талаар боджээ. Мирандаг утсаар ярьж, ням гарагт хөлбөмбөг тоглож чадахгүй гэж хэлэхэд дасгалжуулагч гайхжээ. Тэр түүний бодлыг өөрчлөхийг хичээсэн боловч Миранда гаргасан шийдвэрээ өөрчилсөнгүй. Миранда Хүүхдийн хэсгийн дуунууд ба хичээлийг сонсож байхдаа инээмсэглэв. Зүрх сэтгэлдээ мэдэрсэн амар тайван мэдрэмж нь түүнд зөв газраа байгаа гэдгийг хэлж байлаа. Эцсийн эцэст тэр жинхэнэ хожил авчирсан шийдвэр гаргасан юм. ■

БАЯР БАЯСГАЛАНГИЙН ӨДӨР

Хүндэтгэлийн өдөр нь баяр баясгалант өдөр байх ёстой гэж судруудад заадаг (Исаиа 58:13-ыг үзнэ үү). Та нар ням гарагт ямар баясгалант зүйл хийж болох вэ? Тэнгэрлэг Эцэгийг шүтэн биширэх ямар сайхан, бүтээлч арга замууд байдаг вэ?

АСУУЛТЫН БУЛАН

Сүмийн гишүүн байхын юунд нь чи хамгийн их дуртай вэ?

Ариун ёслолын үеэр бид Есүс Христийг дурсан санаж, талх, ус хүртдэг нь надад таалагддаг. Талх нь Түүний биеийг, ус нь Түүний цусыг төлөөлдөг. Бид ариун ёслолоос хүртэхдээ нүдээ аниад, Есүсийн бидний төлөө хийсэн бүх зүйлийг бодож чадна.

Ава Ж., нас 9, АНУ, Хойд Каролина

Гэр бүлүүд мөнхөд хамтдаа байж чадна гэдгийг мэдэж авахдаа би дуртай байдаг. (Рэнээ)

Би найзуудтай болж, судруудаас өдөр бүр уншин, сайн мэдээнээс суралцаж чадна. (Ралф)

Рэнээ ба Ралф Э., 9 ба 10 настай, Филиппин, Метро Манила

Би Ариун Сүнсийг мэдрэх дуртай. Би хэлсэн үг, хичээлүүдийг сонсож байхдаа Ариун Сүнсийг маш их мэдэрч чаддаг. Би бас бусдад тусалж байхдаа үүнийг мэдэрдэг.

Кэйли С., 7 настай, АНУ, Виржини

Бид суралцаж байхдаа тоглож, Есүс Христийн талаар илүү ихийг суралцах боломжтой байдаг нь надад таалагддаг. Тэр миний Аврагч учраас би Түүний талаар суралцах дуртай. (Лиз)

Би Есүсийн талаар суралцах дуртай ба Есүс бидэнд хайртай гэдгийг мэднэ. (Лало)

Лиз ба Лало С., 8 ба 6 настай, АНУ, Калифорни



Би Хүүхдийн хэсэгт сууж, дуу дуулах дуртай.

Хэйдэн Х., 5 настай, АНУ, Юта

Би Есүс Христийн талаар суралцаж, Хүүхдийн хэсэгт сууж, найзуудтай болох дуртай.

Катрин В., нас 7, АНУ, Хойд Каролина



Би олон найзтай болж, мөн гишүүн бус найзуудадаа сайн мэдээний талаар заах дуртай. Би Ерөнхий чуулганыг үзэж, бошиглогч, төлөөлөгчдийг сонсох боломжтой байдаг. Гэр бүлийн үдэш маш их хөгжилтэй байдаг. Яагаад гэвэл, бид заримдаа гадаа гарч, зайрмаг авдаг. Янзтай!

Саванна Х., 12 настай, АНУ, Вашингтон

ДАРААГИЙН АСУУЛТ

"Ээж, аав хоёр маань маргалдах үед миний санаа зовж, би гунигтай болдог. Би юу хийж чадах вэ?"

Танд энэ талаар өгөх зөвлөгөө байгаа юу? Хариулт болон зургаа 2015 оны 10-р сарын 31-ний дотор бидэнд явуулаарай. Бидний хаягийг 3-р хуудаснаас олоорой эсвэл liahona@ldschurch.org хаягаар бидэн рүү э-мэйл бич. (Гарчган дээр "Question Corner" гэж бичээрэй.) Эцэг, эхийнхээ зөвшөөрлийг явуулахаа битгий мартаарай!

Залбирлын хариу нь тусламж, ойлголт авахад хэрэгтэй байдаг ч Сүмийн сургаалыг зарладаггүй.

БИДНИЙ ХУУДАС

Номлогч эгч нар, Абрил С., нас 9, Мексик

БУРХАН ТАНДАА ТАЛАРХЪЯ

Гэрлийг өгсөнд Бурхан Тандаа талархъя
Энэ нь өдөр мөн шөнө гэрэлтдэг.
Моддыг өгсөнд Бурхан Тандаа талархъя
Тэдгээр нь хүчит салхийг намжаадаг.
Би дүрсэлж чадахгүй өөр олон зүйлийн
төлөө Бурхан Тандаа талархъя,
Гэвч Та миний амьдралыг бүтээсэн гэдгийг
би зүрхнийхээ угаас мэднэ.
Миний амьдрал хэдий сайхан биш ч гэсэн,
Би амьд байгаа цагт сэтгэл хангалуун
байх болно.

Ниша Ж., нас 10, Бүгд Найрамдах Палау улс

Аргентины нэг тойргийн дөрвөн хөвгүүн бүгдээрээ нэг өдөр баптисм хүртжээ. Тэдний бишоп (дунд нь) тэдэнтэй хамт зогсож байна.

Миний ах болон гэр бүлийн минь найз номлолын дуудлагаа хүлээн авсан. Бид Германы Фрайбэргийн ариун сүм рүү найман цаг явж ирсэн ба тэд ариун сүмийн хишгээ хүртсэн юм.

Бид тэнд тав хоног байсан бөгөөд манай гэр бүл ариун сүмийн ажил олныг хийсэн. Ариун сүмийн ойролцоо гэр бүлүүдэд зориулсан дотуур байр байдаг. Би бусад хүүхэдтэй хамт цэцэрлэгчид тусалж, тэр бидэнд зайрмаг өгсөн. Бид маш хөгжилтэй байсан.

Би ирэх жил 12 настай болж, ариун сүмд баптисм гүйцэтгэх боломжтой болохоо тэсэн ядан хүлээж байна.

Алика С., нас 11, Словак

Петр, Корнел, тэнгэр элч гурав

Эрин Сандэрсон

Есүсийг амилж, тэнгэрт буцсаны дараа Петр болон бусад төлөөлөгч олон газарт зөвхөн еврейчүүдэд номложээ.

Корнел нь Ромын цэрэг байсан. Тэр Бурханд итгэлтэй байсан ч еврей биш байв. Тэнгэр элч түүнд үзэгдэж, Петрийг авчрууд гэж хэлжээ. Корнел Петрийг олохоор хүмүүсээ явуулсан бөгөөд Ариун Сүнс Петрт тэдэнтэй хамт яв гэж хэлжээ.

Корнелийн гэрт цугларсан хүмүүсийн олонд нь Петр заав. Түүнийг тэдэнд Есүс Христийн сайн мэдээний тухай хэлэхэд тэд Ариун Сүнсийг мэдэрч, энэ нь үнэн гэдгийг мэджээ. Петрийг еврей биш хүмүүст номлосон гэдгийг мэдээд, найзууд нь цочирджээ. Гэвч Петр тэдэнд Есүс Христийн сайн мэдээ бүх хүнд зориулагдсан гэдгийг хэлэв. (Үйлс 10:1–48; 11:1–18-ыг үзнэ үү.) ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЗҮҮН ГАР ТАЛД: ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КРЭГ СТЭПЛИ; БАРУУН: ХЭНРИЧ ХОФМАНЫ *CHRIST'S IMAGE*, ЗУРГИЙН ХЭСГЭЭС, COURTESY OF C. ХАРРИСОН КОНРОЙ КОМПАНИЙН ЗӨВШӨӨРЛӨӨР ХЭВЛЭВ.

ХУВААЛЦАХАД БЭЛД!

Сайн номлогч болох нэг арга зам бол Есүстэй илүү адил байхыг хичээх явдал юм. Нэрийн тэмдгүүдийг хайчлаад, хөгжүүлэхийг хүсэж буй зан чанараа дотор нь бич. Та нар "Ахлагч Нинжин сэтгэл" эсвэл "Талархал эгч" байхаар ажиллаж болно. Та нарт зорилгыг тань сануулж байх газарт нэрийн тэмдгээ тавь.

Ахлагч

Эгч

Эгч

Ахлагч

ГЭР БҮЛД ӨРНӨДӨГ ЯРИА

Матай 28:19–20-ийг унш. Бид сайн мэдээг хэрхэн хүн бүртэй хуваалцаж болох талаар бод. Найзууд эсвэл хөршүүд чинь сайн мэдээний талаар асууж болох асуултуудыг бод. Та нар гэр бүлтэйгээ хамт үг асуултуудыг асууж мөн хариулах дадлага хийж болно.

Дуулал: Номлолын ажлын тухай нэг дуулал сонго, жишээ нь, "Бид Түүний үнэнийг дэлхийд авчирна" (*Children's Songbook,* 172).

Судар: Матай 28:19–20

Видео бичлэг: Biblevideos.org сайтаас "Сайн мэдээг харийнханд номлох талаар Петрийн авсан илчлэлт"-ийг үз.

СУДРЫН ЗӨВЛӨГӨӨ

Бид суралцаж буй зүйлээ хуваалцсанаараа судруудыг илүү сайн ойлгож чадна. Судрын нэг шүлгийг гэр бүлээрээ уншаад, хүнд үг, хэллэгүүд нь ямар утгатай, судрууд нь та нарын хувьд ямар учир утгатай болохыг, мөн үүнийг амьдралдаа хэрэгжүүлэх арга замуудын талаар ярилц.

ИЛҮҮ ИХИЙГ СУР

Петр дагалдагчаар дуудагдахаасаа өмнө Симон гэдэг нэрээр танигдсан загасчин байсан. Есүс түүнд Петр гэдэг нэр өгсөн юм. Энэ нь "чулуу" эсвэл "хад" гэсэн утгатай. Есүсийг дэлхийгээс явсны дараа Петр ахмад төлөөлөгч байсан бөгөөд Сүмийг удирдаж байсан. Тэр санваарын түлхүүрүүдийг буюу эрх мэдлийг атгаж байсан.

Тусламж авсан нь

Шөнө дунд өнгөрч байсан ч Тэйт ярилцах цаг болсон гэдгийг мэдэж байв.

Кимберли Рейд
Бодит түүхээс сэдэвлэв

*"Тэнгэрлэг Эцэг минь би одоо залбирч байна, намайг өдөр бүр удирдаж мөн хамгаалаач" (*Children's Songbook, *19).*

Тэйт харанхуйд сэрүүн хэвтэж, нулимстай нүдээ цавчилж байв. Тэр тусламж хүсэн залбирсан боловч бараан хар үүл түүний дээр байж, Сүнсийг холдуулсан мэт санагдаж байлаа.

"Би тэр телевизийн муухай нэвтрүүлгийг мартаж чадахгүй бол яах вэ?" гэж тэр санаа зовов.

Хэдэн өдрийн өмнө тэр гэрийн даалгавраа эрт дуусгаад, зурагтаа асаажээ. Гэвч тэр *тийм* зүйл гарч байна гэж бодоогүй байсан юм. Тэйт маш их цочирдсон учраас зурагтаа тэр даруй унтраахаа мартсан байв.

Энэ нь нэг ослын тухай байжээ. Тэр иим зүйл үзье гэж бодоогүй боловч үүнийг одоо мартаж чадахгүй байлаа. Заримдаа энэ нь хичээлийн үеэр, оройн хоолон дээр, бүр сүмийн цуглааны дундуур түүний толгойд орж ирж байв. Иим үед ээж, аав хоёр нь түүний бодлыг мэдэж чадахгүйд тэр баяртай байлаа. Тэйтийн эцэг эх нь түүнд хувцасгүй хүмүүсийн зургийг харж болохгүй гэж заасан. Мөн тэд түүнийг хүчирхийлэл харуулсан телевизийн нэвтрүүлэг, кино, видео тоглоомоос зайлсхийхийг хүсдгийг тэр мэдэж байв.

"Би яагаад гэдгийг одоо мэдлээ" гэж Тэйт өөртөө бувтнан хэлэв.

Тэйт орноосоо босоод, дахин өвдөг сөгдлөө. Тэр юу хийж чадах вэ?

"Тэнгэрлэг Эцэг" гэж Тэйт шивнэв. "Харсан зүйлээ мартахад минь туслаач." Тэр нулимсаа арчиж, сонслоо. Түүний зүрх хурдан цохилж байв. Тэр Ариун Сүнсний өдөөлт мэдрэгдэж байна гэж бодсон боловч энэ нь түүний хүссэн хариулт биш байжээ.

Тэр эцэг эхдээ хэлэх хэрэгтэй байв.

"Яагаад?" гэж Тэйт бодлоо. Тэр шөнө дунд бяцхан хүүхэд шиг аав, ээжийнхээ өрөөнд орохоос ичиж байлаа. Тэгээд бас тэдэнд *хэлэх* гэж үү? Тэр дахиад л ичиж мөн айж эхлэв.

Тэгтэл түүнд Тэнгэрлэг Эцэг түүнийг аз жаргалтай байгаасай гэж хүсдэг гэсэн нэгэн бодол төрсөн байна. Тэнгэрлэг Эцэг түүнийг Сүнсийг дахин мэдэрч, сайн зүйлүүд бодож, мөн гэр бүлийнхэнтэйгээ шударга байгаасай гэж хүсдэг. Ялангуяа Тэр Тэйтийг хэдэн сарын дараа 12 нас хүрэхдээ зохистой Аароны санваартан болоосой гэж хүсдэг. Тэйт харсан зүйлээ хэлэхгүй нууцлаад байвал аз жаргалгүй хэвээр байх болно гэдгээ ойлгожээ.

Тэйт өөрт нь тусламж хэрэгтэй гэдгийг мэдсэн бөгөөд Ариун Сүнс тусламж хаанаас авахыг түүнд хэлсэн юм.

Тэйт орныхоо дэргэдэх цагийг харав. Шөнийн нэг цаг болох гэж байлаа. Тэр босоод аав, ээжийнхээ өрөө рүү орохоор харанхуйд алхлаа. Сандарсан байдалтайгаар тэр тэдний өрөөний хаалгыг тогшжээ.

"Ээж ээ, аав аа"

"Тэйт чи юу?" гэх ээжийнх нь нойрмог дуу гарлаа.

"Ямар нэг юм болоо юу?" гэж аав нь асуув.

"Тийм" гэж Тэйт хэллээ. "Ярилцаж болох уу? Би адислал авч болох уу?"

Аав нь орныхоо хажуугийн гэрлийг асаагаад, Тэйтийг орж ирэхийг хүсэв. Олон өдөр өнгөрсний дараа Тэйт одоо л нэг дулаахан мэдрэмж ба найдвар, гэрлийг мэдэрсэн юм. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ МАРК В.РОБИНСОН

Үгүй байлгүй дээ! Одоо яах вэ?

Энэ зүйл гэр, сургууль, эсвэл найзын гэр гэх мэт ямар ч газар тохиолдож болно. Гэв гэнэт сайн биш гэж *мэддэг* зүйл чинь утас, телевиз, компьютер, эсвэл видео тоглоом, эсвэл ном, сэтгүүл дээр гарч ирнэ. *Энэ үед* та нар сайхан мэдрэмжтэй байхын тулд юу хийж чадах вэ?



Үүнээс хол бай. Үүнийг унтраа. Үүнийг хол байлга. Үүнийг тархины шорон гэж үз. Энэ нь үнэндээ тийм зүйл мөн.

Ээждээ юм уу аавдаа хэл. Аав, ээж чинь чамайг хамгийн сайн мэддэг бөгөөд тэд чамайг аюулгүй бас аз жаргалтай байхад туслахыг хүсдэг. Бүү ичиж зов. Та нарт тохиолдсон зүйл хэзээ нэгэн цагт хүн бүрд тохиолддог.

Юу ч хийхгүй байж болохгүй. Ямар нэг сайн зүйлийг үз эсвэл унш. Идэвхтэй зүйл хий. Сайн үйл хий. Гэр бүлтэйгээ эсвэл найзуудтайгаа хамт бай.

Ярилцаж бай. Та нарт таагүй сэтгэгдэл төрүүлсэн ямар нэг зүйл харсан бол үүнийг ээждээ эсвэл аавдаа хэлэх нь тустай байж болно. Аав, ээжүүд ёс бус зүйл үзэхээс өөрсдийгөө хамгаалах төлөвлөгөө гаргахад чинь тусалж чадна. Хэрэв та нарт урхинд орсон юм шиг санагдаж, санаа зовон, эсвэл ёс бус зүйлийг дахин үзэх хүсэл төрж байвал энэ талаар бас хэлэх хэрэгтэй.

Хэн гэдгээ сана. Муу зүйл үзсэнээрээ та нар муу хүн болсон гэсэн үг биш. Чи бол Бурханы хүүхэд, Тэр чамд хайртай бөгөөд аюулгүй, аз жаргалтай байхад чинь туслахыг хүсдэг.

Бүү ай. Өөрийгөө агаарын бөмбөлөг хөөргөөд, араас нь харж байгаагаар төсөөл. Тайвшрахыг хичээгээд, үзсэн зүйлээ оюун бодлоосоо гарга. Одоо ариун сүм, өөрийн гэр бүл эсвэл харах дуртай өөр ямар нэг зүйлийг дотроо бод.



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ШОНА Ж. К.ТЭННИ

Полын хулуу

Рэй Голдрап

Бодит түүхээс сэдэвлэв

Пол аавдаа ногоо тарихад нь тусалж байхдаа Эрик ахыгаа бас энд байж, тусалдаг ч болоосой гэж хүсжээ. Гэвч Эрик хол газар номлолд явсан ажээ.

“Би хэзээ ч Эрик шиг том болохгүй байх. Би яавал түүн шиг номлолд явж чадах бол?” хэмээн Полыг асуухад

Аав нь “Санаа зовсны хэрэггүй ээ, Чи том болно” гэлээ.

ЗУРГИЙГ ЭЙМИ ВАММЕР

Полд аав нь хулууны хэсэг үр өгөв. Тэгээд тэрээр Полд үрээ суулгахад нь тусалжээ.

"Энэ жижиг үрнүүд том хулуу болж ургах уу?" гэж Пол асуув.

Аав нь түүнд "Тэднийг сайн арчилж тордох юм бол" гэж хэлжээ.

Пол өдөр бүр ногооны талбайгаа харахаар гардаг байлаа. Талбайгаа усалсаар, тун удалгүй бяцхан үрслүүр гарч эхлэв. Навч нахиа нь ч томорчээ. Пол зэрлэгийг нь болгоомжтой зулгаав.

Намар болоход түүний хулуунууд ургасан байлаа. Тэдгээр нь том улбар шар хулуунууд байв.

Пол аавдаа үзүүлэв. Аав нь түүнд “Хулуунуудаа сайн арчилж тордсон байна шүү!” гэж хэлжээ.

“Тийм ээ! Би өөртөө ч гэсэн анхаарал тавьж, том болох болно” гээд Пол инээмсэглэн, “Тэгээд би том болоод, Эрик шиг номлолд явна” гэж хэлэв. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

Хулууны талбай

Пол хэдэн хулуу ургуулсан бэ? Та нар бусад нуусан зүйлийг олж чадах уу? ■

Саяд нэг

Үг: Жан Пинборөү
Ая: Майкл Ф. Мүүди



Жан Пинборөү болон Майкл Ф.Мүүдигийн бүтээл. Бүх эрх хамгаалагдсан.
Энэ дууг ашгийн бус зорилгоор сүм болон гэрт ашиглаж болно.
Энэхүү санамж хуулбар бүрд байх ёстой.

Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг
Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

АЮУЛГҮЙ ГАЗАРТ ХҮРЭХ ЗАМ

Аливаа сэрэмжлүүлгийг Их Эзэнээс ирсэн гэдгийг мэдэх нэг арга зам бол эрх мэдэл олгогдсон гэрчүүдийн хууль юм.

Биднийг аюулгүй газар тийш удирдах гэсэн Аврагчийн хүсэл хязгааргүй мэт байдаг. Тэрээр биднэнд замыг үзүүлэхдээ хувиршгүй байдаг. Тэр нэгээс илүү арга замаар дууддаг бөгөөд ингэснээр энэ нь хүлээн авах хүсэлтэй хүмүүст хүрдэг. Эдгээр арга замын нэг нь хүмүүс Бурханы бошиглогчтой байх зохистой байгаа үед Өөрийн бошиглогчийн амаар захиас илгээх явдал юм. Тэдгээр эрх мэдэлтэй үйлчлэгчид нь үргэлж хүмүүсийг сэрэмжлүүлэх, тэдэнд аюулгүй газарт хүрэх замыг заах үүрэгтэй байдаг.

1838 оны намар АНУ-ын Миссурийн хойд хэсэгт хурцадмал байдал үүсээд байхад, бошиглогч Иосеф Смит бүх гишүүнийг хамгаалагдахын тулд Фар Вестэд цугларах анхааруулга өгчээ. Олон хүн алслагдмал фермүүдэд эсвэл тархан суурьшсан газруудад байжээ. Тэрээр Хаунс Милл хэмээх суурин үүсгэн байгуулсан Иаков Хаунд тусгайлан зөвлөсөн юм. Тухайн үеийн баримт бичигт дараах зүйл тэмдэглэгджээ: “Иосеф ах тээрмийг эзэмшиж байсан Хаунаар дамжуулан тэнд амьдарч байсан ах нарт Фар Вестэд ир гэж хэлүүлсэн боловч ноён Хаун уг захиасыг дамжуулаагүй байна” (Philo Dibble, in “Early Scenes in Church History,” in *Four Faith Promoting Classics* [1968], 90). Хожим бошиглогч Иосеф Смит өөрийнхөө түүхэнд ингэж тэмдэглэсэн байдаг: “Энэ өдрийг хүртэл зөвлөгөөг дагадаг хүмүүсийг аврах хүчийг Бурхан надад өгсөн. Миний зөвлөгөөг дагасан хүмүүсээс нэг ч хүн алагдаагүй” (*History of the Church,* 5:137). Дараа нь бошиглогч хүмүүс түүний зөвлөгөөг хүлээн авч, дагасан бол Хаунс Миллд байсан олон гэмгүй хүний амийг аварч болох байсан талаар бичжээ.

Өнөө үед бидэнд нүгэл, уй гашуугаас хамгаалах хамгаалалтыг хаанаас олж болох талаар сэрэмжлүүлсэн. Эдгээр сэрэмжлүүлэг давтагдсан байдаг нь тэдгээрийг таних нэг түлхүүр болдог. Жишээлбэл, бошиглогч маань Ерөнхий чуулган дээр нэгээс дээш удаа өмнөх бошиглогчоос эш татаж, хоёр дахь эсвэл бүр гурав дахь гэрч болохыг та нар сонсож байсан. Төлөөлөгч Паул “Хоёр буюу гурван гэрчийн амаар үг бүр батлагдах болно” (2 Коринт 13:1) хэмээн бичжээ. Аливаа сэрэмжлүүлэг Их Эзэнээс ирсэн гэдгийг мэдэх нэг арга зам бол эрх мэдэл олгогдсон гэрчүүдийн хууль юм. Бошиглогчдын үгс давтагдах үед бид үүнд анхаарлаа хандуулж, ийм адислагдсан цаг үед амьдарч байгаадаа талархах талархлаар зүрх сэтгэл маань дүүрэн байх ёстой. . . .

Тэнгэрлэг Эцэг маань бидэнд хайртай. Тэрээр Хайртай Хүүгээ бидний Аврагч болгохоор илгээсэн. Бидний мөнх бус байдал аюулд орно гэдгийг, тэр дундаа чөтгөрийн уруу таталтууд хамгийн хүнд аюулд орно гэдгийг Тэр мэдэж байсан. Тийм учраас Аврагч санваарын түлхүүрүүдийг өгсөн бөгөөд сонсох чихтэй, дуулгавартай дагах итгэлтэй хүмүүс аюулгүй газруудад очиж чадна. ■

“Finding Safety in Counsel,” Лиахона, *1997 оны 7-р сар, 23–25-аас авав.*

ОЙЛГОЛТ

Бид бие биедээ сайхан үгсийг чин сэтгэлээсээ хэр ойр ойрхон хэлдэг вэ?

“Бид цөөн хэдэн асуултаар өөрсдийгөө шалгаж болох юм . . . 1. Би хэзээ хамгийн сүүлд, ганцаараа байхдаа, эсвэл үр хүүхдүүдийнхээ хажууд ханийгаа чин сэтгэлээсээ магтсан бэ? 2. Би хэзээ хамгийн сүүлд түүнд талархаж, хайраа илэрхийлж, эсвэл итгэлтэй байдлаар түүний төлөө залбирсан бэ? 3. Би хэзээ хамгийн сүүлд түүнийг гомдоож болох үгийг хэлэхээсээ өмнө өөрийгөө болиулж чадсан бэ? 4. Би хэзээ хамгийн сүүлд түүнээс “хэрэв чи тэгсэн байсан бол” эсвэл “хэрвээ чи тэгээгүй байсан бол” гэсэн үгийг хэрэглэлгүй, уучлалт гуйж, даруухнаар өршөөл хүссэн бэ? 5. Би хэзээ, хамгийн сүүлд өөрийн “зөв” гэдгийг нотлохын оронд аз жаргалтай байхыг сонгосон бэ?”

Линда К.Бөртон, Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч, “Хамтдаа өсөж хөгжицгөөе,” *Лиахона,* 2015 оны 5-р сар, 31.

Энэ дугаарт

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Үнэн хүсэлтэй АМЬДРАХ НЬ

Шийдвэрүүдийнхээ цаад талын “яагаад” гэдэг шалтгааныг ойлгох нь зөв зүйлсийг зөв шалтгаанаар хийхэд та нарт туслах болно. Үнэн хүсэлтэй амьдарч сур!

44-р хуудас

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ



62-р хуудас

СУДРУУД ДАХЬ гайхалтай өсвөр үеийнхэн

Судруудад гардаг өсвөр үеийнхний тэмцэл тулаан та нарынхаас өөр байж болох ч та нар өөрсдөдөө тулгарч байгаа саад бэрхшээлээ даван туулахын тулд тэдний эр зориг, итгэл, дуулгавартай байдлын үлгэр жишээг дагаж болно.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Тусламж авсан нь

Тэйт телевизээр харсан зүйлээ бодохгүй байж чадаагүй учраас юу хийхээ мэдэхийн тулд Тэнгэрлэг Эцэгт хандан залбирчээ.

72-р хуудас

MONGOLIAN
4 02125 70363 5

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ